

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-64
1. “Онпре” ХХК-ийн ашиглалтын лицензийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох	8-35
2. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	36-38
3. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох	38-54
4. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	54-55
5. “Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаар Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсох	55-63
6. “Ажлын хэгсийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	64-64

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
04 дүгээр сарын 16-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 56.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 26 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Б.Пунсалмаа, Д.Үүрийнтуяа.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар хэлэлцэх асуудлын 1 дүгээрт байгаа Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг хэлэлцэх асуудлаас 7 хоног хойшлуулах тухай Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаас ирүүлсэн хүсэлтийг танилцуулан, хэлэлцэх асуудлын дарааллаас хасаж, хойшлуулах горимын санал гаргав.

С.Ганбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Замира, Д.Энхтуяа, Л.Мөнхбаясгалан нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 76.9 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулан хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хойшлуулах горимын санал гаргав.

С.Ганбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын саналууд дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын 1, 2 дугаарт байсан асуудлыг хойшлуулахаар тогтов./14:35/

Нэг. “Онпре” ХХК-ийн ашиглалтын лицензийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн

бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, мөн газрын Эрдэс баялгийн татварын хэлтсийн дарга С.Мөнхбаяр, “Эрдэнэс Оюу толгой” ХХК-ийн Геологи, уул уурхайн хэлтсийн менежер Л.Өнөрбаатар, мөн компанийн Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Наранпүрэв нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут хэлэлцэж буй асуудлын танилцуулга материал хурал эхлэхэд Улсын Их Хурлын гишүүдэд тараагдсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүдэд танилцах хугацаа байгаагүй тул уг асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Ц.Туваан, Х.Жангабыл нар үг хэлэв.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Горимын санал дэмжигдээгүй тул “Онтре” ХХК-ийн ашиглалтын лицензийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг хэлэлцэж эхлэв.

“Онтре” ХХК-ийн ашиглалтын лицензийн талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Х.Жангабыл, Л.Мөнхбаясгалан, Д.Жаргалсайхан, М.Бадамсүрэн, П.Мөнхтулга, О.Батнайрамдал, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, “Эрдэнэс Оюу толгой” ХХК-ийн Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Наранпүрэв нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, С.Замира, Л.Мөнхбаясгалан, М.Бадамсүрэн Г.Очирбат, П.Мөнхтулга, О.Батнайрамдал, С.Ганбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Онтре” ХХК-ийн ашиглалтын лицензийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Ганбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 12

Бүгд: 19

36.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдсангүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 14

Бүгд: 19

26.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Б.Тулга, Д.Батбаяр нар үг хэлэв.

Уг асуудлыг 16 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Г.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, М.Бадамсүрэн, П.Мөнхтулга, Д.Жаргалсайхан, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, С.Замира, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, Л.Мөнхбаясгалан, С.Ганбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Ганбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 10

Бүгд: 19

47.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдсангүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Ганзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Ганзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 10

Бүгд: 19

47.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Илээр санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл, саатал гарсан зэрэг санал хураалтын систем ажиллахгүй болсон тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулна.” гэж заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

С.Ганбаатар: Дээрх батлах санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Ганбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаар Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Автотээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Э.Мөнхнасан, Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, “Ди Ди Эй Жи” ХХК-ийн захирал Д.Ганзаяа, мөн компанийн төслийн инженер С.Балжинням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны референт Г.Баярмаа нар байлцав.

“Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаар Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Ди Ди Эй Жи” ХХК-ийн захирал Д.Ганзаяа нар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, Д.Батлут, Д.Жаргалсайхан, Б.Тулга нарын тавьсан асуултад Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд “Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаарх Зам, тээврийн яамны мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Ганбаатар: “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 8

Бүгд: 20

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 31 минут үргэлжилж, 23 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 87.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН

БОДЛОГЫН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН

ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим, 14 цаг 26 минут

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Эрхэм гишүүдийн ирц бүрдсэн байна. Ингээд та бүхний өнөөдрийн хуралдааныхаа ирцийг би та бүхэнд танилцуулъя. Ингээд Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн ирсэн байна. Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна. Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна. Хажикберийн Жангабыл гишүүн ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна. Буяагийн Тулга гишүүн ирсэн байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Ингээд нийтдээ 56,5 хувийн ирцтэйгээр өнөөдрийн хуралдааны нээснийг мэдэгдье.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн явцын талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох.

2.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Саяын мега төсөлтэй холбогдуулаад.

3.Онтре компанийн ашиглалтын лицензийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох.

4.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээлэл сонсох.

5.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

6.Эрдэнэт машин цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаар Зам, тээврийн сайдын мэдээлэл сонсох.

7.“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Энэ усных шүү. Ийм 7 хэлэлцэх асуудал орж ирсэн байна.

Ингээд гишүүдэд мэдээлэл өгөхөд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн явцын талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох. Энэ асуудлыг Гантөмөр сайд яг Евразийн хэлэлцээрүүдийг танилцуулах ажил Төсвийн байнгын хороо болон бусад холбогдох Байнгын хороод дээр яг эд яригдаж байна. Давхардаж байна хойшлуулж өгөөч гэсэн ийм аргагүй

хүсэлтийг гаргасан учраас гишүүдээс би 1 дүгээр асуудал болон 2 дугаар асуудал болох “Ажлын ажлын хэсэг байгуулах тухай” энэ 2 асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр ийм горимын санал гаргаж байгааг та бүхэн дэмжиж өгнө үү гэсэн ийм санал байна.

1 дүгээр асуудал дээр хойшлуулъя гэсэн горимын санал гаргаж байна. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Замира гишүүн протоколд бас дэмжиж байгаагаа илэрхийллээ. Энхтуяа гишүүн, Мөнхбаясгалан гишүүн бас дэмжсэн байна. Ингээд 9 гишүүний саналаар дэмжсэн учраас Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг дараагийн хуралдаанаар сонсохоор боллоо.

Үүнтэй холбогдуулаад 2-т нь “Ажлын хэсэг байгуулах тухай” Үүрийнтуяа гишүүн уг нь санаачилж байсан. Энэ ажлын хэсэг байгуулах тухай байнгын хорооны тогтоолын төслийг бас хойшлуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ бол соёлын саяын ярихтай холбоотой байсан саналын томъёолол. Ингээд 9 гишүүний саналаар дэмжигдлээ.

Ингээд Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээлэл мега төслүүд ер нь хэрэгжилт ямар явцтай явж байна. Юу болов гэдэг талаар дараагийн хуралдаанаар мэдээлэл сонсож, нэлээн дэлгэрэнгүй асуулт асууж, гишүүд бас ажлын хэсэг байгуулна.

Ингээд хэлэлцэх асуудлынхаа гуравдугаарх асуудалдаа оръё.

“Онтре” ХХК-ийн ашиглалтын лицензийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсьё.

Ингээд ажлын хэсгийг орж ирэхийг урьж байна. Ажлын хэсгийг оруулж ирье. Ажлын хэсгийг танилцуулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ажлын хэсгийнхнийг би танилцуулъя.

Монголын ард түмний яг анхаарлын төвд байгаа Оюутолгой дээр цэвэр далаараа тавиулж, Монголын ард түмнийг маш том өрөнд оруулж, дампуурлын байдалтай байгаа. Оюутолгойн асуудлыг хэрхэн засаж залруулах вэ гэдгийн нэг зүйл бол “Онтре” ашиглалтын компанийн ашиглалтын лицензийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг Монголын ард түмэн хүлээж байгаа.

Ингээд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан орж ирсэн байгаа гэж би итгэж байна. Орж ирээд энэ чинь мэдээллээ тавьчихаад гарах ёстой шүү дээ. Мэдээллээ тавих ёстой шүү дээ. Сая бол Дэлгэрсайхан гишүүн биеэрээ хүрч ирээд, асуудлуудаа бүгдийг нь танилцуулчихаад сая гарлаа. Энэ гишүүд их хүндлэл гуйгаад байгаадаа биш шүү дээ. Монголын ард түмнийг, сонгогчдоо төлөөлж байна гэж бодож байна.

Дээр нь нэмээд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныханд хариуцлага тооцно. Тогтоолоор хариуцлага тооцно шүү. Яагаад гэвэл материал өнөө өглөө орж ирсэн. 2 хоногийн өмнө тараагдах ёстой. Удаа дараа энэ асуудал гарч байгаа шүү.

Гишүүд дараагийн ээлжид тэр холбогдох газар, хэлтсийн дарга нар дээр нь бас саналууд гаргана биз дээ. Одоо ингээд л дандаа аргадаад л, гуйгаад л, царайчлаад л яваад байдаг юм биш шүү дээ. Энэ чинь төрийн ажил шүү дээ.

Энэ дээр горимын санал Батлут гишүүн гаргая гэж байна. Горимын санал гаргана уу.

Д.Батлут: Чухал асуудал хэлэлцэх гэж байгаа. Оюутолгой холбоотой асуудал үндсэндээ Монгол Улсын улс төрийн сүүлийн 20 орчим жил хамааралтай болоод л байнга л асуудлыг ярьдаг. Асуудлууд үүсээд байгаа юм. Тэгээд энэ асуудалтай холбоотой бас маш чухал асуудал энэ “Онтре” гэж компанитай холбоотой асуудлыг хэлэлцэхэд 1 дүгээрт нь салбарын сайд өөрөө байх хэрэгтэй. Хамгийн чухал асуудал учраас. 2 дугаарт нь материал өнөөдөр дөнгөж хуралдаан дээр тараагдаж байгаа. Гишүүд энэ материалтай чинь бас танилцаж, өөр өөрсдийнхөө дүгнэлтүүдийг хийх, цаашлаад ямар асуудлыг яах ёстой вэ гэдэг дээр байр сууриа илэрхийлэх ч зайлшгүй шаардлагатай гэж харж байгаа. Тэгээд ийм хариуцлагагүй хандаж байгаа асуудал дээр Байнгын хороо дарга бас анхаарлаа хандуулж, тодорхой бас одоо арга хэмжээ авах хэрэгтэй байна. Тэгээд сайд нь ч байхгүй, материал ингэж орой тараагдаж байгаа энэ асуудлыг ер нь хойшлуулах нь зүйтэй гэж үзэж байгаа. Бүгдээрээ нэг л зарчим дээр тохирох ёстой. Байнгын хорооны дарга өөрөө Байнгын хорооны хурал дээр сайд асуудлаа оруулдаг, материал 2 хоногийн өмнө тараагддаг. Гишүүдийг мэдэх, таних, бас асуудалд өөр өөрсдийн өнцгөөс хандах боломжийг нь гаргаж өгөх ёстой. Ингээд л асуудал явдаг байх ёстой шүү дээ. Тэгэхгүй дөнгөж материал тараагдахад бид энэ дээр юу ярьж, юу асуух ёстой юм. Ийм хуумгай хандсанаас болоод л олон асуудлууд бүрхэг хэвээрээ цаанаа үлдэж байгаа шүү. Яг нөгөө булхай луйвар нь тэндээ үлдчих гээд байгаа асуудлуудын бас гол учиг нь энэ дээр байгаа шүү дарга аа. Тийм учраас хойшлуулах саналтай байна.

С.Ганбаатар: Батлут гишүүн маш чухал асуудал ярьж байгаа юм шүү. Энэ гишүүдийг хүндлэх тухай гэхээсээ илүү өнөөдөр гишүүдийг сонгосон ард иргэдээ хүндэтгэж мэдээлэл өгч байгаа. Улс орон даяар энэ мэдээллийг сонсож байгаа. Ингээд Туваан сайд ирлээ. Туваан сайдад би орж ирсэн сайд болгонд хэлж байгаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3.5-д эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Засгийн газрын гишүүний мэдээлэл, Засгийн газрын гишүүний мэдээлэл гэж байгаа шүү. Засгийн газрын гишүүний мэдээлэл, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тайлан, илтгэл, мэдээллийг холбогдох хуульд заасны дагуу сонсох, хэлэлцэх гэж заасан байгаа. Бид бол хуулиа л дагаж байгаа шүү. Ингээд Туваан сайд ороод ирсэн байна.

Би энэ саяын горимын саналтай холбогдуулж, удаа дараа энэ 3 дахь удаагаа болж байгаа. Онтре гоулдтой холбоотой энэ өнөөдрийн асуудал дээр өнөө өглөө орж ирлээ. Энэ Монголын ард түмэн хүлээж байгаа энэ асуудал дээр. Та энэ дээр яаж хариуцлага тооцох вэ, хэнд хариуцлага тооцох вэ. Бид яг хариуцлагатай байхыг хүсэж байна. Хүний муу үзээд, хэн нэгнийг хоолгүй болгоё гэж байгаа юм биш. Зүгээр болдог энэ муу хэдэн гишүүд ямар хамаатай юм биш. Монголын ард түмнийг төлөөлж байгаа юм шүү бид. Ингээд Туваан сайд саяын горимын санал дээр яаж хариуцлага тооцох вэ, хэнд тооцох юм. Эсвэл бид сайдтай асуудлаа ярих юм уу. 3 номер.

Ц.Туваан: Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүд, даргын энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгээд хүлцэл өчье. Засгийн газрын хуралдаан 2 цагаас гараад, сэтгүүлчид гээд хэдэн минут хоцорчихлоо.

Энэ асуудал манайд албан бичгээр ирээгүй. Бид нар Улсын Их Хурлын даргын зөвлөлийн хэлэлцэх асуудал дээрээс энэ асуудлыг аваад, тэгээд өөрийнхөө хүрээнд бас асуудлаа энэ жижиг асуудал биш, асуудлаа бэлдээд орж ирсэн. Одоо хэлэлцээд явахад бол бид нарын зүгээс бол асуудал байхгүй гэдгийг хэлье. Тэгээд бас хариуцлагын асуудал дээр Байнгын хорооны даргатай жич дахиад ярилцъя. Тэгээд шаардлагатай бол хариуцлага хүлээе.

С.Ганбаатар: Горимын санал Мөнхбаясгалан гишүүн гаргасан уу. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Оюутолгойн Онтре гоулд гэхээр Онтре ХХК гэхээр хойшлуулмааргүй байна. Нэгэнт сайд нь ороод ирсэн. Мэдээлэл тарсан. Болохгүй бол түр завсарлага авчхаад буцаад хэлэлцэж болно шүү дээ. Би бол хэлэлцье гэсэн горимын санал оруулж байна. Сонсьё.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүний горимын санал бол өнөөдөр энэ асуудал ний нуугүй хэлэхэд бидэнтэй бидэнгүй Канадын шүүх дээр Рио Тинто, Онтре эд нар чинь бидний асуудлыг тэнд шүүхдэлцээд яваад байгаа шүү дээ. Тэгээд яг баялгийн эзэн нь энд ингээд л ангайгаад л байж байдаг. Тэгээд энэ асуудал дээр шаардлагатай байна гэж байна. Батлут гишүүний саналыг би бүр туйлаас хүндэтгэж байна шүү. Энэ дээр материал ирээгүй байна гээд.

Туваан сайд аа, бид даргын зөвлөлийн хурал дээр өнгөрсөн 5 дахид ярьсан. Өнөөдөр 3 дахь өдөр. Тэгээд даргын зөвлөлийн хурлаар орсон. Манай ажлын албанаас 2 удаа утсаар ярьж, материалуудаа өгөөч ээ гэсэн байгаа шүү. 2 удаа ярьсан байгаа. Тэгэхээр энэ дээр бас хаана хаанаа, бие биеэ хүндэтгэж ажиллана. Ингээд Батлут гишүүн энэ дээр шаардлагатай бол ажлын хэсэг байгуулна. Цаашид ажиллуулах сонирхол байна. Жангабыл гишүүн горимын санал гаргая гэж байна.

Х.Жангабыл: Баярлалаа. Энэ материалыг ер нь ямар журмаар, хэд хоногийн өмнө тараах ёстой юм бэ дарга аа. Би сая л авлаа. Өглөө групп дээр тавьчихсан байсан. Өглөө ч биш, 11 цагийн үед. Энэ ийм чухал асуудлыг яаж бид нар электрон жаал биш дорхноо судалдаг юм бэ. Энэ хариуцлагатай ажил шүү дээ. Тэгэхээр Батлут гишүүний гаргасан горимын санал дээр санал хураалт явуулж өгнө үү. Ер нь санал хурааа даа. Энэ судалж байж л яахгүй бол яаж бид нар санал өгөх юм бэ.

С.Ганбаатар: Ингээд Батлут гишүүн горимын саналаа тайлбарлаж бас ярьж гэж байна.

Д.Батлут: Ингээд яах вэ, материалууд оройтоод ороод ирчихсэн. Янз янзын асуудлууд байна. Тэгээд өнөөдөр бид нар танилцах боломж алга л даа. Зөвхөн энэ бол яамны л мэдээлэл, байр суурь. Янз янзын өнцгийн мэдээллүүд байгаа. Мэдээлэлтэй ганц нэг хүн байхыг үгүйсгэхгүй. Бүх гишүүд мэдээлэлтэй танилцаад, өөр өөрсдийнхөө хэмжээнд олж авсан мэдээллээ баталгаажуулах, цаашлаад өөр өөр өнцгөөс нь олж харах, мэдээллүүд цуглуулах, үгүй ээ, энэ чинь Монголын эрх ашигтай холбоотой асуудал ярьж байхад бид нар хуумгай хандах асуудал биш биз

дээ. Зайлшгүй нэлээн сайн тунгааж, олон талын мэдээллийн эх үүсвэрийг гаргаж ирж, бодитойгоор хандаж ажиллах нь л чухал байгаа. Эндээс зөв шийдэл гарна. Тэгэхгүйгээр хандсаны хар гай бас бидний энэ алдаанууд дотор байгаа шүү дээ. Тийм учраас дарга энэ горимын саналыг хүлээж аваад, энэ материалтай ажиллах боломжийг энэ их хурлын гишүүдэд бүгдэд нь олгоод тэгээд байнгын хороогоороо хэлэлцээд тэндээсээ ажлын хэсэг гаргаад ингээд явах нь зүйтэй гэж харж байгаа. Тэгэхгүй эндээс шууд ажлын хэсэг томиллоо гэж үзээд, яриад өнгөрөх юм бол нэг толгойг нь илээд өнгөцхөн үлээсэнтэй л ялгаагүй болчих гээд байна.

С.Ганбаатар: Баярлалаа. Ойлгож байна. Кнопоороо л шийдчихье. Гишүүд ер нь энэ шийдвэрээ кнопоороо л гаргана. Тэгэхээр горимын саналаа 2 удаа үг хэлэх, тайлбарлах дүрэм байгаа учраас Мөнхбаясгалан гишүүн горимын саналаа тайлбарлаад, тэгээд дараа нь горимын саналаар санал хураалт явуулна.

Л.Мөнхбаясгалан: Нэгэнт энд Монгол Улсын Засгийн газрын төлөөлөл ингээд сайд нь хүрээд ирчихсэн мэдээллээ бэлдчихсэн байгаа юм чинь бид сонсож болно шүү дээ. Ямар яг одоо ажлын хэсэг байгуулаад, яг одоо бүх талуудыг дуудаад мэтгэлцэх гэж байгаа биш, хэлэлцүүлэх гэж байгаа биш тийм биз дээ. Өнөөдөр нэгэнт энд бэлдээд аваад ирсэн дээр нь энэ хэмжээ дээрээ сонсchoод, ажлын хэсэг байгуулах чинь дараагийн асуудал байж болно шүү дээ.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүний санаа бол яах вэ одоо бидэнтэй бидэнгүй олон улсад бидний баялгийн тухай хэлэлцээд эхэлчихсэн, бараг бидэнгүйгээр шийдэх гээд байгаа энэ үед яам бас бид нараар дуудуулахгүйгээр материал, мэдээлэл өгч байх ёстой шүү дээ. Тэгээд яг үнэхээр бодитой байдал ийм байгаа юм.

Ингээд мэдээллээ яамнаас сонсchoод, тэгээд дараа нь ингээд ажлын хэсэг байгуулаад, бүр дэлгэрэнгүй мэдээллээ аваад нэлээн ханцуй шамлаж оръё гэсэн саналыг зарим гишүүд гаргаж байна. Хамгийн анхны горимын саналаар Батлут гишүүний саналаар санал хураалт явуулна. Ингээд Батлут гишүүний санал бол мэдээллээ хойшлуулъя. Хойшлуулаад дараа нь дахиж ярилцвал болж байна уу гэсэн санал. Дахиж байнгын хороогоор хойшлуулж хэлэлцье гэсэн ийм санал байна. Энийг дэмжиж байгаа гишүүд нь санал хураалт дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ингээд тэнцэнэ гэдэг чинь юу гэсэн үг билээ. Унасан гэсэн үг. Тэгвэл ингээд мэдээллийг сонсchoор боллоо. Туваан сайд мэдээллээ өгнө үү.

Ц.Туваан: Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэгт Засгийн газраас өргөн мэдүүлснээр эсхүл өөрийн санаачилгаар тухайн ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах гэж заасан бөгөөд үүний дагуу Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор Стратегийн ач холбогдол бүхий ордын жагсаалтад Оюутолгойн бүлэг ордыг хамруулж, Улсын Их Хурлын 2009 оны 57 дугаар тогтоолоор Оюутолгойн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааны төрийн эзэмшлийн доод хэмжээг 34 хувь байхаар тогтоосон байдаг.

Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйлд Монгол Улсын Их Хурлын 2008 оны 40 дүгээр, 2009 оны 57 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын

2009 оны 308 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын Засгийн газар болон “Айвенхоу Майнс Монголиа Инк” Ххк “Айвенхоу Майнс Лимитэд Рио Тинто Интернэйшнл Холдингс Лимитэд компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан бөгөөд тус гэрээнд Оюутолгой ХХК нь 6709А, 6708А болон 6710А тоот тусгай зөвшөөрлөөр олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуул, олборлолт, боловсруулалтын үйл ажиллагааг явуулах, гэрээний 3.3, 15.7.8-д Онтре гоулд компанийн эзэмшиж буй 3148Х, 3150Х тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талаар Айвенхоу Майнс Лимитед компанийн өнөөгийн эдэлж буй эрхийг гэрээгээр баталгаажуулах эсхүл холбогдох эрхийг хөрөнгө оруулагчид шилжүүлсний дараа Засгийн газар уг эрхийн 34 хувийг эзэмшинэ. Хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл болгоно гэж тус тус тусгажээ.

Онтре ХХК-ийн эзэмшиж байгаа 3148Х, 3150Х дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлүүд 2001 оны 4 сарын 3-нд олгогдсон бөгөөд Ашигт малтмалын газрын даргын 2009 оны 877 дугаар тушаалаар Шивээ толгой нэртэй NV0152268 Жавхлант нэртэй NV015225 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг олгосон байна. Оюутолгойн зэс алтны ордон орд нь Хюга, Херуга, Оюут зэрэг ордуудаас бүрддэг бөгөөд нийт нөөцийн зэсийн 24 хувь, алтны 42 хувь, мөнгөний 29 хувь, молибдены 94 хувь нь Онтре ХХК-ийн эзэмшиж байгаа 2 ашиглалтын тусгай зөвшөөрлүүдэд хамаарч байна.

Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдахаас өмнө Туркойс Хилл Ресурс компани нөгөө талаас Онтре Ресурс Лимитэд компаниуд 2004 онд ашиг хуваах гэрээг байгуулсан бөгөөд тус гэрээнд Онтре гийн эзэмшиж байсан 3148Х, 3150Х дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн талбай дахь геологийн судалгаа хайгуулын зардалд Туркойс Хилл Ресурс компани нь 35 сая доллар, түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн олборлолт хийх гүн нь газрын гадаргаас доош 560 метр хүртэл байх тохиолдолд Туркойс Хилл компани 70 хувь, Онтре ресурс лимитэд 30 хувь. Хэрэв 560 метрээс доош бол Туркойс Хилл Ресурс компани 80 хувь, Онтре ресурс компани 20 хувийн эдийн засгийн өгөөж хүртэхээр тохиролцсон.

Мөн талууд ашиг хуваах гэрээний хавсралтаар хамтран ажиллах гэрээг байгуулахаар тохиролцсон байна. Тухайн үед ашиг хуваах гэрээнд хавсрагдсан хамтран ажиллах гэрээний төсөл нь ирээдүйд байгуулагдахаар төлөвлөгдсөн байдаг. Улмаар Туркойс Хилл Ресурс компани нь дээрх эрх буюу Онтре-гийн талбайгаас дал эс үгүй бол 80 хувийн ашиг хүртэхээ 2005 онд эрх шилжүүлэх гэрээний дагуу Оюутолгой ХХК-д шилжүүлсэн байдаг.

Онтре Гоулд ХХК-ийн эзэмшиж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг Оюутолгой компанид шилжүүлэх болон Онтре Гоулдын талбайд Оюутолгой компани бүтээн байгуулалт, олборлолт үйл ажиллагаа явуулах, Онтре гоулд болон Оюутолгой ХХК баяжмал борлуулалтаас хүртэх эдийн засгийн сонирхлоо баталгаажуулах тухай 2004 оны хэлэлцээрийг гэрээгээр баталгаажуулах үйл явц удаашралтай байгаа гэж үзэж, Онтре гоулд компани Арбитрын маргааныг 2022 оны 5 дугаар сард үүсгэсэн.

Тус маргаанд нэхэмжлэгч Онтре Ресурс Лимитэд, хариуцагч нь Оюутолгой ХХК болон Туркойс Хилл Ресурс Лимитэд байсан бөгөөд энэхүү маргааны талаар 2024 оны 12 сарын 19-ний өдөр олон улсын арбитрын шийдвэр гарсан. Арбитрын

шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Оюутолгой ХХК-ийн ТУЗ нь 2025 оны 1 сард хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдахаас өмнө талуудын хооронд тохиролцсон хамтран ажиллах гэрээг болон тусгай зөвшөөрөл шилжүүлэх гэрээ үүнд /Шивээ толгой, Жавхлант/ байгуулах эрхийг гүйцэтгэх удирдлагадаа олгосон.

Аж Үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас стратегийн ач холбогдол бүхий Оюутолгойн бүлэг ордын хил заагийг тогтоох асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 4 сарын 9-ний хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байдаг.

Монгол Улсын Засгийн газраас Оюутолгойн бүлэг ордын хил заагт Онтре ХХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүдийг хамааруулах шийдвэр гаргасан бөгөөд үүнтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтын дагуу Тусгай зөвшөөрөл эзэмшигч Онтре ХХК-ийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмших эсхүл түүнийг АМНАТ-өөр орлуулах эсэх асуудлыг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.

Онтре ХХК-ийн тусгай зөвшөөрлүүдийг Оюутолгой ХХК-д шилжүүлэх хэлцэлд Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэн ард түмэнд ноогдож байх гэсэн шаардлагыг хангуулах нь чухал байна гэж яамны зүгээс үзэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Ганбаатар: Мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд саналаа өгнө үү. Кнопоо дарна уу. Ингээд Жаргалсайхан гишүүнээр тасаллаа. Жангабыл гишүүн асуулт асууна. Энэ ирцээрээ Уянга гишүүн эхэлж ярих юм байна шүү. Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Өдрийн мэнд өдрийн мэнд хүргэе. Танилцах нэлээн шаардлагатай. Тэгээд ажлын хэсэг байгуулна гэж бол ойлголоо. Тийм тэгэхээр тэр үед нь бас нэлээн асуултуудыг асууна. Хөрөнгө оруулалтын гэрээ гээд танай хэд дэх слайд байна даа. 8 дахь байна уу. Монголын Засгийн газрын байр суурь Рио Тинтогийн байр суурь 2-ыг хооронд нь хараад таны хэлсэн зүйлүүдтэй уялдуулаад бодож байлаа л даа. Тэгээд тэрнийхээ хүрээнд асууя. Тэгэхээр манай байр суурь болохоор хөрөнгө оруулалтын гэрээндээ өөрчлөлт оруулъя гэж ерөнхийдөө уншигдаж байна. Дээрх асуудлыг ажлын дэд хэсгүүдийн дүгнэлтээр бол баталгаажуулсан байгаа юм байна.

Рио Тинтогийн байр суурь нь болохоороо энэ арбитрынхаа 2024 оны 12 сарын 19-нд гарсан маргааны шийдвэрийнхээ дагуу Хөрөнгө оруулалтынхаа гэрээнд энэ тусгай зөвшөөрлийг нь шилжүүлээд авах эрхтэй юм. Засгийн газар дангаараа хийчих юм. Улсын Их Хурал руу оруулах шаардлагагүй юм л гэж байгаа юм шиг уншигдаад байна л даа. Одоо яг ямар явцтай явж байгаа юм бол. Энэ гэрээний хэлэлцээр хоорондын ажлын хэсэг байгуулсан байгаа болов уу. Мэдээж тийм техникийн асуултууд бол байгаа. Тэгэхдээ яг тийм гол зүйлээ л та хэлээд өгөөч. Юун дээр нь бас ямар асуудал байна.

С.Ганбаатар: Асуултад 3 номерт Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Энэ нэлээн том асуудал байгаа. Тэгээд яг өнөөдрийн байдлаар бол Засгийн газрын зүгээс Оюутолгойн өмнөх Их Хурлын үед хэрэгжиж байсан 103 дугаар Их Хурлын тогтоол гарсан. Энэ 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж гүйцэтгэлийг Их Хуралд танилцуулах ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар намайг томилсон.

Мөн үүнтэй зэрэгцээд энэ Оюутолгойн татварын маргаантай холбоотой асуудлаар Арбитрын маргаан явж байгаа. Яг одоо олон улсын арбитр дээр энэ асуудлыг хариуцаж байгаа ажлын хэсгийн даргаар нь Алтангэрэл сайд явж байгаа. Тэгээд үндсэндээ яг энэ 2 асуудлын хүрээнд Оюутолгойтой бид нар бол энэ ажлын хэсгийнхээ хүрээнд байнга уулзаад, Рио Тинтогийнхонтой ч гэсэн уулзаад явж байгаа гэдгийг хэлье.

Мэдээж энэ асуудлыг ярихаар яг бодитойгоор бол энд байгаа хүмүүсийн ихэнх нь энэ Оюутолгойн гүний уурхайтай очиж танилцсан. Гүний уурхайн доор байгуулагдаж байгаа туннелийн байгууламжууд нь бол яг энэ лицензийнхээ хил дээр тулаад ирчихсэн байгаа. Тэгэхээр энэ дээр одоо энэ асуудлыг зайлшгүй шийдвэрлэх гэдэг ийм асуудал байгаа. Оюутолгой компани Рио Тинтогийн зүгээс бол энэ асуудлыг яаралтай шийдэхгүй бол бид нар бас яг энэ Онтре-ийн талбай руу орох асуудлаа төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулаад, өөр тийшээгээ олборлолтынхоо асуудлыг хийгээд явна. Тэгэхээр энэ нэлээн цаг тулсан асуудал гэж ингэж асуудлыг тавьдаг. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бол нөгөө саяын уншсан алт, мөнгө, зэсийн өндөр агуулгатай хэсэг энэ Онтре-ийн лицензтэй талбайд хамаарч байгаа учраас хэрвээ төлөвлөгөө өөрчлөгдөөд явбал манай Монгол Улсын хүртэх өгөөж 2037 он гэж байгаа. Хувь өгөөж бас хойшлох ийм асуудал байгаа гэдгийг хэлье.

Мэдээж Онтре компани Рио Тинто компани 2 хоорондоо арбитрын шүүх дээр асуудлаа тавиад, энэ дээр бол Онтре компанийн талд шийдвэр гарсан буюу түрүүний тэр ярьсан ашиг хуваах гэрээний дагуу хийгдэх хамтран ажиллах гэрээг байгуулах хугацаа маш удаан байна. Энэ хугацаа нэлээн алдаж байна гэдэг асуудлаар шийдвэр гарсан учраас энийг ахиулахын үүднээс энэ лицензийг шилжүүлэх, бусад асуудлууд орж ирж байгаа.

Монгол Улсын Засгийн газрын барьж байгаа байр суурь бол мэдээж сая Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг дээр стратегийн 16 ордын 8 ордын хил хязгаар тогтоогдоогүй байсан. Энэ 8 ордыг бүгдийг нь нэгдсэн байдлаар оруулж байж өмнөх Засгийн газрын хуралдаанаар стратегийн ордуудын хил хязгаар бүрэн тогтож дууссан. Энэ хүрээнд Оюутолгойн бүлэг ордын хил хязгаарыг тогтоохдоо Онтре компанийн 2 лиценз энэ.../минут дуусав/

С.Ганбаатар: Гүйцээж хариулъя. 3 номер.

Ц.Туваан: Энэ хил хязгаар дотор орсон байгаа учраас энэ бол одоо стратегийн орд гэдэг ангилалдаа ороод, мөн Засгийн газрын өнгөрөгч оны 11 сарын шийдвэрээр энэ 34 хувийг тогтоох асуудлыг Учрал сайдад үүрэг болгосон хүрээнд энэ асуудал яригдана. Тэгээд мэдээж стратегийн ордтой холбоотой хөрөнгө оруулалттай холбоотой асуудал учраас Засгийн газраас хэлэлцээд, Улсын Их Хуралд өргөн барьж шийдвэрлүүлэх гэдэг ийм байр суурь дээр байгаа. Тэгээд ойрын хугацаанд энэ асуудал Засгийн газраар орж, Улсын Их Хурал руу шийдвэрлэгдэхээр орж ирнэ гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Уянга гишүүн тодруулж асууя. Ойрын хугацаа гэдгээ бас тодруулж хэлсэн нь дээр байх.

Б.Уянга: Тодруулаад нэг зүйлээ хэлье. Өнгөрсөн 7 хоногт байх аа, Баясгалан гээд нөгөө Монгол талаас ТУЗ-д суудаг бүсгүй Монголын Үндэсний Телевиз дээр байна уу, Тэнгэр телевиз дээр байна уу яриа өгсөн байсан юм. Тэгээд энэ Арбитр дээр маргаан нь Онтре-ийн талд шийдэгдчихсэн учраас Ашиг хуваах гэрээ 80/20 буюу тэр гэрээнийх бол хийгдчихсэн юм байна лээ. Тэгэхээр энэ хийгдчихсэн, ер нь бол тэгээд л бүгдээрээ ажлын хэсгээ байгуулаад, цаашаагаа мэдээллээ бүх талаас нь сонсох ёстой л юм шиг сонсогдоод байна л даа. Тэгээд ямартай ч 2 тал яг энэ Онтре-ийн асуудлаар ажлын хэсэг байгуулаад нэг ширээний ард суусан байгаа юм уу, суугаагүй байгаа юм уу. Яг хэзээ суух юм. Сууж эхэлсэн байх үед ямар асуудал байна. Бид нар юу мэдэх ёстой вэ.

С.Ганбаатар: 3 номерт Туваан сайд хариулъя. Маш тодорхой асуултууд асуулаа.

Ц.Туваан: Ажлын хэсэг бол ерөнхийдөө байнга уулзаж байгаа нөгөө талтайгаа. Саяхан бас энэ Рио Тинто группийн гүйцэтгэх захирал Жекоб бас Монгол Улсад ирсэн. Зэсийн группийн захирал нь шинээр томилогдсон хүн ирсэн. Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын сайд нартай уулзсан. Бид бүхэн бол тэнд тодорхой байр сууриа хэлсэн. Энэ асуудлыг бол Засгийн газар дангаараа шийдэх эрх мэдэл хүрэхгүй. Улсын Их Хурал дээр томоохон хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой асуудал учраас энийг Их Хурал шийднэ гэдэг байр сууриа хэлсэн байгаа. Өмнө нь тэр яригдсан 2 компанийн арбитртай холбоотой асуудал дээр бол 80/20 гэдэг дээр оччихсон байгаа. Яагаад гэхээр үүний гүний хэмжээ бол 560 метрээс доош орсон байгаа учраас энэ асуудал дээр бол Рио Тинтогийн тал буюу Оюутолгойн талд 80 хувь, Онтре компани дээр бол 20 хувь нь ашиг хуваах байдлаараа бол тогтоогдсон. Одоо харин бид нар .../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайд гүйцэд хариулъя.

Ц.Туваан: Оюутолгойд байгаа Эрдэнэс Оюутолгойн эзэмшиж байгаа 34 хувь эзэмшиж байгаа учраас Оюутолгойн талд ноогдож байгаа 80 хувийн 34 хувь гэдэг нь бол ингээд ер нь ойлгомжтой харагдаад явж байгаа. Онтре талд байгаа 20 хувийн хэдэн хувийг яаж эзэмших вэ гэдэг асуудлыг шийдвэрлүүлэхээр Улсын Их Хуралд оруулж ирэхээр байгаа гэдгийг нэмж хэлье.

Тэгээд энэ асуудал өнөөдөр Аж үйлдвэржилтийн байнгын хорооноос шийдвэр гараад танилцуулах мэдээллээр орж ирж байгаа. Яг хугацааг бас хэлж чадахгүй байна. Тун ойрын хугацаанд Засгийн газар энэ асуудлыг Улсын Их Хурал руу оруулж ирнэ.

С.Ганбаатар: Зарим хариултууд дээр бас нэмж тайлбар өгөх байх. Тэгээд ер нь бол яам нарийвчилсан мэдээллүүд байгаа байх. Гишүүд энэ талаар, ялангуяа Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүд энэ талаар тодорхой мэдээлэл байхгүйгээр, шийдэл байхгүйгээр чуулган руу орвол тэгээд л ёстой хаус болно шүү дээ. Ард түмнийг талцуулна. Ингээд Жангабыл гишүүн асууя.

Х.Жангабыл: Баярлалаа. Бидэнд хангалттай мэдээлэл байхгүй байна. Тэгэхээр асуух асуулт ч хэцүү байна. Энэ Онтре гоулдын тусгай зөвшөөрлийг

шилжүүлэх гээд байгаа юм. Тэгээд Оюутолгой руу шилжүүлэх гэж байгаа юм уу. Нэг дэх асуудал. Тэрийг шилжүүлэхгүйгээр ерөөсөө л одоогийн хууль тогтоомжоор дахиад шинээр гэрээ байгуулж болохгүй юм уу. Яагаад энийг шилжүүлээд, тийшээ Оюутолгойн гэрээнд ингээд хутгаад байгаа юм бол. Лиценз нь Онтре гоулдын нэр дээр байгаа юм байна шүү дээ. Тэгээд энэ дүгнэлт бодвол нэлээд ажилласан юм шиг байгаа юм. Ажлын дээд хэсгийн санал, дүгнэлт гээд энэ дээр бол саяын зөвшөөрөлтэй газар стратегийн ач холбогдол бүхий ордод хамаарч байгаа эсэх нь тодорхойгүй гээд байгаа юм. Үгүй ээ, ийм ордыг стратегийн ач холбогдолтой хамаарч байгаа эсэхийг нь одоо хүртэл тодорхойлоогүй юм уу. Иймэрхүү асуултууд байна даа.

С.Ганбаатар: Жангабыл гишүүн бол голыг нь олж бас л Монголын ард түмний санаа зовж байгаа зүйлийг асуулаа шүү дээ. Хариулт өгье. 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Стратегийн ордуудын эхний 15, 1 нэмэгдээд 16 орд бол өмнө нь тогтоогдсон. Нэрс нь Их Хурлаар ороод баталгаажсан гэсэн үг. Энэ ордуудын хил хязгаар тогтоох асуудал тогтоогдоогүй яваад байсан 8 ордынх нь. Энэ 8 ордын асуудлын хил хязгаарыг тогтоох асуудлыг Засгийн газраас манай яаманд үүрэг болгосон Засгийн газрын тогтоол гарсан. Энэ хүрээнд бид бүхэн үлдсэн 8 ордыг хил хязгаарыг нь тогтоогоод Засгийн газрын хурлаар Стратегийн ордод авч, хил хязгаарыг нь тогтоосон. Тэгэхээр одоо бол энэ Оюутолгойн бүлэг орд бол стратегийн ордод орсон гэж ойлгож болно. Стратегийн ордод орсон дотор энэ Онтре компанийн 2 лиценз орсон гэж ойлгож болно. Дээрээс нь энэ өөрөө бүлэг орд байгаа. Тэгээд хүдрийн биет нь 1 цул. Тэгээд далд уурхайн байдлаар доороос нь одоо блоклож унагаах замаар олборлолт хийгдэж байгаа. Доороос нь блокдоод унагаахаар яг энэ 2 ордын энэ лицензийн хил хязгаараар хүдэр зааглагдахгүй. Унахаа хүрвэл тэгээд л бүгдээрээ нийлээд л унана. Тэгэхээр энэ дээр бас энэ асуудлыг бас яг энэ хэсэг рүү орж олборлохоос өмнө асуудлыг нь шийдэх ийм зайлшгүй шаардлага байгаа гэдгийг хэлье. Оюутолгой руу шилжүүлэх асуудлыг бол өмнө нь би танилцуулгад хэлсэн, шийдэгдсэн. Тэгээд арбитрын маргаантай байсан. Үүний дагуу хамтран ажиллах гэрээ хийгдээд 80/20-оор эндээс олох үр өгөөжөө хуваах асуудал яригдаад явж байгаа учраас энэ хүрээндээ лиценз Оюу толгой руу шилжих ийм асуудал байгаа. Тэгэхээр энэ шилжилт нь бол мэдээж Их Хурал дээр шийдвэр гараад, АМГТГ дээр шийдвэр гарч байж лиценз шилжинэ. Тэгэхээр үүний өмнө бид бүхэн асуудлаа Их Хурал руу оруулж шийдвэрлүүлнэ гэж ойлгож болно.

С.Ганбаатар: Жангабыл гишүүн тодруулъя.

Х.Жангабыл: Энд нэлээд их маргаан гарах юм байна сайд аа. Миний бодлоор бол. Тэрийг яаж зохицуулах юм байгаа юм. Ухаан зарахгүй бол их л хүнд асуудал болох юм байна даа.

С.Ганбаатар: Жангабыл гишүүн түрүүн тодруулж асуусан юман дээр нь би тодруулчихвал зөвдөх болов уу яадаг бол. Туваан сайд аа, Оюутолгойн хортой Монгол орныг дампууруулж, маш аюултай байдалд оруулсан Хөрөнгө оруулалтын гэрээ хувь нийлүүлэгчдийн гэрээнд энэ Оюутолгойн бүлэг ордын тодорхой бас л нэлээн том хувь болох Онтре гоулдын энэ лиценз эзэмшиж байгаа энэ талбай хамаарахгүй биз дээ гэж асуулаа. Та энэ дээр хамаарахгүй гээд болж өгвөл хэлээд өгөөч. Энэ гэрээнд хамаараг уу. Өөрөөр хэлбэл энэ асуудал дээр Монголын ард

түмэн, Монголын Засгийн газар дахиад Онтре гоулдын тал дээр дахиад шинээр, цоо шинээр хөрөнгө оруулалтын хувь нийлүүлэгчдийн гэрээ байгуулах алтан боломж байгаа гэж би үзэж байна. Зөв үү гэж маш энгийн элементарны асуулт асуулаа. Та хариулт өгөөч.

Ц.Туваан: Хамаарахгүй.

С.Ганбаатар: Өөрөөр хэлбэл Засгийн газрын зүгээс Онтре гоулд дээр цоо шинээр дахиад Монголын ард түмэн алдаагаа засаж гэрээ хийх алтан боломж байна гэж хариулж байна. Ингээд Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Оюутолгой дээр аудит хийсэн улсын нууцад байгаа аудитын тайланг би бүрэн уншсан. Анхааралтай уншсан. Монгол Улс 2034 оноос ашиг авахгүй. Хэзээ ч авахгүй. Улсын нууцад хамаарч байгаа учраас энд би зарим зүйл заалтыг ярьж чадахгүй. Тийм учраас энэ Онтре ХХК дээр бид нар маш их анхаарах ёстой. Монгол Улсын Засгийн газар энэ Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтын дагуу гэж байгаа байхгүй юу. Жишээ нь 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмших эсвэл АМНАТ-өөр орлуулах эсэх асуудлыг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх шаардлагатай байна гэж байна шүү дээ. Ийм юм ороод ирж байхад л Их Хурал хэлэлцэх шаардлагагүй юм байна гээд л асууж байгаа гишүүн байна шүү дээ энэ чинь. Тэгж болохгүй шүү дээ. Тэгэхээр Туваан сайд энийг тайлбарлаж өгөөч. Монгол Улсын Засгийн газар энэ Онтре-ийн 34 хувийг эзэмших ёстой тийм үү. Аль 17 жилийн өмнө Улсын Их Хурлын 27 дугаар тогтоолоор батлагдсан. Стратегийн ордууд. Дээрээс нь 2024 оны 4 дүгээр сард батлагдсан Үндэсний баялгийн сангийн хуулиар стратегийн ордуудын хувийг үндэсний баялгийн санд шилжүүлэх ёстой тийм үү. Тэгж байж манай үндэсний баялгийн сан мөнгөтэй болно. Тэгж байж асуудлаа шийднэ. Бид нар өнөөдөр эх үүсвэр хайгаад яваад байдаг шүү дээ. Гэтэл энд бэлээхэн эх үүсвэр байна. Энэ Онтре дээр. Тэгэхээр энийг оройтоогүй дээрээ 34 хувьтай тэнцэх хувийг яаралтайгаар стратегийн ордод авах, үүний төлөө Засгийн газар яг ямар ажил хийж байгаа юм. Танай яамнаас. Энэ дээр тодорхой тайлбар авъя.

С.Ганбаатар: Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Тийм ээ, энэ үндсэндээ нэг хүдрийн биет салшгүй ингээд нийлчихсэн 1 хүдрийн биет байгаа гэж ойлгож болно. Тэгээд тухайн үед тэр газар доорхыг харж чадахгүй учраас лицензээ компаниуд авахдаа тодорхой координатуудаар авсан. Тэр координатуудаар энэ хүдэр маань өөрөө 2 хуваагдчихсан гэж ойлгож болно. Багахан хэсэг нь буюу хамгийн баялагтай хэсэг нь Онтре-ийн Жавхлант гэдэг хэсэг дээр хойд талдаа. Өөрөөр хэлбэл энэ хойд хюга ордын үргэлжлэл гэж ойлгож болно.

Нөгөө талдаа Шивээ толгой гэдэг лиценз нь мөн адилхан бас нэг үзүүр хэсэг нь тэр юун дээр орчихсон херуга ордын үргэлжлэл болоод ингээд орчихсон байгаа. Тэгэхээр энэ өөрөө энэ 2-ыг бол салгаж ойлгох боломжгүй. Манай яамны зүгээс бол энэ стратегийн ордын хил хязгаарыг Оюутолгойн бүлэг ордын хэмжээнд нь хил хязгаараа тогтоогоод, Засгийн газраар оруулаад шийдвэрлүүлчихсэн. Тэгэхээр энэ орд одоо стратегийн орд. Стратегийн орд учраас таны саяын хэлсэнчлэн энэ асуудлыг бол Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэх ёстой.

80/20 гэдэг зарчим ингээд үйлчиллээ гэж бодоход энэ бас эцэслэгдээгүй учраас бодоход 80 хувийнх нь 34 хувь нь бол тэртээ тэргүй Эрдэнэс Монголын эзэмшиж байгаа хувьцаагаар Эрдэнэс Монгол тал буюу Монголын тал руу орчихно. Үлдэж байгаа 20 хувийн 34 хувийн асуудлыг нь авах, тэгээд тэрийг нь Үндсэн хууль, Баялгийн сангийн тухай хуульд нийцүүлэх асуудлыг одоо Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэж өгнө. 34 хувиа авах юм уу, энд санхүүгийн хариуцлага хүлээх юм уу, хүлээхгүй юм уу. Эсвэл нөгөө Орано-ийн гэрээ шиг тусгай АМНАТ-өөр орлуулаад шууд олборлолтоос нь ашиг хүртээд борлуулалтын орлогоос нь ашиг хүртээд явах юм уу гэдэг асуудал нь удахгүй шийдэгдэнэ гэж ойлгож болно.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ яг нөгөө 2007 оны Ухаа худгийн гэрээг яг давтах гэж байгаа байхгүй юу. Засгийн газрын тэмдэглэлээр Энержи ресурс шилжүүлчихсэн. Одоо тэрийгээ авъя гэж Монголын төр бараг дажин дайн дэгдээж байна шүү дээ. Одоо яг энэ шиг энэ Онтре-ийн та сая хэллээ. Хүдрийн хамгийн гол нөөц нь байдаг Жавхлант, нөгөөдөх нь Шивээ толгой гэсэн 2 хэсгийг тэд нар зүгээр л ашиг хуваах гэрээгээр өгөх гээд байгаа байхгүй юу. Тийм учраас бид нар энэ дээр Монголын Засгийн газар тусдаа гэрээ байгуулах боломжтой тийм үү. Гэрээ байгуулах тэр боломжийг судалж үзсэн үү.

С.Ганбаатар: Туваан сайд 3 номер.

Ц.Туваан: Бас энэ дээр бол нэлээн олон асуудлууд яригдах юм байна лээ. Бид хэд ч гэсэн бас нэлээн судалж үзсэн. Тэгээд дараа бас Их Хуралд ороод ирэхээр манай төрийн 34 хувийг төлөөлж байгаа Эрдэнэс Оюутолгой компани Ганхүү захирал бас томилолттой явж байгаа. Ирээд бас нэлээн зүйлүүдийг нэмж хэлэх байх. Ерөөсөө Их Хурлаар шийдвэрлүүлнэ гээд байгаа нь яг л ард түмний нүдэн дээр нээлттэй, ард иргэдийн төлөөлөл бага ард түмнээр хэлэлцүүлж эцсийн шийдвэрийг гаргуулна гэж ойлгож болно. Энэ хүрээнд таны саяын асуусан зүйл шийдэгдэнэ л гэж бид нар ойлгож байгаа.

С.Ганбаатар: Асуултад бол дараан нь хариулъя. Хүн нь ирэхээр хариулъя гэж би ойлголоо. Ингээд Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Энэ хамгийн гол асуудал бид нар нөгөө стратегийн ордод энэ орд сая хамаарахгүй гээд хэлчихлээ шүү дээ. Хамаарна гээд. Сая Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн юм байна. Тэгэхээр бидний хувьд энэ чинь нөгөө Оюутолгой гээд байж байгаа. Энэ компанийнх нь нэр нь өөр байгаад байна л даа. Тэгэхээр энэ дараа нь маргаан үүсэх үү. Маргаан үүсэх нөхцөл байгаа юу. 1 дэх асуулт нь.

2-т нь бидний хувьд Оюутолгойтой хамтраад явчихаар бид нар чинь Оюутолгойгоос ашгаа авч чадахгүй байгаа шүү дээ. Тэгэхээр бас яг тийм юм руу орчих уу. Эсвэл энэ компани ингээд шүүх дээрээ яваад, энэ шүүхийн шийдвэр нь энэ компанид олго гэсэн шийдвэр нь гарч байгаа юм байна гэж ойлгож байна. Тэгэхээр тэр олгосон орлогоос нь буюу ашгаас нь 34-өө авах нь бид нарт зөв үү. Аль нь зөв бэ. Энэ дээр та бүхний санал ямар байна вэ гэсэн ийм 2 асуулт байна.

С.Ганбаатар: 3 номер Туваан сайд.

Ц.Туваан: Монгол Улсын хуулийн дагуу бүлэг орд гэсэн ойлголт байдаг. Тэгэхээр энэ өөрөө бүлэг орд. Түрүүн би хэлсэн. Хүдрийн биет нь 1 байгаа. Тэгээд яг ингээд лицензээр нь виртуал байдлаар ингээд буулгаад үзэхээр л хуваагдаж байгаа болохоос биш энэ өөрөө яг ингээд үргэлж цул орд орд байгаа. Тэгэхээр энэ дээрээ түрүүний тэр ярьсан компаниудын хоорондын асуудал дээрээ Арбитрын шүүхээр ороод, тэр хувиа тохироод ингээд явж байгаа гэж ойлгож болно. Тэгэхээр 80 хувиар тохирчихлоо гэдгийн 80 хувийн 34 хувь нь Эрдэнэс Оюутолгой компанийн эзэмшлээр ингээд ороод явчихна. Тэгэхээр тэндээс манайх чинь энэ дээр бол нэлээн орой хувь хүртэх, тэгээд нөгөө 34 хувиараа санхүүгийн хариуцлага энэ тэр хүлээгээд, тэрнийхээ мөнгийг нь хүүтэй нь төлөх гэдэг байдлаар нэлээн хойшлоод явж байгаа шүү дээ. Юун дээр бол Онтре дээр бол ондоо асуудал байгаа. Энэ 20 хувийн 34 хувийг нь нөгөө компани ч гэсэн компани Онтре компанийнхантай ч гэсэн уулзсан. Бид нар бол энийг ашиглаж байгаа тохиолдолд энэ 20 хувийнхаа 34 хувийг төр ямар шийдвэр гарна. Тэр шийдвэрээр нь өгөхөд бэлэн байна аа гэдгийгээ тэр компанийн зүгээс илэрхийлээд явчхаж байгаа юм. Тэгэхээр бид нар энийг одоо 34 хувиар нь авах юм уу, санхүүгийн эрсдэл хүлээх үүргээ юу гэж харах юм. АМНАТ-өөр орлуулаад шууд борлуулалтаас нь ашиг аваад явах юм уу гэдэг асуудлууд бас яригдана. Хэрвээ бид нар АМНАТ-өөр орлуулаад шууд борлуулалтаас нь ашиг аваад явбал тэр 37 оныг хүлээлгүйгээр наана нь энэ Онтре-тэй талын хэсгээсээ шууд үр өгөөжөө хүртээд явчих ийм боломж байгаа гэж ойлгож болно.

С.Ганбаатар: Асуултад хариулт авлаа. Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Энэ ярьж байгаа орд лиценз бол ингээд Оюутолгойн бүлэг ордын молебеденийн 94 хувь, зэсийн 24, мөнгөний 29, алтны 42 хувь гэж байгаа байхгүй юу. Аймаар том орд байгаа байхгүй юу. Оюутолгой чинь ямар хэмжээний том орд билээ. Тэгэхэд үүний бараг зарим нь бол 90 хэдэн хувьтай, зарим нь 30 орчим хувьтай. Тэгээд дүгнээд үзэх юм бол маш том орд байгаа байхгүй юу. Тэгээд би зүгээр нэг л зүйлийг гайхаад байна л даа. Ингээд энэ лицензийг олгочихсон юм байна. Тэгээд олгоод энэ лицензийг төрд мэдэгдэхгүйгээр түүгээрээ 2 компани ашиг хуваах гэрээ гэж байгуулаад, тэгээд тэр нь олон улсын арбитрын шүүхээр маргаан болоод, тэгээд энийг би 1 дүгээрт асуух гэж байгаа нь. Энэ маргаантай холбоотой асуудлыг Монголын Засгийн газар мэдэхгүй байсан юм уу.

2 дугаарт нь энд ер нь тухайн үед Монголын Засгийн газар ямар байр суурьтай байсан юм. Өөрөөр хэлбэл эцэг өвгөдийн үлдээсэн энэ хэвлий доорх баялгийг 2 компани хоорондоо ингээд ашиг хуваах гэрээ хийгээд яваад, тэрийг нь гэнэт одоо мэдчихсэн юм шиг ийм юм ойлгогдоод байгаа байхгүй юу. Тэгээд одоо мэдчихээд хүүе ээ энийг яах вэ гээд.

3 дугаарт нь заавал Оюутолгой компанитай энийг гэрээ хийхгүйгээр шууд одоо энэ Онтре гоулд гээд компанитай нь гэрээ хийх саналаа манай Засгийн газар тавьсан юм уу. Энэ чинь Оюутолгойн гэрээг муу болсон гээд л нийгэм даяараа л олон жил ярьсан. Тэгээд одоо тэр гэрээ дээр нь дахиад нөгөө талд нь Монгол Улсын төрөөс олгосон 2 лиценз, тэгээд энэ ордынх нь бараг тэн хагас нь шахуу байсаар байтал энийг дамжуулаад дахиад нөгөө Оюутолгой компанитай нь байгуулна гээд. Тэгээд би энийг л гайхаад байна л даа. Яагаад энэ төр, Засгийн газрын хяналтгүй 2 компани хоорондоо арилжаад яваад байсан юм бэ.

Дараагийнх нь ер нь тэр лицензийг Ашигт малтмалын газар өгдөг байдлыг больё гээд би мөн их олон удаа саналаа дэвшүүлж байгаа даа. Улсын Их Хурлын зөвшөөрлөөр Засгийн газар олгодог байх. Тэгээд энэ согтууруулах ундааны импортын зөвшөөрлийг Засгийн газар олгож байна. Өндөр төвөгшилтэй барилгын зөвшөөрлийг Засгийн газар олгож байна. Тэгээд энэ хэвлий доорх энэ том ордтой холбоотой зүйлийг тэгээд 1 албан тушаалтан олгочихдог. Одоо тэр хэн гээд Жаргалсайхан гээд хүн Ухаа худгийн ордыг өгсөн л гэсэн. Сүхбаатарын Цайрт минералыг өгсөн л гэсэн. Хувьдаа авсан л гэсэн. Үүрийнтуяа гэдэг хүн 3 ураны лицензийг өгсөн л гэсэн. Хууль бус л гэсэн. Тэгээд та нар ингээд яриад л байдаг хэзээ үүнд хариуцлага тооцох юм. Энэ албан тушаалтан өгдөг байдлыг хэзээ Засгийн газар Улсын Их Хурал, ард түмний төлөөлөлд танилцуулдаг болох юм бэ. Ингээд өнгөрсөн борооны хойноос цув нөмөрнө гэдэг шиг уже ингээд яваад өнгөрчихсөн юмны араас орж ирэх л асуудал байгаад байна л даа. Тэгээд би энийг бол үнэхээр гайхаад байна.

Тэгээд танилцуулга бол дэндүү цаг тулгаж ирж байна. Хууль журам ер нь байдаггүй юм болов уу. Би энийг бас Байнгын хорооны даргаас асууя.

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүний асуулт маш чухал шүү. Энэ дээр заавал хариуцлага тооцно. Яагаад ингээд тулгав. Энэ 3 дахь удаагаа тохиолдож байгаа. Тэгээд энэ тал дээрээ бас жич сайд надад мэдээлэл өгөөд, тэгээд би гишүүддээ бас танилцуулна. Дараа дараагийн ийм юм гарахгүй гэдэг үүднээсээ энийг бас шийдэж байгаа шүү. Сая Бадамсүрэн гишүүний асуултад Туваан сайд 3 номер хариулт өгье.

Ц.Туваан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Мэдээж Засгийн газар бол мэдэж байсан энэ асуудлыг. Монгол Улсын хуульд өөрөө энэ бүлэг ордоороо ордог учраас энэ хоорондоо хамааралтай асуудал. тэгээд Оюутолгойн далд уурхай ашиглах асуудал бол саяхнаас ашиглалтад ороод ингээд явж байгаа. Мэдээж энэ хооронд тэр 2 компани Онтре компани жишээлбэл хайгуулын лиценз аваад тэрийгээ ашиглалтын лиценз болгоод ингээд явж байгаа асуудал бол хууль номынхоо дагуу явж байгаа. Энэ хоорондоо шилжих асуудал нь өөрөө бүлэг ордын хүрээнд нэг юм гээд Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээн дотор бол бас тусгагдчихсан явж байгаа ийм зүйл юм билээ. Тэгэхээр энэ асуудлыг бол Засгийн газар мэдэж байсан.

2 дугаарт энэ Онтре-ийн холбоотой асуудал Оюутолгойн хөрөнгө оруулалт маань өөрөө ингээд маш өндөр дүнтэй хөрөнгө оруулалт байгаа. Маш төвөгшилтэй газрын гүнд 1200, 1300 метрийн гүнд хөрөнгө оруулалт хийж олборлож байгаа ийм асуудал. Тусгаарлаад энэ асуудал шийдэгдэхгүй байхад Оюутолгой компани бол цаашдаа нөгөө тал руугаа Онтре тал руу биш, нөгөө тал руугаа каналаа татаад олборлолтоо хийх зорилгоор ингээд явчихна. Ингэсэн тохиолдолд тэр компанийн зүгээс ярьж байгаа зүйл бол бас нөгөө борлуулалтын орлогоос нөгөө Монголын талын оруулсан санхүүжилт дарагдаад, шийдвэрлэгдээд тэгээд эргээд Монгол Улсын хүртэх үр өгөөжийн хугацаа яригдаж байгаа. Энэ хугацаа бол бас хойшилж магадгүй гэсэн ийм зүйл байгаа.

Дээрээс нь Онтре компанийн энийг тусад нь ашиглая гэхээр 1 хүдрийн биет. Доош нь нураалаа гэхэд заагтай нурахгүй. Тэсэлгээ хийгдээд доошоо нурлаа гэхэд нийлээд л нурна. Энийг бас энэ түвшинд хоолойд доошоо туннел татаад ороход

бол бараг маш их хэмжээний зардал орно. Орох ийм асуудал бол манай яаман дээр манай мэргэжлийн хүмүүс бас ярьдаг гэдгийг хэлье.

Тэгээд ашигт малтмалын лиценз дээр бол бид нар хуулийн дагуу л явж байгаа. Тэгээд тэр дээр яг өнөөдрийн хуулиар бол тендер буюу сонгон шалгаруулалт зарлаад, компани шалгараад тэрийг нь манай яамны харьяа АМГТГ-ын Кадастрын албан дээр албажуулж бүртгэл хийж өгч байгаа л асуудал байгаа. Хууль дээр өөрөөр заагдвал бид бүхэн тэрийг бас дагаад ажиллана гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Хариулт авлаа. Одоо Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Ер нь бол яг үнэнийг хэлэхэд өнгөрсөн 70 жилийн хугацаанд бидний ахмад үеийн хайж тогтоосон энэ ордуудыг үндсэндээ 1990-ээд он 2000-аад онд хэдэн мэдээлэлд ойр хүнд өгөөд, тавиад дууслаа л даа. Тэгээд тэрний нэг жишээ бол энэ Онтре гоулд байгаа байхгүй юу. Тэгээд энэ олон жил болж байхад энэ асуудлыг яагаад ерөөсөө гаргаж ирж тавихгүй байсан юм. Ийм том Оюутолгойн бараг тэн хагас шахуу дүйцэхүйц орд явж байхад энийг яагаад өнөөдөр хүртэл гаргаж ирж тавихгүй байсан юм бэ гэдэг асуудал дээр хамгийн их санаа зовж байгаа юм. Тийм учраас энэ судлах зүйл бол маш их байгаа учраас энийг Байнгын хороо нэгэнт л татаж авч танилцуулга сонсож байгаа бол энэ дээр тодорхой чиглэлтэй ийм шийдвэр, тогтоол гаргаж, энийг дахин нарийвчилж танилцах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол Байнгын хороо тэгээд энэ асуудалд нэг их оролцоод, Засгийн газар оруулж ирэх гэж байгаа зүйлийг урьдчилгаад бид нар үзээд байх шаардлага байна уу. Хэрэв үзнэ гэж байгаа бол энийг маш сайн танилцуулгыг дахин нарийвчилж сонсох хэрэгтэй байна гэсэн санал байна.

С.Ганбаатар: Санал хэллээ. Дахин нарийвчилж мэдээллүүдээ авч сонсох ёстой гэж байна. Мөнхтулга гишүүн асуулт асууя.

П.Мөнхтулга: Олон нийтэд гарч байгаа шинэ мэдээлэл байгаад байгаа байхгүй юу. Гэтэл энэ лиценз хуваасан энэ байдал нь бүр аль эртнийх. Тэгээд энэ нь аягүй их хардалт төрүүлээд байгаа. Оюутолгойн гэрээний үед ч юм уу, ерөөсөө энэ нь гарч ирээгүй, дурдагдаагүй. Тэгээд олон нийт юу гэж хардаад байгаа вэ гэхээр түрүүний нөгөө Бадамсүрэн гишүүний хэлдгээр хамаг нөгөө охь гэдэг хамаг агууламж өндөртэй тэр охийг нь аваад, салгаад өөр компанид лицензийг нь хуваачихсан. Тэгээд энэ хардалтад байгаа учраас энэ дээр гишүүд маш анхааралтай, хойшлуулъя, дахиж сайн хэлэлцье гээд ийм асуудлууд байгаад байгаа юм. Тэгээд энэ хардалтыг бид нар энд яг Байнгын хороогоороо нэлээн сайн чанамаар байна. Нэлээн сайн чанаад, энэ бол ерөнхийдөө Засгийн газрыг их олон зүйлээс аврах байх. Тэгээд Их Хурал руугаа оруулаад хийхдээ одоо бол бид нар нүүрс гарахгүй маш хэцүү байдалд байна шүү дээ. Төсөв маш хэцүү байдалд байна. Нүүрсний үнэ унаад байдаг. Алт, зэс харин зөрүүлээд энэ дайны нөхцөл байдал, худалдааны дайны нөхцөл байдал дээр эргүүлээд гол түүхий эд болоод эхэллээ. Өсөөд эхэллээ. Тэгэхээр энэ үед бид нар нөгөө 34 хувь энээ тэрээ баялгийн сан гэсэн төөрөгдүүлэхгүйгээр байнгын орлоготой байх асуудал дээрээ, наана нь мөнгөтэй болох асуудал дээр Оюутолгойн гэрээг бид нар нээрээ турж үхтлээ л харлаа шүү дээ. Тэгэхээр энэ нөхцөл рүүгээ бид нар маш сайн Байнгын хороо дээрээ чанамаар байна.

Тэгээд асуулт бол яагаад лицензийг нь ингээд хуваачихсан юм. Анхнаасаа яагаад энэ 20 хувь гэдэг юм тусдаа газар аваад үлдчихэв. Манайх яагаад 80 хувь, тэгээд нөөц хэр хүнд байгаагаас шалтгаалж гэж ийм нөхцөл байдал тогтоогоод байгаа юм. Энэ нөөц нь хэр хүнд байгаа нь тодорхой л байсан шүү дээ. Тэгэхээр энэ асуудлуудыг та нэг цэгцтэй гишүүдэд ойлгуулж өгөөч ээ. Тэгээд одоо Засгийн газар дээр хэрвээ яг энэ Онтре-ийн орд дээр шинэ гэрээ байгуулагдах юм бол үүний төсөл ямар хувилбараар явж байгаа юм. Хувь эзэмшиж явах юм уу. Түрүүн та нэг зардлын асуудал ярьчихлаа. Нэлээн их зардалтай гээд. Энэ зардлын асуудлыг яаж шийдэх гэж байгаа юм гэсэн ийм 2 асуулт байна.

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн 2 асуулт асуулаа. Ингээд Туваан сайд хариулъя 3 номер.

Ц.Туваан: Энэ 2004 оны асуудал Оюутолгойн гэрээ маань Хөрөнгө оруулалтын гэрээ маань 2009 онд байгуулагдсан. Үүнээс 5 жилийн өмнө яригдсан асуудал. Тухайн үед бол зөвхөн одоо нөгөө лицензийг өргөдлөөр авдаг байсан. Доор юу байгааг хэн ч мэдэхгүй. Энд бол нөгөө хайгуулын лиценз авах асуудал. Тэгэхээр хайгуулын лицензээ авчхаад дараагаар нь өрөм тавиад нөөцөө тогтоох гэдэг асуудал, дараагаар нь нарийвчилсан хайгуул хийж байж бүр эцсийн нөөц тогтоох гэдэг ийм асуудлууд байх үед энэ 2 компани хоёулаа л зэрэгцэж ороод л нөгөө кадастраа өгөөд л лицензээ авсан. Нийтдээ 5 лиценз авсан нь л ийм байдлаар хуваагдсан гэдгийг хэлье. Тухайн үед бол тэр хэдэн метрийн гүнд байсан ч гэсэн яг мэдэгдээгүй байсан асуудал. Зүгээр таамаг байдлаар иймэрхүү асуудал яригдсан юм байна лээ.

Тэгээд бүлэг орд дээрээс нь энэ хөрөнгө оруулалтын гэрээ дээр бол энэ асуудал бас Онтре-ийн эзэмшиж байгаа лицензтэй холбоотой Онтре-ийн лицензэд ноогдож байгаа баялгийн асуудал бол яригдсан. Энийг бол бүлэг ордын хэмжээнд авч үзнэ гэдэг зүйл заалт байгаа. Энэ хөрөнгө оруулалтын гэрээн дотор. Тэгээд зардлын хувьд бол энийг олборлоход мэдээж өнөөдөр дөнгөж л саяхнаас гүний уурхайг ашиглаж эхлэхэд маш их хэмжээний зардал гарсан. Би яг гарчихсан байгаа хөрөнгө оруулалтын зардлыг нь мэдэхгүй байна. Яг үүнтэй адил хэмжээний зардал гарна дахиад энийг ашиглахад. Тэгэхээр дээрээс нь тэр орд маань өөрөө бас яг доогуур нь блоклон буулгах аргаар ашиглахад бас л яг энэ нь Онтре-ийн лицензтэй талбайн хүдэр, энэ нь Оюутолгойн талбайн хүдэр гэж ингээд ялгагдах ийм боломжгүй нөхцөл байдал үүсчихсэн байгаа. Тэр үед 2 компани анх ярилцаад, энд юм байх юм бол гэдэг таамаг байдлаараа танайх ийм хөрөнгө оруулалт хийгээд, нарийвчилсан судалгаа хийгээд, нөөц тогтоогдох юм бол тэдэн метрээс дээш үү, доош уу гэдэг нөхцөл тавьж байгаад л энэ ашиг хуваах гэрээ гэдэг юмыг байгуулаад, цаашдаа яг ашиглаад ирэх үед болохоор тэр хамтын ажиллагааны гэрээ гэдгийг байгуулаад тэгээд явна л гэдэг ийм заалт байгаа. Тэгээд нөгөө маш удаан хугацаанд яваад байхаар нөгөө Онтре компани нь олон улсын арбитрын шүүхэд Рио Тинто компани энэ асуудлаа шийдэхгүй байна гээд арбитрын маргаан үүсгээд өгчихсөн асуудал нь 2024 оны 12 сард эцэслэн шийдэгдсэн юм. Тэгээд энэ хүрээнд Онтре-ийн талд шийдвэр гараад, энэ хамтын ажиллагааны гэрээгээ яаралтай байгуулж, энэ асуудлаа цаашдаа яаралтай шийд гэдэг ийм шийдвэр гарсан байгаа гэдгийг хэлье. Мэдээж дахин дахин нягтлах .../минут дуусав/

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн тодруулж асууя. Энэ 80/20 гэдгийг нь хэн хуваагаад байгаа юм бэ. Одоо таны ярианаас ойлгоход 1 компани, 5 компани ингээд аз туршаад тэнд хайгуул хийе гээд лиценз авсан юм байна. Тэгээд азтай

учраас нэлээн том баяжмалтай ордтой болчихсон Онтре гээд компани байна. Тэгээд үүний 20 хувийг эсвэл 80 хувийг гэдэг энэ тоог ямар тооцооллоор гаргасан юм. Зүгээр анхнаасаа хайгуулын лиценз өгөхдөө ингээд тохирчихсон юм уу. Энэ 20 хувийнхаа зардлыг яаж гаргасан юм. Манай тал яагаад 90 биш, 70 биш, 80 юм. Энэ дээр яг бодит тийм шударга хийсэн тооцоолол байдаг юм уу.

С.Ганбаатар: 3 номерт Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Энэ бол нөгөө 2 компани хоорондын хувь. Ерөөсөө манай талтай ярьсан хувь биш. 80 хувийг нь тэр Ашиг хуваах гэрээгээ ярилцаад, хөрөнгө оруулалт хийгээд энийг олборлосон тохиолдолд яг энэ лицензтэй талбайгаас олборлож байгаа хүдрээс олсон ашгийг хувааж авах хувиа 2 компани тохирсон хоорондоо. Тэгээд тэнд тэр цагаас хойш Онтре компани бол энэ дээр ямар нэгэн хөрөнгө оруулалт хийгээгүй. Оюутолгой компани нь Рио Тинтогийн зүгээс хөрөнгө оруулалтаа хийгээд явж байгаа. Одоо нөгөө туннелдээд очиж байгаа хэсэг чинь яг энэ Онтре компанийн лицензийн хил дээрээ ирчихсэн байгаа. Энэ асуудал бас яагаад нэлээн шуурхай яригдаж байгаа гэхээр Арбитр дээр шийдэгдэж байгаа энэ тэр чинь бол яг энэ рүү орох уу, орохгүй юу гэдэг энэ шийдвэр гарах зааг дээр ирчхээд байгаа. Монголын талын хувь бол тов тодорхой. Хувийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн бол 34 .../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайд гүйцэд хариулъя.

Ц.Туваан: Улсын хөрөнгөөр хайгуул хийгдсэн бол 50 хүртэл гээд заачихсан байгаа. Тэгээд яг энэ хүрээгээрээ л Оюутолгойн гэрээ ч байгуулагдсан. 34-өөрөө. Тэгэхээр Оюутолгойд ноогдох 80 хувийн 34 нь бол автоматаар Эрдэнэс Оюутолгойн талд буюу Монголын талд шийдэгдчихэд ямар нэгэн маргаан байхгүй гэж ойлгогдож болно. Нөгөө стратегийн орд болчихсон учраас Онтре-д үлдэж байгаа 20 хувь ч гэсэн бас асуудалтай. Тэгэхээр ямар асуудалтай гэхээр энэ хувиа авах уу, энэ хувь авсныхаа хүрээнд хөрөнгө оруулалт хийх үү, эсвэл энийгээ тусгай АМНАТ-өөр орлуулаад шууд борлуулалтын орлогоосоо ашгаа аваад явах уу гэдэг ийм л шийдлүүдийг гаргуулахаар Улсын Их Хуралд орж ирнэ.

С.Ганбаатар: Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Баярлалаа. Маш чухал асуудал Аж үйлдвэржилтийн байнгын хороо ярилцаж байна. Тэгэхээр Оюутолгойг дагасан нэлээн том одоо хүртэл яг шийдэгдээгүй асуудлуудын нэг бол яалт ч үгүй Онтре. Тэгэхээр яг өнөөдөр бид нарын энэ хэлэлцүүлгээс юу ойлгомжтой гэх юм бол энэ Оюутолгой дээр байгаа мэдээллийн тэнцвэргүй байдал. Энэ дээр магадгүй бид нар 3, 4 удаа 1 хуралдахдаа бараг 5 цаг хуралдаад ч энэ мэдээллийг бүгдийг нь шингээж чадахгүй маш их мэдээлэл байгаа.

Тэгээд сая Мөнхтулга гишүүн ч гэсэн асууж байна л даа. Энэ арбитрын шийдвэр нь 2024 оны 12 сарын 19-нд буюу 4 сарын өмнө гарсан. Тэгээд яг тэрний дараа яг сарын дараа Эдийн засгийн байнгын хороон дээр би Тэргүүн шадар сайдаас асууж байсан. Тэр үед бол ямар ч мэдээлэл байгаагүй шүү.

Тэгэхээр энэ арбитрын шийдвэр бид нарт цаг хугацааны хувьд яаравчлах зайлшгүй шаардлага үүсгэчихсэн байхгүй юу. Яагаад гэхээр яг түрүүн сайд тайлбарлалаа л даа. Энэ 2 гэрээ байгаа юм. Энэ гэрээ бол бүр энэ чинь Рио Тинто

Монголд орж ирэхээс өмнө бүр 2004 онд Айвенхоу Майнс, Онтре гоулд гээд 2 компани хоорондоо 2 гэрээ хийсэн байдаг байхгүй юу. Хамтын ажиллагааны гэрээ тэгээд ашиг хуваагч гэж бас хэлэхгүй л дээ. Энэ хувь нийлүүлэх болон ашиг хуваах гэрээ байхгүй юу. Equity participation гэж бас байгаа юм. Энэ 2 гэрээг байгуулчхаад албажуулахгүй явсаар байгаад 20 жил болсон байна. Дөнгөж сая Арбитрын шүүхийн шийдвэр гараад Онтре дээр байгаа вебсайт дээр байгаа мэдээллээр бол дөнгөж 2 сард энэ албажсан байгаа юм. Албажингуут тэгэхээр Монголын тал эндээс хоцрох гээд байна гэсэн үг л дээ. Нөгөө 2 учраа олчхоод байдаг. Гэтэл Монголын талын эрх ашиг, Монголын талын 34 ч юм уу, АМНАТ юу вэ, тэр яах вэ гэдэг асуудал үлдчихээд байгаа юм. Тэгээд Туваан сайд миний яг асуугаад байсан гол нэг зүйл хариултыг маш тодорхой хэлчихлээ. Гэхдээ энэ дээрээ бүгдээрээ зогсоно шүү дээ. Энэ бол 2009 оны 10 сарын 6-нд байгуулагдсан Хөрөнгө оруулалтын гэрээнд тооцогдохгүй. Тэр гэрээг хийх үед энэ огт яригдаагүй. Тэр гэрээнд Онтре-тэй холбоотой ямар ч заалт байхгүй. Тэгэхээр энэ ойлгомжтой. Бас 20-30 гэж, энэ 20 хувь гэж ярьдаг чинь бас буруу шүү. Энэ 560 метрээс дээш олдсон тэр хүдэрт 30 хувь, доош олдсонд нь 20 хувь гэж байгаа юм. Тэгэхээр ер нь бол энэ 20-30%-ийн Equity participation interest гэж байгаа юм. Нэг ёсондоо оролцох хувь. Бас ашиг гэж хэлэхэд хэцүү. Тэгэхээр гэрээний маш нарийн зохицуулалтууд байгаа байхгүй юу. Тэгэхээр гэх мэтчилэн маш олон мэдээллийн тэнцвэргүй байдлаар бид нар уншаад уншаад энэ маш их мэдээлэл байгаа юм. Тэгэхээр энэний шийдлийг нь та юу гэж харж байна вэ. Энэний шийдлийг юу гэж харж байна вэ гэхээр одоо Рио Тинто 2022 онд худалдаж авахаас өмнө Туркойс Хилл гээд олон нийтийн компани ядаж мэдээлэл нь олон нийтэд байсан байхгүй юу. Яагаад гэвэл Канад, Америкийн хөрөнгийн бирж дээр гарчихсан. Одоо хаалттай болчихсон. Үүний тэнцвэргүй байдлыг гаргаж арай жоохон засахын тулд МХБ дээр Оюутолгойн хувьцааг гаргаж болохгүй юм уу сайд аа. Энэ дээр шууд танаас .../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайд хариулъя. 3 номерын микрофон.

Ц.Туваан: Тэгээд нарийн асуудлууд зөндөө байгаа. Миний ч ойлгоогүй асуудал зөндөө байгаа. Одоо нуулгүй хэлье. Нэлээн төвөгтэй асуудал байгаа. Тэгэхдээ ерөнхий ойлголт нь бол мэдээж энийг ашиглах ёстой. Энэ боломжтой хугацаан дээр бид нар ялангуяа алтны үнэ, зэсийн үнэ, энэ ордод байгаа ашигт малтмалуудын үнэ өндөр байгаа үед бол бас бид нар ашиглах юм бол Монгол Улсын, Монголчуудын хүртэх хувь, хүртэх хугацаа наашлах ийм зүйл байгаа гэдгийг бас хэлье. Дээрээс нь энэ чинь лицензээрээ яг хуваагдаж байгаа. Мэдээж ингээд ашиглалтад ороод олборлолт хийгдээд яваад ирэхээр ямар хуваарь байдаг юм, тэр метр бол ер нь ихэнх нь миний ойлгож байгаагаар бол 560-аас бүгдээрээ энэ орд бол доор байгаа. Өөрөөр хэлбэл хүдрийн биет нь бол доор байгаа учраас энэ 20 хувь гээд юм яригдах байх. 20 хувь ч бай, 80 хувь ч бай нийлээд 100 хувь ч бай ерөөсөө л яригдах асуудал бол бид нарын анхны Хөрөнгө оруулалтын гэрээндээ ярьчихсан 34 хувийн л асуудал байхгүй юу. Тэгэхээр энэ 34 хувиа бид нар бол одоо өгөхгүй гээгүй. Нөгөө Онтре компанийн зүгээс бас бид нар энийгээ өөрийнхөө авах хэсгээсээ өөрөөр хэлбэл энэ чинь Оюутолгойн ашиглаж байгаа лицензтэй талбай доторх юм яригдаагүй шүү дээ. Гадна дахиад гараад Онтре-ийн хүдрийн 80/20 яригдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр Оюутолгойд ноогдож байгаа 80 хувийнхаа 34-өө бол авах, үлдсэнээ бид нар 2 зам байгаа. 34 хувиа авна гэдгээрээ үндсэн хөрөнгө оруулалтын гэрээ шигээ явах юм уу. Эсвэл энийгээ АМНАТ-өөр орлуулах байдлаар тооцоод явбал бид нар тусдаа тэндээс орлого

олоод явах ийм боломж бас харагдаж байгаа. Тэгэхээр энийг шийдэх эцсийн шийдвэр бол Улсын Их Хуралд, Улсын Их Хурлын гишүүдэд байгаа гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Батнайрамдал гишүүн тодруулах уу. Батнайрамдал гишүүн тодруулна.

О.Батнайрамдал: Бид нар энэ дээр 34 АМНАТ гээд яригдахаар энэ бас аягүй тийм тусгай кэйс болчхож байгаа юм л даа. Яг одоог хүртэл хийсэн гэрээгээр ямар зохицуулалттай вэ гэхээрээ хамтын ажиллагааны гэрээ бол Оюутолгой гол менежер нь болно. Бүх зүйлээ хариуцна. Энэ компани өөрөө Канадын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй. Тэнд ямар ч хүн байхгүй шүү дээ. Зүгээр бараг хоосон шахуу компани байхгүй юу. Зүгээр л хувь эзэмшдэг. Хувь эзэмшлээрээ дараа нь орлого олно. Тэгэхээр яг ийм учраас одоо бид нарт Оюутолгой дээр илүү нөгөө зардал хянах гэдэг асуудал чинь Онтре дээр тусдаа байна гэж байхгүй байхгүй юу. Тийм болохоор энэ дээр хувь байх уу, АМНАТ байх уу гэдгээ бүр ондоо утгаар авч үзэх ёстой гэсэн үг 1 дүгээрт.

2 дугаарт энэ Оюутолгойн асуудал дуусахгүй. Энийг Оюутолгойг Монголын талаасаа МХБ дээр хувьцааг нь гаргаад нээлттэй компани болгох хэрэгтэй. Хөндлөнгийн Монголын санхүүгийн шинжээчид Оюутолгойг шинжилж дүгнэлт гаргадаг ийм байдал руу оруулахгүй бол төр нэг яам нь, эсвэл нэг төрийн хэдэн хүн л ирээд Оюутолгойг яриад байдаг, яриад байдаг, нөгөө талдаа ойлгодоггүй. Энэ байдлыг бүүр цугаар нь халах ёстой байхгүй юу.

С.Ганбаатар: Манай Батнайрамдал гишүүн бас чухал санал хэллээ.

Би хэдэн юм тодруулж хэлье. Оюутолгойн гэрээ 2003 оноос эхлээд л ярьсан. 2004, 2005 он гээд л ард түмэн чинь шуугиад эхэлсэн. Луйвардууллаа л гээд байсан. Би мэдэж байна гээд л цээжээ дэлдээд л хэдэн улс төрч царайтай, ухаантай царайтай хэдэн хүмүүс л давхиад байсан. Одоо алуулчихлаа гээд л тэгэхээр чинь зэрэг үгүй ээ, тэгээд явчихсан л байгаа биз дээ. Хэнд хамаатай юм бэ л гэх юм. Миний тэр үед асууж байсан асуулт. Би одоо дахиад асууя.

Одоо энэ Онтре дээр манай Засгийн газрын дарга нар, яамны дарга нар мэдэхгүйгээ мэдээд, хөндлөнгийн бие даасан олон улсын шинжээчдийг авсан уу. Шинжээчдийн дүгнэлтийг гаргуулж байгаа юу. 1 дүгээр асуулт.

Үгүй ээ, энэ чинь та нар чинь юу ч мэдэхгүй 640 тэрбум долларын Оюутолгойн үнэтэй курст суучихсан хүмүүс шүү дээ. Одоо тэгээд азаар муу хүний заяа завагт гэгчээр нэг хэсэг нь молебеденийн бол бараг 100 орчим хувь нь. Алтны нэлээн том хувь. Зэс дээр бол арай 50 хүрэхгүй. Ийм том дахин нэг алдаагаа засах боломжийг тэнгэр бурхан өгчхөөд байгаа үед та нар өөрсдөө мэддэг юм шиг царайлж орж бас монголчуудыг минь бүр сүйрүүлээд хаячхав. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт Айвенхоу Майнс, Онтре гоулд 2-ын 2004 оны 10 сарын 15-нд байгуулсан гэрээ дээр яг хувьцаа худалдан авах ашиг хуваах тухай гэрээний яг ашгаа хэдээр тохирсон бэ. Тэрийгээ тоогоор нь хэл дээ. 4.5-д нь заасан байгаа. Монголын ард түмэнд энэ хэрэгтэй.

3 дугаар асуулт. 2022 оны 3 сарын 19-нд Оюутолгойн сайт дээр монголчуудад өгөх ашиг нь тэр хавьцаа байгаа юм. Бид бол 80 хувийн ашгийг нь авна гэсэн ийм дээрэнгүй мэдээллийг Оюутолгой Рио Тинто гаргасан. Энэ дээр та нар байр сууриа илэрхийлсэн үү. Бүр албан ёсоор, бүүр албан албан ёсоор announcement ийсэн байгаа шүү дээ. Энэ дээр та нар гомдол гаргаж байр сууриа илэрхийлсэн үү. Миний 3 дахь асуулт. Би бүүр 2022 оны 3 сарын 19-нд гэж байна шүү.

Үндсэн хуулийн заалтаар ашгийн дийлэнхийг Монголын ард түмэн эзэмшинэ гэдэг энэ асуудлаа та нар яаж асуудлыг тавьж байгаа вэ. 4 дэх асуулт.

5 дахь асуулт бол хувь эзэмшлийг түрүүн асуучихсан. Гэрээ байгуулах үед нөөц тогтоогдсон эсэх талаар та нар байр сууриа хэлээч. Онтре дээр яг нөөц нь тогтоогдсон байсан юм уу. Оюутолгой дээр нөөц нь тогтоогдсон байсан юм уу. Гэрээ байгуулах үеийн эрхүүд нь яасан юм. Яг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эрхүүд нь яг юу гэж заасан юм. Монгол Улсын Засгийн газрын эзэмших хувь нь яг гэрээ байгуулж байх үед хэд хэд байсан юм.

Эцэст нь 2010 оны ТЭЗҮ-ээр орд ашиглах ТЭЗҮ-ээр 106 хуудсанд бол заасан байгаа. Монголын тал ямар ч санхүүгийн хариуцлага үүрэхгүй гэж заасан байгаа. Онтретай. Тэр талаар та нар хөрөнгө оруулалтад хөрөнгө гаргах ямар ч шаардлагагүй гэдэг тэр бүр албан ёсоор байр сууриа илэрхийлсэн байгаа. Энэ дээр өнөөдөр бас хэвээрээ байгаа юу. Өөрчилсөн байгаа юу. Би 6 асуулт асуулаа. Хариулт авъя. 6 дугаар номер дээр хариулт авъя.

Ж.Наранпүрэв: Эрдэнэс Оюутолгойн Наранпүрэв. Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Их товчхон хариулаад явъя. Эхний асуудлаар Онтре-ийн асуудлаар хөндлөнгийн бие даасан шинжээч авсан уу. Дүгнэлт гарсан уу гэж ингэж асууж байна. Яг тухайлаад Онтре-ийн асуудлаар зөвлөх гэдэг ийм багийг хараахан аваагүй байгаа. Миний мэдэж байгаагаар шүү. Тийм учраас ...

С.Ганбаатар: Та нарт бол чадвар хангалттай байна гэж үзэж байгаа юм уу.

Ж.Наранпүрэв: Тийм учраас дүгнэлт гараагүй байгаа. Яг энэ Онтре-ийн асуудлаар хөндлөнгийн бие даасан шинжээч авах асуудлыг Эрдэнэс Оюутолгой компанийн хувьд толгой компани, ажлын хэсэг, яамдад бас удаа дараа санал тавьж байсан. Зөвлөх авах уу, авахгүй юу. Дүгнэлт гаргуулах уу гэж. Зүгээр ташрамд хэлэхэд 2021 онд Оюутолгойн далд уурхайн зардлын болон хугацааны хэтрэлт үүссэн. Монголын тал хүчтэй гэх үү, эсэргүүцэлтэй гэх үү шаардлагуудыг удаа дараа тавьсан. Үүний дагуу далд уурхайн бүтээн байгуулалт дээр Ай Си Жи гэж англиар нь товчлох юм даа. Independent consulting group гэж хөндлөнгийн хараат бус шинжээч нарыг авч ажиллуулсан. Үнэхээр доор бол зардал хэтэрсэн байна, хугацаа хэтэрсэн байна. Гэхдээ уг асуудлаар тусад нь аудит хийлгэх нь зүйтэй гэдэг ийм албан ёсны дүгнэлт бол байдаг. Энэ ч мөн ялгаагүй Онтре-ийн сэдэвт хамаарна. Яагаад вэ гэвэл Оюутолгой компанийн техник хэрэгслийг буюу тэр далд уурхайн технологийг ашиглаад, операторыг нь ашиглаад Онтре-ийн хүдрийг баяжуулж, борлуулах асуудал хөндөгдөх учраас энэ далд уурхайн зардлын хэтрэлт, хөндлөнгийн хэтрэлтийн хугацааны хэтрэлтээр бол дүгнэлт албан ёсоор гарсан байдаг.

2 дугаарт нь энэ таны асуултад 2022 оны 3 сарын 19-нд Оюутолгойн мэдэгдэлд хэрхэн няцаасан бэ гэдэг ийм асуулт байгаа. Энэ дээр бас эрх зүйн хувьд тодорхой болох 2, 3 асуудал бий. Тэр нь юу вэ гэхээр Монгол Улсын Засгийн газраас 2018 онд тогтоол баталсан байдаг. Энэ тогтоол нь юутай холбоотой тогтоол вэ гэхээр зэрэг арбитрын маргааны талаар авах арга хэмжээний тухай гэж. Хэрвээ Монгол Улсын Засгийн газар Монгол Улсыг хариуцагчаар олон улсын арбитрад дуудсан тохиолдолд дараах журмын дагуу ажиллана гэсэн ийм тогтоол. Гэтэл 2009 оны хөрөнгө оруулалтын гэрээ, Хувь нийлүүлэгчдийн гэрээний маань маргааны шийдвэрлэх харьяалал нь хаана байдаг вэ гэхээр Арбитр дээр байдаг. Олон улсын НҮБ-ын дүрмийн дагуу Лондон дахь арбитрад бид нар дуудагддаг. Ингэхээр нэг талаас Оюутолгой ба тэдгээрийн хувьцаа эзэмшигч нартай холбоотой хууль бус ч гэж үзнэ үү тавьсан шаардлагыг авсан ч гэнэ үү асуудлаар сөрөг маргаан үүсэх .../минут дуусав/

С.Ганбаатар: Би арбитр уг нь асуугаагүй. Тэгэхдээ яг тодорхой хэдэн тоо л асуусан. Тэрийг хариулбал их сайн байна. Микрофоныг 6 номерт нээж өгье.

Ж.Наранпүрэв: Тодорхой асуудлуудаар шаардлага тавьсан тохиолдолд нөгөө талтайгаа байр суурийн зөрүүнд хүрэх, улмаар маргаан үүссэн тохиолдолд арбитр луу явдаг. Энэ арбитрын журам маань тусдаа Засгийн газрын тогтоолтой учраас, бас зардалтай учраас бид нарт асуудал нэг бүр дээр хувьцаа эзэмшигчээсээ зөвшөөрөл, мандат хүсдэг. Тэдгээрт бол тодорхой хариултууд ирээгүй байна. Гэрээ байгуулагдах үед нөөц тогтоогдсон уу гэдэг асуудал байна. Энийг бол хөрөнгө оруулалтын гэрээ гэж ойлгож байна. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдах үед бол нөөцийг тодорхой хэмжээнд, Онтре-ийн ялангуяа талбай дээр бол тодорхой гаргаагүй байдаг юм билээ. Тэгэхдээ бас хайгуулын судалгааны ажлууд хийгдсэн байдаг юм байна лээ. Эндээс эхлээд сонирхолтой асуудал хөндөгдөнө. 2009 оны 10 сарын 6-ны өдрөөс 2010, 2015 оны Оюутолгой төслийн ТЭЗҮ-д Оюутолгой ба .../минут дуусав/

С.Ганбаатар: 6 номерт тодруулах боломж өгье. Зүгээр нөөц тогтоогоогүй л гээд хэлчихэд болоо шүү дээ. Тодорхой

Ж.Наранпүрэв: 2010 ба 15 оны ТЭЗҮ дээр Онрте ба Оюутолгой гэдэг 2 компанийн нөөц ашиглалтын технологи, зардал, өгөөжийн асуудал хамтдаа тусаад явчихсан байдаг юм билээ. Сая 2023 оны ТЭЗҮ-ийн асуудал хөндөгдөхөд бид ямар шаардлага тавьсан бэ гэхээр уучлаарай хууль дээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ТЭЗҮ-ээ хянуулах, тодотгох үүрэгтэй шүү гэдэг шаардлагыг тавьсан. Өөрөөр хэлбэл 1 компанийн ТЭЗҮ дээр нөгөө компани нь ТЭЗҮ-ээ ачиж орж ирж болох юм уу гэдэг ийм шаардлагыг тавьж байгаа гэдэг үндэслэлээр бас сая 2024 оны 8 дугаар сард болсон Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар гэрийн даалгавар өгсөн Оюутолгойд. Энийгээ засаж ир гэж. 2010 оны ТЭЗҮ дээр Монголын тал Онтре-ийн асуудлаар ямар ч хариуцлага хүлээхгүй гэсэн. Энэ юу болсон бэ гэдэг асуудал байна. Ер нь бол энэ .../минут дуусав/

С.Ганбаатар: Хуулиараа бол дэгээр бол 2 удаа л чи тайлбар өгөх ёстой. Үгүй мөн сайхан нурших юм. Тэгээд бас хүндэлж байна. 6 номерт тодруулах боломж өгье.

Ж.Наранпүрэв: Их товчхон хариулъя. 2021 оны Улсын Их Хурлын 103 дугаар тогтоол ёсоор Монголын талд хуримтлагдсан 2,3 тэрбум америк америк долларыг тэглэх ажиллагаа хийгдсэн. 2022 оны 1 сард. Үүнээс хойш Монгол Улсын Эрдэнэс Оюутолгой компанийн эзэмшиж байгаа 34 хувь дээр өр үүсээгүй явж байгаа. Гэсэн хэдий ч түүнээс хойш төсөлд нэмэлт санхүүжилтүүд бол орсон. Тэгэхээр 2010 оны таны асууж байгаа тооцооллын хариуцлага хүлээхгүй гэдэг хэсэг бол одоо компани дээрээ өр нь бичигдээд бараг Монголын талын өрийг тэглэсэнтэй тэнцүү, түүнээс илүү хэмжээний компанийн өр Оюутолгой компанийн өр бол нэмэгдсэн явж байгаа. Товчхон хариулъя.

С.Ганбаатар: Тэгээд л өр нь л Оюутолгой талд л их гоё гоё мэдээллүүдийг өглөө. Тэгээд чи өөрийгөө танилцуул даа. Хэн билээ. Чи протоколд хэл дээ. 6 номер.

Ж.Наранпүрэв: Эрдэнэс Оюутолгой Наранпүрэв.

С.Ганбаатар: Хэн гэнэ ээ.

Ж.Наранпүрэв: Наранпүрэв Эрдэнэс Оюутолгой.

С.Ганбаатар: Юу хийдэг гэнэ ээ.

Ж.Наранпүрэв: Хуулийн баг.

С.Ганбаатар: Хуулийн баг юм уу. Хуулийн багийн дарга л байх даа. Бодвол тийм ээ.

Ингээд гишүүд асуулт асуулаа, хариултаа авлаа. Тэгээд 1 сайхан азтай баяртай мэдээг манай Засгийн газрынхан сайхан өглөө. Юу гэвэл тэр Оюутолгой ХХК, Онтре 2 хоорондоо 80/20 байна уу. Түрүүний миний асуултад та нар дутуу хариуллаа шүү. 4.5 дээр нь 51-80 хувь гээд их олон дайменшнтай заасан байгаа шүү. Тэгээд тэд хоорондоо юу гэж заасан нь падгүй. Бид 100 хувь цоо шинээр гэрээ байгуулах алтан боломж олдлоо гэдгээ өнөөдөр тунхаглаж, та нар хариулт өглөө. Тэгээд үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ингээд Замира гишүүнээр үг хэлэхийг тасаллаа. Бадамсүрэн гишүүн, Уянга гишүүн үг хэлнэ.

Б.Уянга: Их тодорхой ярих ёстой юм байна. Өнөөдөр бол миний асууж байгаа асуулт бол яг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны танилцуулж байгаа материалаас байгаа. Тэгээд яг энэ 6 дугаар слайд дээр бичигдчихсэн. Хөрөнгө оруулалтын гэрээ гэдгийн Засгийн газрын байр суурь, Рио Тинтогийн байр суурийг бичиж орж ирж байна гэдэг хүрээнд нь асуултаа бол асуусан юм. Зүгээр давтаад хэлье. Рио Тинто компанийн байр суурь нь болохоороо 2009 оны хөрөнгө оруулалтын гэрээндээ Онтре-ийн тусгай зөвшөөрлүүдэд дурдагдсан учраас энэ байр суурь гэдэг энэ хэсгийнх нь дээрээсээ 3-д бичигдсэн байгааг тайлбарлаад, дахиад өөрийнхөө асуудлыг тодруулаад хэлэхэд. Дурдагдсан байгаа учраас Хөрөнгө оруулалтын гэрээнд энэ Онтре-ийн тусгай зөвшөөрлүүд хамрагдана гэж үзэж байгаа юм байна. Тэгээд Улсын Их Хурлаар оруулахгүй байх тал дээр байр сууриа илэрхийлсэн боловч манай Засгийн газраас бол Рио Тинтогийн энэ Оюутолгой төслийн бүлэг ордынх нь хил заагийг нь сая тогтоочихсон учраас Улсын Их Хурал дээр хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт орох энэ санал нь бол орж ирэх юм байна. Мэдээж энийгээ Туваан сайд сая бол нэлээн тодорхой

тайлбарлалаа. Тэгэхээр хөрөнгө оруулалтын гэрээний өөрчлөлт Их Хурал дээр орж ирэхийг ер нь бол хүлээсэн байдалтай байж байя гэж бодож байна.

Тэгээд 1 зүйлийг бол ца заавал хэлэхгүй бол болохгүй байгаа юм. Тэр нь болохоор Туваан сайд бас санал нэгдэх байх. Ер нь энэ олон улсын хэмжээний арбитр дээр Монгол Улсын аль нэг аж ахуйн нэгж татагдаж орж ирж байгаа, Засгийн газар ч юм уу орж ирж байгаа бүх хэргүүд уул уурхайн төслүүдтэй холбоотой байгаа юм байна лээ. Энэ бол маш том харамсалтай зүйл. Тэгэхээр энэ дээр бол асуудал нь манай хууль, эрх зүйн орчин нь болохгүй байна. Бүх талаар тайлбарлагдах боломжтой байна л гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр хууль эрх зүйн орчноо, Ашигт малтмалын тухай хуулиа яаж сайжруулах вэ гэдэг дээр салбарын яамныхан нэлээн идэвхтэй ажиллана байх гэж найдаж байна.

С.Ганбаатар: Уянга гишүүнд баярлалаа. Замира гишүүн үг хэлнэ.

С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Одоо ингээд ажлын хэсэг байгуулна тийм ээ Ганбаатар дарга. Уг нь сая 80/20 гээд хувь яриад байна шүү дээ манай яамныхан. Бид нар стратегийн ордын 34 хувийг Монгол Улс эзэмшинэ гэхээс биш, тэрнээс биш тэд нарын дундаа ашиг хуваах, эсвэл хувьцаа эзэмших ч юм уу тэр тал дээр тэр дотоод асуудалд манай Монгол орон орох ёсгүй гэж би бодож байна. 34 хувийг нь бид Монгол орон авна, эзэмшинэ. Тэгээд үлдсэн хувийг нь тэд нар 80/20-оор хуваана уу, яаж шийднэ тэдний дотоод асуудал байх учиртай. Энэ тал дээр та бүхэн маань анхаарч ажиллана уу. Хэрвээ шаардлагатай бол Оюутолгой чинь бид хэллээ шүү дээ. Тийм учраас энэ удаагийн шинээр хууль батлагдаж байгаа үед бол энийг сайн ашиглаж аль болох Монгол оронд, Монголын ард түмэнд, Монголын эдийн засагт ээлтэй талаар нь хуульд шинээр оруулах юм уу, ямар нэг аргаар энийг энэ удаа цэгцэлж авъя хэдүүлээ. Та бүхэнд амжилт хүсье.

С.Ганбаатар: Замира гишүүн маш чухал саналуудыг хэллээ. Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ.

Л.Мөнхбаясгалан: Үндэсний баялгийн сангийн асуудлыг хэлэлцэхийн өмнө энэ Онтре гоулд орж ирж байгаа юм байна. Бид өмнө нь алдаа хийж байсан. Тэр алдаануудаа давтах вий дээ. Өнөөдөр гэхэд л уул уурхайн биржийн тухай хуулийг дахин засаж байгаа. Тухайн үед 40 их наядын луйвар гарлаа. Хүү, хаа нүүрсний хулгайчдыг бөөн бөөнөөр нь баривчиллаа. Мундаг хууль гарлаа гээд л явсан. Монгол, Францын Ораногийн гэрээг бас яг тэгээд л явсан. Засгийн газар урагшаа тэд алхлаа урааа гээд л явсан. Одоо энэ дээр дахиад л Засгийн газар Оюутолгойгоос том ордоо аваад, АМНАТ-ыг нь ингэлээ гээд л ингээд л бүрээ бөмбөр нүдээд давхичих вий дээ. Юмыг сайн шалгаж, ул суурьтай нягталмаар байна. Энд байгаа гишүүдээс Оюутолгой дээр хийсэн аудитын тайланг улсын нууцад байгаа тайланг уншсан хүмүүс байгаа байх гэж би итгэж байна. Одоогоор Туркес Хиллс Ресурс аймаг их ашиг олчихоод байгаа. Хэдэн тэрбум долларын ашиг олсон байгаа. Зээлийнхээ хүүнээс, зөвлөх үйлчилгээнээсээ гэх маягаар. Тэгэхээр тэр гэрээг уншаад энэ Онтре-г хамтатгаад ажлын хэсэг байгуулах хэрэгтэй байна. Тийм санал оруулж байна. Тэгэхгүй бол энийг ямарваа нэгэн ийм гэрээг зүгээр пи ар болгоод явчих вий дээ гэсэн айдас байна шүү.

Тухайн үед Оюутолгойн гэрээг баталж байхад Монголын ард түмэнд урьдчилгаа өглөө гээд л байсан. Тэрийгээ бид нар төлж л байгаа юм байна лээ

шүү дээ хүүтэй нь гэх мэтчилэнгээр. Нөгөө пи ар нь хэтэрчхээд байдаг шүү. Гэнэт эдийн засгийн байдал хүндрэхээр эсвэл улс төрийн нөхцөл байдал хүндрэхээр нэг томхон юмыг оруулж ирээд, гялалзтал аваад явдаг, тэрэндээ бүр гаршчихсан. Тийм битгий байгаасай. Ажлын хэсэг байгуулж сайтар шалгаасай гэж хүсэж байна. Байнгын хорооны дарга алга даа. Дахиад хэлэх үү ороод ирэхээр нь.

Байнгын хорооны даргыг ирсэн юм чинь дахиад хэлчих үү. Улс орны эдийн засгийн байдал муудаад ирэхээр, улс төрийн нөхцөл байдал хүндрэхээр нэг том юм гаргаж ирдэг. Тэгээд тэрнийгээ улс орны хэмжээний гайхамшигтай ажил болж Пи Ар хийдэг. Энд энэ Онтре гоулд орчих вий дээ гэж айгаад, болгоомжлоод байх юм. Оюутолгой бас яг л тийм байсан. Оюутолгойн урьдчилгаа Монголын Засгийн газарт өглөө. Пүү Монголчууд ер нь 1 хүрз эхлээгүй байхад л баяжчихлаа гээд байсан. Тэрийгээ бид хүүтэй нь төлж байгаа. Оюутолгойн хажуудаа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийг ихэнхийг нь цалинжуулан өөрсдийнхөө талд дүгнэлт гаргуулдаг. Өнөөдрийг хүртэл Туркийс хилл хамгийн их ашиг олж байгаа. Монгол улс олоогүй байгаа. 2033 оноос эхлээд ашиг нь буурна. Туркийс Хиллс өрөө төлнө. Бид нарт юу ч олдохгүй. Яг энэ Онтре гоулд ийм болчих вий дээ. Нүүрсний хулгай илрүүлээ. Бид нар ёстой үнэхээр мундаг уул уурхай биржийн тухай хууль хийлээ гэсэн. Одоо өнөөдөр тэр эдийн засагт нь чөдөр болчихоод өнөөдөр Туваан сайд орж ирээд нүүрсний хулгайчаараа дуудуулж байна шүү дээ. Та нар нийлж нүүрсний хулгай хийх гэж байна уу гээд. Тэгэхээр би энэ дээр их ул суурьтай хандахыг энд байгаа гишүүдээс хүсэж байна. Дээрээс нь Оюутолгойд хийсэн аудитын нөгөө улсын нууцад байгаа тайланг А, Б-гүй уншаач ээ. Тэрийг Монгол хүмүүс Монголын төлөө хийсэн гэдэгт би итгэхгүй байгаа өнөөдрийг хүртэл. Арай дэндүү гэрээ хийчихсэн байна лээ. Тэр аудитын тайланг олж уншаач.

Тэгэхээр Байнгын хороон дарга аа, энэ дээр ажлын хэсэг гаргаж нухацтай ажилламаар байна. Онтре гоулд, Оюутолгой 2 дээр хянан шалгах ажлын хэсэг гаргах саналыг оруулж байна. Тэгээд битгий пи ар болгоорой. Туваа сайд аа гуйж байна. Нухацтай авч үзэх хэрэгтэй шүү. Дараа нь бид нар.../минут дуусав/

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүний саналыг ойлголоо. Монголчууд зүрхээ зүсүүлчихсэн. Ойлгож байна. Тэгээд Оюутолгой яриад эхлэхээр л хэдэн пи арчид, хэдэн тархи угаагчид, хэдэн ухаантай царайтай нийтлэлчдийн цалин нь тавигддаг шүү дээ. Тэгээд л балбаад эхэлнэ. Оюутолгой ярьж байхад сонины шарласан хуудсан дээр ер нь бүр албан тушаалтан нь хэлж байлаа шүү дээ. Өдөр болгон 1 сая доллар алдаж байна гэсэн. Одоо 15 дахь жилдээ 15, 16 дахь жил дээр явж байна хөөрхий. Тэгээд хаана ч байгаа юм. Өөрсдийнхөө мөнгийг л ярьсан юм шиг байгаа юм. Тэгэхээр ажлын хэсэг байгуулна. Мөнхбаясгалан гишүүний саналыг би хүлээж авлаа. Тэгээд манай 126 гишүүнтэй парламент дээр бас 70, 80 хувь нь шинэ гишүүд байгаа. Энэ дээр цоо шинэ уур амьсгалтай, цоо шинэ зүйл хийнэ гэдэгт би итгэлтэй байгаа. Урьд нь бол хөөрхий 76-д чинь зүгээр харц нь солийгоод л ерөөсөө тэгээд л допингдуулчихаад л ороод ирдэг юм байсан байсан. Зовлон байна. Тэгээд гайгүй байх. Одоо бол юм бас сайхан болж байгаа. Ингээд Бадамсүрэн гишүүн үг хэлнэ.

М.Бадамсүрэн: 8 санал байна. Энэ Байнгын хорооноос би чиглэл өгөх тухай тогтоол гаргах ёстой гэж бодож байна. Энэ дээр чиглэл өгнө гэдэг нь мэдээлэл цуглуулахтай холбоотой. Нэгэнт Байнгын хороо энэ асуудлыг татаж авч танилцуулга сонсож байгаа бол энэ дээр ажилласан шиг ажиллахгүй бол тэгээд нэр хэмээгээд юм уу, тэгээд энэ асуудалд нь хутгалдсан байдлаар бол байхыг би

хүсэхгүй байна. Тийм учраас 1 дүгээрт хайгуулын 3148 болон 3150 гэсэн тусгай зөвшөөрлүүдийг анх бол энэ танилцуулга дээр харахад Монгол газар гэдэг компанид олгосон юм байна. Энэ компанид олгосон нь хууль тогтоомжид нийцсэн эсэхийг дүгнэлт гаргуулмаар байна.

2-т нь дээрх хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг Шивээ толгой гээд Жавхлант гээд ийм нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөл болгосон байгаа. Тэгээд хамгийн энд хардмаар байгаа нь 2009 онд олгосон гээд он сарыг нь тавиагүй байгаа байхгүй юу. Сар, өдрийг нь. Бусад бүх тусгай зөвшөөрлүүдийг тэдэн сарын тэдэнд олгосон. Оюутолгойн гэрээг 10 сарын 6-нд байгуулсан гэж байгаа юм. Энийг яагаад энэ он сарыг тавиагүй вэ. Оюутолгойн гэрээ байгуулагдсаны дараа ашиглалт болгосон уу, өмнө болгосон уу.

3.8 жилийн дараа Х-ээс А болгосон байна. Өөрөөр хэлбэл хайгуулаас ашиглалтын зөвшөөрөл болгосон. Энэ хугацаанд энэ компани яг хайгуул хийсэн юм уу, үгүй юм уу. Яг хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл болгосон юм уу, үгүй юм уу гэдгийг хянах шаардлагатай.

4-д нь Оюутолгойн гэрээ байгуулагдах үед энэ 2 лиценз хайгуулынх байсан гэж энэ танилцуулга дээр дурдсан байна. Тэгээд хөрөнгө оруулалтын Оюутолгойтой байгуулсан гэрээний 15.7.8-д Онтре гоулд компанитай холбоотой дурдагдсан гээд орхичихсон байгаа байхгүй юу. Яг юу гэж дурдагдсан юм. Тэрийг яагаад энэ танилцуулгад оруулахгүй байгаад байгаа юм. Энд бол ингээд ийм хардах, яагаад зарим зүйлүүдийн он сарыг нь тавиад заримыг нь тавихгүй байгаа юм. Яагаад зарим зүйлийг нь ингээд дурдсан болоод, мэдээлсэн болоод өнгөрөөд байгаа ч вэ гэдэг юм уу ийм хардалт бол байна. Уучлаарай энэ дээр би бас буруу бодож байж магадгүй. Гэхдээ энийг бол асуух ёстой ард түмний өмнөөс. Тухайн 2 аж ахуйн нэгж хоорондоо Ашиг хуваах гэрээ, Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн үү, үгүй юу. Энийг ер нь юу гэж үзэж байгаа юм. Одоо тэгээд сүүлдээ зүгээр миний бодлоор бол Оюутолгой компани зэрглэлдээ дээр байсан лицензээ тэрүүгээр өөр энэ Онтре Гоулд гээд компанитай байгуулчхангуутаа тэгээд тэрийгээ манайх бид нар л гэрээгээ байгуулна. Энэ гэрээ дээрээ одоо бид нар энэ өмнө байгуулсан гэрээтэйгээ нэгэн адил байна гээд. Энэ Оюутолгойг Рио Тинто компани чинь байр суурь гээд энэ танилцуулга дээр байна шүү дээ. Үгүй ээ, тэгээд ингэж болох юм уу. Энэ тусгай зөвшөөрөл лицензээ ер нь Монголын төр мэдэх юм уу, мэдэхгүй юм уу. Энэ чинь Оюутолгой гээд компани бүгдийг нь мэдэх ёстой юм уу. Энэ чинь хажууд байгаа лицензийг манайх мэднэ гэсэн л үг байна шүү дээ энгийн үгээр хэлбэл. Тэр компани хоорондоо гэрээ байгуулаад яваад байх нь Монголын хууль тогтоомжид нийцэж байгаа юм уу, үгүй юм уу гэдгийг би асуугаад байгаа байхгүй юу. Энэ дээр ийм мэдээ, тодруулга авмаар байна.

8-д нь ер нь бусад стратегийн ач холбогдол бүхий энэ бүлэг ордуудад эргэн тойронд нь бас иймэрхүү зөрчлүүд байна уу, үгүй юу. Ингээд чимээгүйхэн 1 лиценз аваад, таарчихсан байгаад байгаа юм биш биз дээ. Эсвэл хэд хуваачихсан. Тэгээд энэ бол үнэхээр хардалт төрүүлж байгаа учраас энд бүх стратегийн ач холбогдол бүхий бүлэг орд 16 орд, дээр нь дахиад 39 орд хүлээгдэж байгаа. Энэ ордуудын эргэн тойронд нь ямар зүйл байгаа вэ гэдгийг сайн хяналт шалгалт хийж, олон нийтийн мэдэх эрхийг хангамаар байна. Тэгээд энэ 8 төрлийн зүйлийг өнөөдрийн Байнгын хорооноос гарах шийдвэр дээр асуудал хэлэлцэж танилцсан бол нэг

шийдвэр гарах байх гэж бодож байна. Энэ дээр тусгаад, тэгээд нарийвчилж энэ мэдээллүүдийг авч үзэж, энийг хянаж Монголын ард түмэнд мэдээлмээр байна.

Тэгэхгүй бол энийг бид нар Байнгын хороо дээр гишүүн.../минут дуусав/

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн бас яг л аймаг удирдаж, олон хүний амьдрал зовлон бэрхшээл шийдэж явсан учраас маш гярхай, нарийн уншсан байна. Рио тинто их дээрэлхэж байгаа шүү. Энэ бол тэр луйврын гэрээ рүүгээ оруулна л гэж чирээд байгаа. Түрүүн бас манай дарга нар зарим нь ярьж байна. Ингээд тулгаад тавьчихсан. Рио Тинтогийн тэр хэдэн тоног төхөөрөмж, тэр шахтыг л ашиглахгүй бол бид болохгүй гээд шахалтад орчихсон. Аль хэзээний дарамтад орчихсон юм шиг л яриад байх юм. Тусгаар тогтносон Монгол Улсын хүмүүс шүү. Тэгээд сая Бадамсүрэн гишүүн маш чухал нарийн харсан зүйлүүд байна. Хардах юу байх вэ. Ард түмэн бид чинь тэнэг байгаад, гэнэн байгаад бүр залхаж байна шүү дээ. Тэгээд энэ дээр бас нарийвчилсан байдлаар асуудал шийдэх байх. Тэгээд гишүүний ярьсан зүйлүүд дээр бас тодорхой та нар бэлтгэл ажлаа хангана гэж бодож байна. Гишүүн болгоны энэ ярьж байгаа зүйлүүдийг бичнэ шүү. Хариултуудаа бас өгнө шүү. Очирбат гишүүн үг хэлнэ.

Г.Очирбат: Өдрийн мэнд хүргэе. Тэгээд яамныхандаа бас их талархаж байна. Мэдээллээ тодорхой оруулж ирээд Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангаад явж байгаад нь маш их талархаж байна. Тэгээд заримдаа бас манай энэ Их Хурлын гишүүд энэ өөрсдөө уул уурхайн салбараа ойлгохгүй, тэнд очиж хэдэн экскаватор ажиллуулж үзээгүй, тэнд олборлолт хийж үзээгүй, тэнд уурхайчдын яаж ажилладгийг мэдэхгүй байж байж микрофоны ардаас их улс төржих юм. Тэгээд энийгээ жоохон хаана хаанаа бодох хэрэгтэй шүү. Ямар ч байсан бодлогын асуудлыг бол оруулж ирж байгаа Туваан сайдад бас үнэхээр талархаж байна.

Тэгэхдээ Монголын эрх ашгаа яг манай яам бол хамгаалах ёстой шүү. Одоо та хэд тэгээд л тэр шийдвэр гарсан, олон улсын шийдвэр, янз бүрийн юм гарч ирээд л энд нөгөө Оюутолгойн 80 хувь дээр чинь л асуудал үүснэ шүү дээ манайхан. Тэгээд хэлэх гээд байгаа санаа бол энэ Онтре ХХК-ийн 100 хувь, тийм ээ лицензийнх нь 100 хувиас нь 34 хувийнхаа бид нар хуулийн дагуу 34 хувиа авна. Үгүй бол нөгөө өсөн нэмэгдэх АМНАТ-өөр орлуулаад, шууд татваруудаа авах ийм юм руугаа орох хэрэгтэй шүү. 34 хувь руу орох л юм бол дахиад л тэнд очоод зардлаа өсгөөд л Монгол Улс юмгүй хоцронр. Тэгэхээр аль болох бид нар нөгөө түрүүн Орано-ийн гэрээг хийдэг шиг өсөн нэмэгдэх АМНАТ-тай, аль болох л Монгол Улсад тодорхой хугацаанд, тодорхой мөнгө нь орж ирдэг, тэр нь эдийн засагт эргэлддэг ийм юмаа барьж явахгүй бол бас болохгүй шүү гэдгээ хэлэх гэсэн юм. 1 дүгээрт.

2 дугаарт гэх юм бол мэдээж энийг ухаад байх юм бол асар их юм болчихно. Зарим иргэд ч ойлгохгүй. Яаж байна гэхээр та хэд өөрсдөө харж байгаа. Онтре ХХК-ийн цаад компаниуд нь хэн бэ гэхээр л нөгөө Рио Тинто, Туркийс хиллс гээд задраад задраад явчихна. Энийг илүү тайлбарлах тусам толгой эргээд л иргэдийг 2, 3, 4, 5 хуваагдуулаад л явчихна шүү. Тэгэхээр бид нар бол энэ Онтре ХХК дээрээ үүний хамааралтай лицензээс 34 хувь гэхээсээ илүүтэйгээр зүгээр миний л хувь гишүүний байр суурь бол аль болох тэр өсөн нэмэгддэг АМНАТ татвараа аваад л явах хэрэгтэй. Энийг яам, сайд маш сайн анхаарч ажиллах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол энэ дахиад улс төрийн сэдэв болно. Тэгээд хэн хохирох вэ гэхээр ард иргэд хохирдог. Бүгд гарч ирээд, мэддэг мэддэг юм шиг юм ярьдаг.

Тэгээд 1 гоё юм болгоод л дуусгадаг шүү. Тэгээд мэргэжлийн яам мэргэжлийн ажилдаа хандаарай. 100 хувь лицензээс нь 100 хувь шүү. Явж явж наадуул чинь нөгөө 20 хувь дээрээ юм ярих гээд эхэлнэ. Энэ дээр би бүр протоколд үлдээж байгаа шүү. 20 хувь дээр чинь юм ярьж эхэлж магадгүй шүү. Оюутолгойд байгаа 80 хувь, өөрийнх нь 20 хувь дээр нийт 100 хувиас нь 34 хувиа буюу 34 хувьтай тэнцэхүйц АМНАТ-өөр татвараа л хурдан олж авах нь их чухал байгаа шүү. Тэгэхгүй бол хэрүүл дуусахгүй. Улс төржилт дуусахгүй. Очиж уурхай гэдэг юмыг мэдэхгүй хүмүүс тэнд очиж уурхай яриад л эхэлдэг ийм зовлон эхэлнэ шүү. Тэгээд энийг мэргэжлийн Байнгын хорооны гишүүний хувьд тодорхой хэлье. Хэлэхгүй бол болохгүй. Тэгээд л баахан юмыг хааж бооно, ажил явуулахгүй, улс эх орны эдийн засгийн ямар нөхцөл байдалтай байгааг тооцож үзэхгүй. Тэгээд ийм юм болдог шүү. Тэгээд мэргэжлийн яамныхан бас мэргэжлийнхээ юмнуудыг бас тодорхой байр сууриудаа илэрхийлээд явах ёстой шүү. Тэгээд яамныхандаа амжилт хүсье.

С.Ганбаатар: Гишүүд маш чухал саналуудыг хэлж байгааг ойлгоорой. Тэгээд өнөөдрийн энэ ярьж байгаа зүйлийг хөөрхий муу Рио Тинто чинь бүр синхронный сонсож байгаа шүү дээ. Тэгэхээр бидний байр суурь бас их тодорхой байх ёстой. Хатуу байх ёстой. Дээр нь түрүүн тэр Батнайрамдал гишүүн бас их чухал санаа хэлсэн шүү. Одоо ч гэсэн хуульд байгаа шүү 10 хувийг нь манай Монголын Хөрөнгийн бирж дээр гаргах ёстой гэдэг. Хууль нь байгаа шүү. Тэгээд энэ болгон дээр та нар маань бас байр сууриудаа тэмдэглэж авч байгаа байх гэж бодож байна. Мөнхтулга гишүүн үг хэлнэ.

П.Мөнхтулга: Нээлттэй хуралдаан явж байгаа. Чухал асуудал ярьж байгаа. Ард түмэн харж байгаа. Тэгэхээр маш энгийн үгээр л ярих гээд байгаа юм. Оюутолгойн бүлэг орд байжээ. 5 компани лиценз авчээ. Онтре гэдэг компани нэг маш ноцтой юм сая хэлсэн нь Оюутолгойн гэрээ байгуулагдаж байхад тухайн газар нутагт тэр лицензийн талбай дээрээ хайгуул хийгээгүй байсан гэж хэлж байна. Тэгэхээр юу болж хувирч байсан бэ гэхээр Оюутолгой бол бүр хайгуулаа хийгээд, нөгөө олон нарийн жёрк стандартаараа хийгээд, хөрөнгө оруулалтын гэрээгээ хийгээд, тэр доор байгаа юмаа дөрвөлжин шугамтай дэвтэр шиг мэдэж байсан байна. Тэгэхээр яг хажууд нь 1 метрийн зайтай байгаа газар тийм хэмжээний юм байгаа гэдэг нь тодорхой болж эхэлсэн. Онтре компани зардал гаргах шаардлагагүй болсон. Тийм учраас Оюутолгойтой ч байдаг юм уу, 2 компанийн хооронд 80/20 гэдэг шууд битүү гэрээ байгуулагдсан. Би түрүүн яагаад асуулт дээр энэ 11,9 эсвэл 21.0 тэд гэсэн нарийн тоо байхгүй 80/20 юм бэ. Энэ дээр ямар нэгэн дүгнэлт зардал гарсан уу гэсэн. Энэ дээр надад хариулт өгөөгүй. Тэгэхээр энэ Онтре гэдэг компани лиценз дээрээ ямар ч зардал гаргахгүй байж байгаад өөрөө аз таарсан тэр баялгийг 20 хувийн ашгийг авъя гэдэг ийм л хэлцэл явсан байна. Тэгэхээр бид нар энийг бол түрүүн би Бадамсүрэн гишүүний тэр олон шаардаад байгаа бичиг баримтуудыг бүгдийг нь гаргаж өгөөд, дахиад Мөнхбаясгалан гишүүн ажлын хэсэг байгуулъя гэж байна. Тэгээд энэ дээр нэлээн нарийн авч үзээд, бид нар ерөөсөө бүх юмыг цоо шинээр 100 хувиар нь лиценз дээр эхлүүлэх боломж байгаа юм байна гэж харж байна. Яагаад гэвэл энэ компани хайгуулын зардлаа гаргаагүй байж байх үедээ өөрсдөө юутайгаа мэдээд ийм тохироо хийсэн байна. Тэгэхээр Монголын баялгийг 2 компани хоорондоо тохироод 80/20 гээд зүгээр аман тоогоороо, цээжинд багтсан тоогоороо ингэж хувааж эзэмшиж болохгүй. Тэгэхээр хэдүүлээ энэ зүгээр аз таарчихсан л байна шүү дээ. Нэг хайгуулын лиценз авчихсан чинь тэр дээрээ зардал гаргаагүй байж байгаад ингэсэн. Тэгэхээр нөгөө хуульд үндсэн логикоороо тэр компани зардлаа гаргаад, эрсдэлээ үүрээд явсан бол бид нар 34 хувийг нь авъя гэж байгаа юм.

Тэгтэл яг тэр Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдаагүй үед Оюутолгой хажуу талыг нь бүгдийг нь зардлаа гаргаад хайгаад олчихсон байгаа учраас тэр хүнд тэр зардлыг гаргах шаардлагагүй болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хүн, энэ компани, энэ этгээд бол ерөөсөө энэ дээр зардал гаргахгүйгээр маш том ашиг хүртэх боломж бий болж байгаа энэ нөхцөл байдлыг бид нар дүгнэж үзээд, энэ 100 хувь дээр ямар шийдвэр гаргах вэ гэдгийг л манай Засгийн газар ухаанаа уралдуулж ажиллаасай гэж хүсэж байна.

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн чухал саналууд хэллээ. Ажил хэрэг болгож авах ёстой. Ингээд Батнайрамдал гишүүн үг хэлнэ.

О.Батнайрамдал: Энэ асуудал хөндөгдөхгүй байсан болохоос биш байгаад л яваад байсан юм л даа. Рио Тинто талаасаа ч, Онтре талаасаа ч гэрээ нь албажихгүй яваад, сүүлдээ 2 тал явж шүүхдэж байж, шүүхийн шийдвэр гарч байж албажиж л байна л даа. Тэгэхээр яах вэ энэ цаг хугацаанд бас Монголын тал цаг алдалгүй өөрсдийнхөө яг энэ 2 лиценз дээр хамаарах Монголын баялгийн талын хувь хэмжээ юу байх вэ гэдгээ л ойлгомжтой болгох ёстой. Ер нь энэ асуудлыг бид нар шийдэж байна гэдэг бол зөвхөн Монголын тал асуудлаа шийдэж байгаа биш л дээ. Энэ бол оролцогч бүх талууд олон жил явж ирсэн эрсдэлд тооцогдож байсан асуудлуудаа нэг мөсөн шийдээд явах боломж л юм л даа. Тийм учраас энийг бид нар нэгэнтээ шийдчих юм бол 3 тал гурвуулаа маш ойлгомжтой болоод, харилцан ашигтай хамтын ажиллагаа явах боломжтой нөхцөл нь л бүрдэнэ гэсэн үг л дээ.

Тэгэхээр Монголын тал ялангуяа Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдчихлаа. тэгээд сая Ганбаатар дарга хэлж байна. Ашигт малтмалын тухай хуулийн 5.3, 5.4, 5.5 бас 5.6 дээр хөрөнгийн бирж дээр 10 хувийг нь гаргах гээд бүх заалтууд нь байгаа. Тэгэхээр энийгээ л бид нар хамтдаа энэ нэг хэлэлцээрээр энэ асуудлуудаа бүгдийг нь шийдчихмээр байгаа юм. Тэгэхээр Оюутолгойн энэ маргаан дээр бол татварын маргаан байна. Тэгээд энэ Онтре-ийн маргаан байна. Янз бүрийн асуудлууд байгаа. Тэгэхээр энийгээ нэг цогцоор шийдээд урагшилмаар байна.

Тэгээд дээрээс нь бас 1 зүйл гарч ирсэн. Тэр юу вэ гэх юм бол урьд өмнө нь явж байсан яг тэр үнэ шилжүүлэх механизмын хүрээнд үндэстэн дамнанг татвараас зайлсхийх жишээлбэл эрсдэл байдаг юм л даа. Тэгээд энэ бол жишээлбэл яг тухайн 2012 оны үед Оюутолгойн толгой компани Нидерланд гээд Монгол Улстай давхар татварын гэрээтэй орон байхад яг энэ асуудал хөндөгдөөд Монгол Улс тухайн үедээ Улсын Их Хурал бол Нидерландтай бол давхар татварын гэрээгээ цуцалж байсан. Ингэж бас цуцалснаараа бид нар дээр жишээлбэл бид нар татвар дээр маргаан үүсэх нөхцөл нь бүрдэж байсан. Ингээд 2020 он хүртэл бид нар татварын маргаанаар 1,3 их наяд төгрөгийн татвар алданги ноогдуулчихсан 3 их наяд төгрөгийн алданги ноогдуулчихсан байдаг. Гэтэл жилийн өмнө Оюутолгой Нидерланд гээд толгой компани маань Оюутолгой Сингапур гэдэг шал өөр нэртэй юм байна лээ. Гэхдээ Сингапурын бас Монгол Улсад давхар татварын гэрээтэй компани руу Толгой компани маань яг Нидерландын компанид байгаа бүртгэл дээр нь байгаа бүх өр төлбөр бүх зүйлээ шилжүүлсэн мэдээ байгаа. Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ гэхээр цаашдаа бид нар давхар татварын гэрээтэй учраас дахиад татварын маргаан гаргаж чадах боломж нөхцөл хаагдах ийм эрсдэл дагуулж байгаа юм л даа. Тэгэхээр энэ эрсдэл гарч байсан учраас бид нар тэрийг ойлгоод тухайн үедээ арга хэмжээ авч байсан учраас энийг бид нар алдаа автаж болохгүй юм. Тэгэхээр Оюутолгойтой

холбоотой нэлээн цогц хэд хэдэн асуудлууд байгаа. Тэгээд энийг Засгийн газар үнэхээр Улсын Их Хурлаар оруулж ирэх гэж байгаа бол цогцоор нь шийдэж орж ирээрэй. Зөвхөн Онтре-ийн асуудлыг шийдчихээд, үлдсэнийг нь орхиж болохгүй. Тэгэхээр энэ энэ маргаан чинь үргэлжлээд л яваад байгаа. Тэгэхээр нэгдсэн ойлголттой, нэгэнтээ л бид нар хамтдаа энэ уурхайг 60 жил цаашлаад ч ашиглах байх. Тэгэхээр энэ асуудлуудаа цогцоор нь шийдээд явах нь зөв гэж бодож байгаа.

Тэгээд сая та бол миний жишээлбэл түрүүн 7 хоногт Ерөнхий сайд тавьсан асуултын гол зүйлийг нь яг хариулчихлаа. Тэр ямар ч байсан бид нар тэгвэл Онтре-ийн 2 лиценз дээр Онтре компанитай Монгол Улсын Засгийн газар Үндсэн хуулийн 6.2 болон Ашигт малтмалын хуулийн 5.3.5-д заасан заалтын дагуу бол шинэ Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах нь гэдэг агуулга руу орох юм байна. Ийм хүлээлттэйгээр Засгийн газар энэ дээр яаралтай шийдлээ гаргаад Улсын Их Хурлаар орж ирэх нь зөв л гэж бодож байна. Та бүхэнд амжилт хүсье.

С.Ганбаатар: Манай Батнайрамдал гишүүн чухал саналууд ярилаа. Ер нь бол би товчхон үг хэлээдэхье.

Яг энэ Онтре гоулдын тал дээр бол Оюутолгойн ТУЗ-д байсан Монголын тал би ч тухайн үедээ их шүүмжилдэг л байсан ч гэсэн хүмүүс бол бас яг Монголынхоо талд их олон дуугарч байсан. Би протоколтой нь танилцаж байсан. Яг энэ асуудлаар бол бид сүүлийн 10 гаруй жил Бат-Эрдэнэ аварга байна. Даваасүрэн гишүүн, Болорчулуун гишүүн байна, Баттөмөр гишүүн байна. Олон гишүүдийг би нэрлэнэ. Энэ Онтре-ийн асуудлаар бид удаа дараа байр сууриа илэрхийлж байсан. Тэгэхдээ яам нь дандаа ихэвчлэн таг байдаг. Ямар сайндаа энэ 80 хувийг нь бол энэ хортой гэрээгээрээ бид шийднэ шүү гээд л удаа дараа мэдэгдээд байхад л бид дуугүй байна гэдэг бол хүлээн зөвшөөрч байгаа юм шиг болчих гээд байдаг шүү. Удаа дараа бид нар бас ард түмнээ ойлгож бас нэг өрвөлзөж байх ёстой, байр сууриа илэрхийлж байх ёстой юм болов уу. Заавал тэр арбитр дээр очиж татаж чангаалгаж байж биш, тэд чинь ингээд л дураараа мэдээлэл хийгээд байдаг. Дээр нь нэмээд энэ төрийн нууцад хамаарагдаагүй, аваагүй байгаа зүйл шүү. Нээлттэй ярих ёстой. Жишээ нь ордыг ашиглах 2010 оны ТЭЗҮ-ийн 1 дүгээр бүлгийн 106 дугаар хуудсан дээр Монголын тал 34 хувь дээрээ ямар ч санхүүгийн хариуцлага үүрэхгүй шүү. Бид ямар ч хөрөнгө оруулалт хийх шаардлагагүй гэдгээ бүр албан ёсоор бичсэн байгаа шүү. Яамныхан тэрийг бүүр нарийвчилж хараарай. Та нар мэдэж л байж таараа л даа.

Тэгэхээр 2-т нь миний хэлж байгаа зүйл гэвэл ээ дээ та нар Монголчууд ийм том том төслүүд рүү ороод 15 жил алуулж дуусаж байгаа ч гэсэн жоохон туршлагатай байгаа ч гэсэндээ бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтийг гаргуулж байж дүгнэлт гэдэг чинь бидний өмнөөс шийдвэр гаргана гэсэн үг биш шүү дээ. Дүгнэлтээ тойрч бид нар Засгийн газар, Улсын Их Хурал нь ярих алтан боломж бүрдэнэ гэсэн үг шүү. Тэгээд нөгөө Рио Тинто шиг, Голден Сакс шиг тэдний карманы луйварчин компаниас бас зөвлөгөө аваад далаараа тавиулав. 2 удаа луйвардуулна гэдэг бол адгийн тэнэг болж хувирна. 2 дахь удаагаа хэдүүлээ Монголын талд нэг нааштай шийдвэр гаргана гэж би итгэж байгаа. Ингээд миний асуултуудад бас зарим зүйлүүдийг нь тодорхой хариулсангүй. Мэдээллийг өнөөдөр бид сонслоо. Ингээд асуулт асууж, мэдээлэл авлаа.

2 дахь асуудалдаа орно. Энэ асуудлаар бид ажлын хэсэг байгуулах уу гэдэг 2 дахь асуудал руугаа орно.

Онтре Гоулд тэгээд энэ Оюутолгойтой холбоотой энэ асуудал дээр ажлын хэсэг байгуулах нь зүйтэй гэж нэлээн олон хоногийн өмнө бас Мөнхбаясгалан гишүүн хэлсэн шүү. Тэгээд л асуудлууд бас очерлож дугаарласаар байгаад л явж байгаа нь энэ шүү. Ингээд ажлын хэсэг байгуулах нь зүйтэй.

Дараагийн хуралдаан дээр ажлын хэсгийн удирдамж болон бичиг баримтаа баталгаажуулъя гэж бодож байна. Ингээд өнөөдөр ажлын хэсэг байгуулж, нарийвчилсан мэдээллүүдийг авъя гэдэг ийм шийдвэрийн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд бас саналаа өгнө үү. Би энийг дэмжиж байгаа шүү. Батбаяр гишүүн горимын санал гаргая гэсэн. Батбаяр гишүүний микрофоныг өгье.

Д.Батбаяр: Би саяын ажлын хэсэг байгуулъя гэдэг санал хураалтад санал өгөх гэсэн боловч энэ төхөөрөмж гацсан учраас саналаа өгч чадсангүй. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгуулаад, дахин санал хураалгах ийм горимын санал гаргаж байна.

С.Ганбаатар: Батбаяр гишүүн, минийх ч гэсэндээ бас дараад болсонгүй шүү. Батбаяр гишүүний горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Батбаяр гишүүний санал бас.

Үгүй ээ, энэ чинь ажлын хэсэг байгуулахгүй, энийг ер нь хэлэлцэхгүй гэж арай ч үгүй байлгүй дээ. Дараа нь албан бичгээр явуулчих уу. Үгүй ээ, үгүй. Ажлын хэсэг байгуулаад л тэр чинь мэдээллээ авна. Үгүй ээ, цаана чинь бидний юмыг Канадад яриад, эд бадгыг нь хуваагаад цаана чинь бүүр ингээд залгичихсан байгаа шүү дээ. Тэгвэл энэ 2 дахь асуудлыг дараа нь ирц бүрдсэний дараа хэлэлцье гэдэг горимын санал гарах юм уу. Мөнхбаясгалан гишүүн горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаясгалан: Монгол Улсын эрх ашигт хамааралтай, стратегийн ордод хамааралтай асуудлыг хэлэлцэж байхад гишүүд ажлын хэсэг байгуулахаас татгалзаж болохгүй байх гэж бодож байна. Бүгдээрээ ажлын хэсэг байгуулъя гэдгийг дэмжиж байгаа байх. Тийм учраас Байнгын хороо ирцээ бүрдүүлээд, ажлын хэсэг байгуулах хэсэг дээр санал хураалтаа түр хойшлуулбал яадаг юм гэсэн тийм горимын санал оруулж байна.

С.Ганбаатар: Ингээд гишүүд эрх нь байгаа юм чинь горимын санал гаргалгүй яах вэ. Ингээд Мөнхбаясгалан гишүүний горимын саналыг ... үгүй би чинь хурал даргалагч шүү дээ. Би чинь хурал зохион байгуулагч шүү дээ. Мөнхбаясгалан гишүүн тэгэхдээ ёс ёмбогор шүү. Мөнхбаясгалан гишүүний саналаар горимын санал заавал хураах ёстой. Тэгээд горимын санал сая нэгэнт л гаргасан бол өөрөөр хэлбэл өнөөдөртөө шийдье. Зүгээр гишүүдийн ирц бүрдэхгүй байхад жоохон хойшлуулж болохгүй юу гэсэн. Ингээд Уул уурхайн яамныхан байж байгаарай. Дараагийн асуудал танайх ярих байгаа шүү.

Ингээд Мөнхбаясгалан гишүүний горимын саналаар Тулга гишүүн горимын санал гаргаж байна.

Б.Тулга: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Би бас жоохон хоцроод ороод ирлээ Засгийн газрын хурал дөнгөж сая тараад. Тэгэхээр өнөөдрийн энэ оруулж байгаа асуудал маань ерөнхийд энэ асуудлыг танилцуулж байгаа гэж би ойлгож байгаа. Дэгийн хувьд та сая ажлын хэсэг байгуулах саналаа хураагаад дараа нь тэр дээр горимын санал гаргаад уначихсан учраас дахиж ажлын хэсэг байгуулах тухай асуудал яг энэ асуудал дээр бол биш байх. Зүгээр харин хэдүүлээ ярьж байгаад энэ бол ганцхан тохиолдол биш байх гэж бодож байна. Тэртээ тэргүй манайх 1997 оны хуулиараа лиценз олгохдоо ингээд л залгаа залгаа олгочихсон. Шивээ хүрэнгийнх ч байдаг. Нөгөө юуных ч байдаг. Бүх л ордууд ийм байгаа. Тэгэхээр энийг ер нь нэгмөсөн хамтруулаад ярих нь зөв байх л гэж бодож байна. Тэр үүднээсээ энэ дээр нэг их учиргүй би эх оронч, чи эх оронч биш гэдэг агуулгаар биш. Өнөөдөр энэ дээр бид нар ямар нэгэн шийдвэр гаргахаар танилцуулга биш байна шүү дээ. Энэ чинь ийм ийм юм байгаа шүү гэдгийг л мэдээлж байгаа мэдээлэл байгаа учраас нэг их хэдүүлээ юу яалгүйгээр зарчмын хувьд энэ лицензүүдийнхээ дахин хэлэхэд нөгөө хэсэгчлээд, махчлаад олгочихсон юмнууд дээр ер нь яах юм. Энэ чинь яг л бодитой л проблем шүү дээ. Дээр нь аваачаад маштабаар нь хуваагаад өгчихсөн. Доор нь юу юу байгаа нь мэдэгдэхгүй. Мэдэгдээд гараад ирэхээр зохицуулалтаа хэдүүлээ юмаа л сайжруулах ёстой шүү дээ. Энийгээ л харин яривал яасан юм бэ. Тэгэхээр энэ ажлын хэсгээ арай өөрөөр томьёолбол зүгээр юм биш үү гэж хэлэх гэсэн юм.

С.Ганбаатар: Ойлголоо Тулга сайд аа. Тэгэхээр байна шүү дээ. Мөнхбаясгалан гишүүн горимын санал гаргачихсан байхад, та нарын хэн нь ч гаргасан байхад горимын саналаа өөрөө л татахгүй бол би заавал хураах ёстой. Мөнхбаясгалан гишүүн үг хэлье. Горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаясгалан: Горимын саналаа татъя.

С.Ганбаатар: Ингээд нэг нь эх оронч, нэг нь эх оронч биш гэдгээ харуулахаас илүү ирэх 7 хоногт Үйлдвэр технологийн паркийн ажлын хэсэг бас нэлээн эрчимтэй ажиллана. Тэгэхээр манай Байнгын хорооны гишүүдийн ирц бас нэлээн суларна. Тэгэхээр бас 2 долоо хоног хойшлохоор байгаа шүү. Тэгээд нөгөө дэлхий дээр чинь нөгөө юмнууд нь гялалзаад явчихвал ард түмний өмнө юу хэлэх вэ дээ. Ингээд Батбаяр гишүүн горимын санал гаргая гэж байна.

Д.Батбаяр: Түрүүн яг асуудлыг яг танилцаж байх явцад бас өөрийнхөө саналыг хэлье гэсэн боловч бас хэлж болоогүй. Төхөөрөмж ажиллаагүй учраас би саналаа хэлэх боломж гарсангүй. Тэгээд энэ дээр юу вэ гэхээр яг анх лиценз олгосноос хойш хамтын ажиллагаа, ашиг хуваах гэрээ 2 аж ахуйн нэгжийг байгуулах хүртэлх явцад яг ямархуу байдалтай хайгуулын лицензүүдийг хайгуулыг хийж байсан юм бэ. Яг энэ хайгуулын лицензийг авахдаа хийсэн гэрээнийхээ дагуу ажил хийж байсан юм уу, үгүй юм уу гэдэг дээр бас жоохон тодорхой мэдээлэл дутуу байгаад байна л даа. Хоёрхон хуудас цаас байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ 2 хуудас цаасаа арай жоохон өргөтгөөд, манай яамныхан минь ахиад жоохон ажиллаад, жоохон мэдээллүүдээ зузаатгаад, шаардлагатай мэдээллүүдээ гаргаж өгөөд энэ Байнгын хорооны гишүүдэд шийдвэр гаргахад мэдээллээр хангах учиртай. Тэгээд энэ мэдээллээ жоохон дэлгэрүүлээд, ахиж хуралдаад тэгээд шийдвэр гаргавал яасан юм бэ гэсэн ийм горимын санал байна.

С.Ганбаатар: Батбаяр гишүүний санааг ойлголоо. Ингээд үндсэндээ яамнаас илүү мэдээлэл авъя л гээд байна. Үгүй ээ, тэр мэдээллийг чинь авах гээд 7 хүнээ сонгоод, тэр яам руугаа очиж, өдөр шөнөгүй ажилла л гэж хэлэх гээд байгаа ухаантай юм шүү дээ. Тэгэхээр 23-уулаа ажилламаар байна. Ажлын хэсэг хэрэггүй л гээд байх шиг байна янз нь.

Ингээд өнөөдөр Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороо Онтре гоулдын талаар мэдээллийг монголын ард түмэнтэй хуваалцлаа. Ажлын хэсэг байгуулж энэ рүү нарийвчилж орох асуудал дээр ажлын хэсэг байгуулах одоохондоо шаардлагагүй байна. Бүгдээрээ мэдээлэл авъя гэж үзэж байгаа юм байна. Ингээд одоо 2 дугаар асуудлыг хэлэлцэхгүйгээр, ажлын хэсэг байгуулахгүйгээр 3 дугаар асуудалдаа оръё.

16.20 цаг.

Ингээд 3 дугаар асуудал руугаа оръё. 3 дугаар асуудал Эрдэс баялаг, уул уурхайн яамтай холбоотой учраас гишүүд маань их онцгой анхаараарай. Ялангуяа тойрог дээр байгаа ашигт малтмалын зөвшөөрлүүдтэй холбоотой асуудал шүү.

Ингээд Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох.

Мэдээллийг өгнө үү. Ингээд ажлын хэсгээ би танилцуулъя. Түрүүн танилцуулаагүй явчихсан байна шүү.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жавхланбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Намчинсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Ганбаатар гэсэн ийм ажлын хэсэг ирсэн байна.

Ингээд Туваан сайд танилцуулга хийнэ.

Ц.Туваан: Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

Гэрээ байгуулах асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулна. Байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно. Нутгийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг олон нийтэд нээлттэй ил тод байлгана. Нутгийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд гэрээнд тусгагдаагүй хандив тусламжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахыг хатуу хориглоно гэж хуульчилсан байдаг.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс 2023 онд 21 аймгийн олборлолтын үйл ажиллагаа явуулж, ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу ирүүлсэн 211 уулын ажлын тайлан албажсанаас мөн хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу нутгийн захиргааны байгууллагатай байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх гэрээг Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан загварын дагуу 173 гэрээ байгуулж, гэрээ байгуулаагүй 23 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, ашигт малтмал баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч 15 аж ахуйн нэгж байна.

Гэрээ байгуулсан 173 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 147 гэрээг дүгнэж, тодорхой шалтгааны улмаас гэрээ дүгнэгдээгүй 24, санамж бичиг байгуулсан 2 байгаа ба гэрээний хэрэгжилт, гэрээ биелэлт дунджаар 95,7 хувьтай байна. Монгол Улсын Засгийн газар олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгад 2006 онд нэгдсэн. Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлагын хүрээнд 2006-2023 орнуудын хооронд аж ахуйн нэгжүүдээс нийт давхардсан тоогоор 16,361 олборлох үйлдвэрлэлийн холбогдох тайлан, гэрээ, мэдээллийг ил болгож, мэдээллийг түгээх ажлыг гүйцэтгэж байна.

Энэхүү холбогдох тайлан, гэрээ, мэдээлэлд аж ахуйн нэгжүүдийн ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасан орон нутагтай хамтран ажиллах гэрээ багтдаг болно.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, аймгуудын Засаг дарга нартай Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Эрдэс баялгийн салбарт мөрдөгдөж байгаа төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахад хамтран ажиллах, үйл ажиллагааны уялдааг хангах, байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар гэрээ байгуулан хэрэгжилтийг жил бүр дүгнэн ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийг хэлэлцэн холбогдох шийдвэр гаргаж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Ганбаатар: Туваан сайд мэдээлэл өглөө. Ингээд мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ингээд 3 гишүүнээр тасалъя. Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Уянга гишүүн асуулт асууна.

Б.Уянга: Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дээр асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана гээд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг өгсөн байдаг. Яг ингээд газар дээрээ хэрэгжиж байгаа байдал дээр нэг ийм асуудал байгаа. Тэрийг бас сайд юу гэж харж байгаа бол. Ер нь бол тусгай зөвшөөрөл байгаа сумын өөрөө удирдах байгууллага аймгийнхаа Засаг даргатай, тэгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй ингээд гуравласан байдлаар гэрээгээ хийгээд явдаг. Тэгээд тэрнийхээ дагуу юу хийх вэ гэдгээ гэрээндээ тусгаад, хэрэгжилтээ хангаад явбал илүү үр дүнтэй байдаг. Тэгтэл харамсалтай нь манайд юу болдог вэ гэхээрээ аймгийнх нь Засаг дарга нь нэг нам, сумынх нь Засаг дарга нь болохоороо арай нэг өөр нам байлаа гэж бодоход тэр нь ингээд аймаг нь сумаа оруулахгүйгээр гэрээ хийнгүүтээ тэгээд

сумдаа тухайн 4 жилд ямар нэгэн байдлаар хөрөнгө оруулалт тавьдаггүй. Тэгээд тэр сумын газар нутаг хөндөгдөөд байдаг боловч яг нутгийн тухайн компани нь тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулийнхаа 42-т заасан үүргийнхээ дагуу гэрээгээ хийгээд, мөнгөө сумдаа биш аймагтаа өгөөд байтал сум тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч 2-ын хооронд асуудал үүсчихдэг. Тэгэхээр энэ дээр ажлын хэсэг манай Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо дээр байгуулагдах гэж байгаад бол их талархалтай байгаа юм. Тэгээд энд бол орж ажиллана. Тэгээд та хэд зөндөө статистик өгч явуулсан байна. Ажлын хэсгийнхэн бүгдээрээ сууж байгаад бараг аль аль сумд нь сумаа, аль аль аймаг нь сумаа оруулахгүйгээр хоёрлосон байдлаар хийсэн байна. Тэрнийх нь үр дагавар нь юу болов. Аль нь гуравласан байдлаар хийсэн байна гээд ажиллагчид зүгээр юм шиг байна лээ. Тэгээд та ер нь энэ агуулгыг бас сонссон л байх. Ер нь цаашдаа магадгүй 42.1 дээр зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигч нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана гэхгүйгээр сум, аймаг 2-ыг нь хоёуланг нь дэлгэрүүлж зааж өгөх ёстой ч юм уу нэг тиймэрхүү тийм санал бол хувийн зүгээс бол байгаа. Тэгээд энэ дээр таны саналыг сонсьё.

С.Ганбаатар: Туваан сайд 3 номерын микрофоныг нээж өгье.

Ц.Туваан: Уянга гишүүний асуултад хариулъя. Энэ дээр яг орон нутаг дээр одоо бид нар энэ гэрээ байгуулна гээд заачихсан байгаа. Тэгтэл орон нутаг дээр нөгөө амьдрал баян гэдэг шиг нэлээн өөр нөхцөл байдлууд үүсээд байдаг. Тухайлах юм бол аймаг нь сумуудтай, уурхайнуудтайгаа уулзаад, та нар сумуудтай гэрээ байгуулахгүй шүү. Зөвхөн аймаг мэдэж байгуулах болсон гээд бас шийдээд явдаг асуудал ч бий. Тухайлах юм бол Төв аймаг дээр энэ асуудал өнгөрсөн хугацаанд яг тодорхой гарч байсан. Сум нь юу гэдэг вэ гэхээр бид нар яагаад сум дээрээ энэ уурхай ашиглуулж байгаа байж байж бид нарт ямар ч шийдүүлэх асуудал, ялангуяа нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчны нөхөн сэргээх гэх мэт энэ асуудлуудын хүрээнд бас бус хандив тусламжийн хүрээнд асуудал шийдэж болдоггүй юм бэ гээд ингээд асуудал ярьдаг.

Миний байр суурь бол мэдээж гуравласан байдлаар байх нь аймаг засаг захиргааны нэгжийн тухай хуулиараа мэдээж сум нь аймагтаа харьяалагддаг ч гэсэн яг тэр сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа учраас бол гуравласан байдлаараа явах нь илүү үр дүнтэй гэсэн ийм байдал харагдаж байгаа. Мөн нөгөө талаасаа манай зарим сумууд дээр ажиглагддаг. Юу гэхээр нөгөө уул уурхайн компанитай өөрсдөө сумын Засаг дарга нь 1, хурлын дарга нь 1, орлогч нь 1, байгаль орчны байцаагч нь 1 ингээд тус тусдаа очоод янз бүрийн байдлаар хандив тусламж аваад яваад байдаг. Нэлээн их хэмжээтэй авчихдаг. Нөгөөдхөө ерөөсөө ил тод мэдээлдэггүй. Тэгэхээр нөгөө уурхай бол бид нар өгч байгаа шүү дээ. Өгөөд ийм ийм юм гээд нэлээн сүүлд энэ асуудал яригдсан үед ил болдог.

Тэгэхээр ер нь бол энэ асуудлыг бас ажлын хэсэг нэлээн анхаараад, ер нь ил тод байдалд нь тэгээд харилцан тийм шударга байдлаар шийдчих нь зөв байх. Дээрээс нь энэ асуудал цаашлаад ингээд явахаараа АМНАТ-ийн хуваарилалтыг орон нутагт хийх гэдэг асуудалтай ч гэсэн бас уялдаад явах асуудал байгаа гэж байр сууриа хэлье.

С.Ганбаатар: Ингээд асуултад хариулт авлаа. Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Ашигт малтмалын тухай хуульд байгаа орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр их чухал заалт л даа. Тэгээд энийг бол цаашид бол маш сайн хэрэгжүүлэх хэрэгтэй. Ер нь энэ өргөн уудам нутагтай Монгол Улсын хувьд бол нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өөрийн төсвийн эрх мэдэл, бие даасан хөгжлийн асуудлууд бол хамгийн чухал байгаа. Жишээлбэл манай 1 аймгийн нутаг дэвсгэр Өмнөд Солонгосын нутаг дэвсгэрээс том. Тэгээд 21 аймагтай. Тэгэхээр Засгийн газар энэ яамд бол бүх орон нутагт очиж ажиллах бас боломжгүй учраас энэ нутгийн одоо өөрөө удирдах ёс, нутгийн захиргааг бол дэмжих ёстой.

2 дугаарт нь энэ хууль дээр нутгийн захиргааны байгууллага гэдэг байгааг юу юу гэж ойлгож байгаа вэ гэдгийг би бас 1 дүгээрт асууя. Нутгийн захиргааны байгууллага гэдгийг. Надад авсан мэдээллээр бол өмнө нь уул уурхайн сайдаас өмнө шүү. Уул уурхайн сайдаас энэ ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах төслийг өргөн барихдаа сумын засаг дарга гэрээ байгуулна гэж хуулийн төсөл орсон гэж би сонссон. Гэхдээ би өөрөө хараагүй. Ингээд энэ хууль бол тэгээд буцаагдсан юм байна лээ гэж ойлгосон. Хэлэлцэгдээгүй. Энийг сумын засаг дарга ганцхан байж болохгүй шалтгааныг би бас хэлье гэж бодож байгаа юм. Үндэстэн дамнасан том компаниудтай жишээлбэл Оюутолгойтой, Петровичтай Дачин Тамсагтай сумын Засаг дарга ижил түвшинд хууль, эрх зүй хөгжлийн асуудлууд гэрээ байгуулахад бас бодох ёстой асуудал байгаа. Сумын Засаг дарга дэргэдээ хууль зүйн хэлтэс байхгүй. Байгаль орчны газар байхгүй. Мэргэжил арга зүйн хувьд бол ийм туслалцаа үзүүлэхэд бол их учир дутагдалтай.

Тийм учраас ихэвчлэн аймаг, сумын Засаг дарга 1 талд нь гэрээ байгуулж байгаа гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл гуравласан гэрээ бол биш. Яагаад гэвэл энэ талдаа нутгийн захиргааг төлөөлж аймаг, сумын Засаг дарга, нөгөө талдаа компанийг төлөөлж өмчийн эзэн гүйцэтгэх удирдлага 2 л гэрээ явуулах ёстой. Миний хувьд бол Дорнод аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа яг энэ загвараар гэрээ байгуулж ажиллаж байсан. Өөрөөр хэлбэл компанийн зөвхөн гүйцэтгэх захиралтай байгуулахаар өмчийн эзэн биш учраас би энэ дээр хөрөнгө санхүүтэй холбоотой эцсийн үүрэг хариуцлагыг бас хүлээхэд учир дутагдалтай гэдэг асуудал гардаг учраас энэ талд нь өмчийн эзэн буюу ТУЗ-ийн дарга, энэ талд нь гүйцэтгэх захирал, энэ талд нь аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга. Ингэж хийвэл их тохиромжтой гэж үзэж байгаа. Дээр нь энэ Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д заасан нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана гэдэг дээр ашигт малтмалын шинээр боловсруулж байгаа хууль дээр энийг жоохон дэлгэрүүлж оруулж ирэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл яг журам гээд явчихаар л энэ маань жоохон асуудалтай болчихоод байгаа шүү дээ.

Тийм учраас энэ дээрээ тодорхой яг юу гэж, юу гэж гэрээ байгуулах юм бэ гэдгийг тодорхой зааж өгөхгүй бол жишээлбэл мөнгөн дүнгээр мөнгө төвлөрүүлье гэхээр АМНАТ шиг болчих гээд байдаг. Тэгэхээр энийг яаж их тодорхой заах вэ гэдгийг .../минут дуусав/

С.Ганбаатар: Асуултад хариулъя. 3 номерын микрофон дээр Туваан сайд .

Ц.Туваан: Нутгийн захиргааны байгууллагыг бол засаг захиргааны нэгжийн хуулиараа бид бүхэн аймаг, тэгээд сум гээд хуваагдаад явж байгаа. Удирдах байгууллагын хувьд бол мэдээж манай дээр нэг тийм жоохон уруу байдлаар хэрэгжээд явдаг. Өөрөөр хэлбэл Засаг дарга нь Иргэдийн хурлаасаа сонгогдоод,

томилогддог. Одоо яг л Их Хурал, Засгийн газар байгуулдаг шиг. Тэгээд яг нөгөө хэрэгжүүлж байгаа мөн уламжлалаараа ч гэдэг юм уу Засаг дарга л бүх асуудлыг шийдэж мэддэг юм шиг ийм байдалтай явдаг. Тэгэхээр энэ удирдлага дотор бол шат шатны Иргэдийн Хурал, түүнээс томилогдсон Засаг дарга, түүний удирдлагын багийг гэж ерөнхийдөө ойлгож байгаа. Яг энэ гэрээний тухайд бол хуулийн заалт дээрээ бол бид 42.1 дээрээ бол дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар гэж байгаа юм. Ерөөсөө ингээд уг нь бол ингээд тодорхой заачихсан. Тэгээд энэ хүрээд заримдаа халиад ч явсан ийм асуудал байдаг. Таны хэлсэн асуудал бол мөн л дөө. Бадамсүрэн гишүүн бас орон нутагт удирдаж байсан. Тэгээд гүйцэтгэх захирал гээд нөхөртэй гэрээ хийчихдэг, дахиад цаад талд нь компанийн яг жинхэнэ удирдлага эзэмшигч, ТУЗ энэ тэр чинь ондоо юм яриад яваад байдаг. Тэгэхээр энэ асуудлыг тодорхой болгоё гэдэг зүйл дээр бол тантай санал нэг байна. Тэгэхээр энэ асуудлыг хэлэлцэгдэж байгаа юм чинь ажлын хэсэг байгуулагдаад явах байлгүй. Тэгээд бид нар Улсын Их Хурлын даргын захирамжаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэг Наранбаатар гишүүнээр ахлуулаад, манай яам бас дэд ажлын хэсэгт нь оролцоод явж байгаа. Тэгээд энэ асуудал дээр бас тодорхой зүйлийг илүү тодорхой байхаар зааж өгье гэдэг зүйлээр хариулт өгье.

С.Ганбаатар: Туваан сайд хариуллаа. Бадамсүрэн гишүүн тодруулъя. Жаргалсайхан гишүүний нэрийг бас оруулаарай. Түрүүн хэлээд гарсан шүү.

М.Бадамсүрэн: Тэгэхээр Ашигт малтмалын тухай хуулийн энэ их чухал заалт учраас энэ шинэчилсэн найруулга дээр энийг улам сайжруулах чиглэлээр нэлээн сайн байгуулагдах ажлын хэсэг бол анхаарах, тэгээд ер нь Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ч гэсэн анхаарах ёстой гэж үзэж байгаа. Дээр нь бас мэргэжлийн яамны хувьд та бүхэн энийг улам илүү дэвшилт гаргаж ажиллах тал дээр нэлээн сайн дэмжиж ажиллаасай гэж бодож байна.

2 дугаарт нь бол энэ iltodgeree.mn гээд сайт дээр байгаа. Тэгээд түрүүн мэдээлэл хийхэд нөгөө судлаач маань энийг бол олж харж чадаагүй гэдэг зүйл ярьсан. Тэгэхээр энийг илүү сурталчлах, ил тод байлгах энэ зүйл дээр анхаарах хэрэгтэй. Энэ гэрээ яагаад их чухал ач холбогдолтой вэ гэхээр энэ байгаагүй байх үед нэг байгууллагын удирдлага очоод, морь уралдах гэсэн юм хандив өг гээд уул уурхайн компаниудад ийм шахалт үзүүлдэг. Тэгээд энэ байдлыг цэгцлэх гэж л энийг байгуулсан. Орон нутгийн хөгжлийн санд зөвхөн энэ хандив нь ордог болох зохицуулалт одоогоос .../минут дуусав/

С.Ганбаатар: Асуултад тодруулж хариулъя. 3 Номерын микрофонд Туваан сайд.

Ц.Туваан: Энэ хуулийн үзэл баримтлал, ажлын хэсэг нэлээн ажиллаад 3 ч удаа хуралдаад, энэ ажлын хэсгийн гишүүдэд Бадамсүрэн гишүүн бас ороод ингээд явж байгаа. Тэгээд бид нар энэ дээр бол 100 хувь санал нэгдээд явж байгаа. Тэгэхээр илүү нарийвчлаад тусгаад хэдүүлээ хуулийнхаа үзэл баримтлалдаа оруулаад, зүйл заалт болгож оруулаад явъя. Тантай санал нэг байна.

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн асуулт асууя.

П.Мөнхтулга: Сая тайлангийн ерөнхий дүнг сонслоо. 4 асуулт байна. Тайлан гаргахдаа гэрээний гүйцэтгэлийг аль талаас нь асуусан бэ. Засгаасаа асуусан юм уу. Хурлаас нь асуусан юм уу. Компаниас нь асуусан юм уу. Тайлангийн гүйцэтгэлийг компани бол сайхан л гэж хэлэх байх. Засаг дарга бол ер нь өөрөө гэрээ байгуулчихсан бараг 1 тал учраас гэрээгээ хамгаалах байх. Тэгэхээр энэ гэрээний тайланг хэнээс асуусан юм бэ. Бид нарын өнөөдөр маргаад байгаа гол асуудал бол энэ 42 бол хэтэрхий ерөнхий заалттай. Тэгэхээр энийг Засгийн газар ямар төсөлтэй байгаа юм бэ. Одоо энэ багц хууль өргөн барих гэж байгаа сураг байсан. Энэ дээр яг энэ 42-ын асуудал дээр ямар төсөлтэй байгаа юм бэ. Хуулийн төслийнх нь заалтыг сонсьё.

Хуучин бол энэ бүр Иргэдийн хурлаар шийддэг байсан асуудал. Тэгээд Засаг дарга руу өгчихсөн чинь Засаг дарга маань компанийн талд ажилласан. Ийм асуудлууд зөндөө байгаа. Яг газар дээрээ очоод үзэхээр манай тойргийн иргэд бол хангайн бүс бол бас нэлээн хэдэн чамгүй том уурхайнууд байгаа. Манай Баянхонгор, Өвөрхангай алт, Архангай бас алт. Тэгээд энэ дээр яг иргэдэд очоод наалдчихсан юм байдаггүй байхгүй юу. Тэгэхдээ иргэд уурхайг ашиглуулахгүй гээд тэмцээд байгаа юм байхгүй. Хариуцлагатай байя. Бидэнд нутаг ус, бэлчээрээсээ хасуулж тонуулж байгаа юм чинь бид нарын нийгмийн асуудлыг шударгаар шийдээд өгчих гээд ИНХ, багийн нийтийн хурлаар хэлэлцүүлдэг байсан юмыг нь болиулаад Засаг дарга гээд 1 этгээдэд аваачаад өгчихсөн. Үүнээс болж л бид нар өнөөдөр тайлан нэхээд л маргаан үүсгээд л ийм асуудал болгоод л яваад байгаа юм. Энийг нь хуулийг нь цэгцтэй болгоод иргэдийн оролцоог нь хуучин тэр ИНХ руу нь өгчихвөл энэ асуудал шийдэгдэх процесс нь удаан ч байж магадгүй. Гэхдээ тэрнээс хойш шулуухан явдаг болчихно. Дахиж улс төржихгүй ээ. Иргэд өөрсдөө бүгдээрээ оролцоод шийдчихсэн юм чинь. Тэгэхээр энэ ИНХ руу шилжүүлэх асуудал дээр Засгийн газар ямар байр суурьтай байгаа юм бэ.

4-д нь хангайн бүсийн тойргийнхоо тайланг сонсьё. Яг одоо Байнгын хорооны хурал дээр би бичлэгээр сонсмоор байгаа юм. Тэгээд дараа нь цаасаар авна. Ийм 4 асуулт.

С.Ганбаатар: 4 номерын микрофонд хариулт. Төрийн нарийн бичгийн дарга Жавхланбаатар.

С.Жавхланбаатар: Мөнхтулга гишүүний асуултад хариулъя. 1 дүгээр асуулт хэрхэн дүгнэдэг вэ гэсэн асуулт байсан. Энийг бид нар жил болгон нөгөө гэрээ маань бас хугацаатай байгаа. Тэр давхардсан тоог бас нарийн дараа нь өгч болно. Уулын ажлын тайлангаар жил болгон авч дүгнэдэг гэрээг би хийлгэх гэж байна. Энэ нь бол сум компанитайгаа хамтарсан дүгнэлт гаргаж байгаа юм. Дүгнэсэн гэрээг л манай агентлаг баталгаажуулж хүлээж авч байгаа юм. Өөрөөр хэлбэл талууд гэрээгээ дүгнэсэн байдаг гэдэг ийм хариултыг өгье. Бид нар бол дүгнэлт түрүүн сайдын танилцуулга дээр гарсан. Ер нь 90 орчим хувьтай 2023 оны гэрээг ярьж байна шүү. 2023 оны 173 гэрээний 90 орчим хувь нь дүгнэлттэй байна гэж ойлгож болно.

Шинэ хуульд хэрхэн зохицуулж байна гэж. Шинэ хуулийн үзэл баримтлалыг ажлын хэсгийн Наранбаатар гишүүний ахалсан ажлын хэсэг дээр бас хэд хэдэн удаа ярьсан. Энд зарим гишүүд маань бас орсон байгаа. Үндсэн гол санаа маань ер нь ил тод байх санаачилгыг Монгол Улс 2007 оноос хойш хэрэгжүүлээд явж байгаа. Тэгэхээр түрүүний тэр Бадамсүрэн гишүүний дурдсан iltodgeree.mn гээд та

бүхэн ороод харах юм бол 16 мянган гэрээг ил тод болгосон байгаа. Тухайн компаниудаасаа гаргасан ч байгаа. Өөрсдөөс нь авсан ч байгаа. Орон нутгаас авсан ч байгаа. Өөрөөр хэлбэл энэ гэрээнүүд ил тод веб сайт дээр байршсан байж байгаа. Тэгэхээр хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх дэлхий нийтийн концепцыг бид нар шинэ хуулийн төсөлдөө оруулъя гэсэн энэ үзэл баримтлал дотроо ямар мэдээллүүд, ямар гэрээнүүд ил тод байх вэ гэдгийг хуулийн шинэчилсэн найруулга дотор үндсэн санааг нь тусгаад явж байгаа. Яг таны хэлж байгаа ИТХ-ын оролцооны асуудлыг бол сумын түвшинд нь гэрээг нь байгуулаад, мэдээж сумын Иргэдийн хурлаараа ороод, Засаг дарга нь гэрээ байгуулах эрх нь өгөгдөөд, дараа нь аймаг нь хянаж баталгаажуулдаг байвал ямар вэ. Энэ зүгээр нэг санал шүү. Хувилбар ингэж явж байгаа гэдгийг хэлье.

Хангайн бүсийн тоонуудыг манай холбогдох хүмүүс өгнө.

С.Ганбаатар: 5 номерт хариулт өгье. Нэр усаа хэлээрэй. Протоколд тэмдэглүүлье.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн. Гишүүний асуултад нэмж хариулъя. Үндсэндээ нийт АМГТГ дээр ирсэн 211 тайлангийн хэмжээнд гэрээ дүгнэсэн, дүгнээгүй байгаа тоог сая үндсэндээ Төрийн нарийн бичгийн дарга, сайд 2 маань танилцуулчихлаа. Үндсэндээ гэрээний биелэлт 94,5 . Би танд Архангай, Өвөрхангайн тоог нягтлаад, Баянхонгор 3-ын тоог эргээд танд одоохон гаргаад хэлээдэхье.

С.Ганбаатар: Нягтлаад хэлье. Тодруулж хэлье гэж энэ нэг хурган залиа одоо зогсоогоорой. Энийг ганцхан танай яаманд хэлээгүй шүү. Ерөөсөө бүгдээрээ тэгж байгаад танд хэлнэ. Уг нь их зөв юм. Зүгээр дараа больё ийм луйвруудаа болиорой та нар. Мөнхтулга гишүүн тодруулж асууя.

П.Мөнхтулга: Тэгэхээр юу яасан юм байна. Гэрээний дүгнэлтийг бол ашиг сонирхол нэгтэй талуудаас авсан байна. Засаг өөрөө ИНХ-ын өмнө хариуцлага хүлээж байгаа хүн. Тэгэхээр энэ гэрээний бас нэг тал. Тэгэхээр Засаг, ХХК 2 хуйвалдчихсан байхад хөндлөнгийн хяналт хийж тавьж байгаа ИНХ-аас нь энэ гэрээний биелэлтийг асуух ёстой. Тэгж байж логикийн хувьд зөв болно. Тэгэхгүй үгсэн тохирчихсон 2 нөхрөөс би бүгдийг нь гэж байгаа юм биш. Ийм тохиолдлууд гарна. Энд ашиг сонирхол байгаа учраас. Тэгэхээр энэ гэрээний дүгнэлт чинь 94,5 гэж гарч байна. Тэгэхэд яг энэ асуудлыг Монголын нийт ард түмнээс асуух юм бол 94,5-тай гарахгүй шүү. Тэгэхээр өнөөдөр бодит амьдрал, цаасан дээр байгаа тоо 2 чинь ингээд зөрөөд байгаагийн учир нь энэ байна.

С.Ганбаатар: Мөнхтулга гишүүн тодруулж асуулаа. Туваан сайд хариулъя. 3 номер.

Ц.Туваан: Гишүүнтэй бол санал нэг байна. Тэгээд түрүүн бас Бадамсүрэн гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Энэ хууль дээрээ ажиллаж байгаа. Манай дээр бас 42 дээрээ гаргаж байгаа драфтууд бол байгаа. Тэгэхээр олон талын оролцоо байж байж ил тод байна, шударга байна, нээлттэй байна гэдэг зарчмыг ойлгож байна. Ялангуяа иргэдийн өгөх тэр иргэдийг төлөөлж байгаа сумын Иргэдийн Хурлын төлөөлөгчдийн өгөх үнэлгээ бас нэлээн чухал гэдэг дээр санал нэг байна. Тэгэхээр энэ асуудлыг гэрээг дүгнэхэд оролцогч талууд гэдэг тал дээр бас таны саналыг хуулийн төсөлд оруулаад явъя.

С.Ганбаатар: 5 номерт. 3 аймаг байна шүү дээ. Тэр ард иргэдээс нь асуусан уу. Ард иргэдийнх нь санал бодлоор энэ тайлангаа дүгнэж байгаа юу гэж Мөнхтулга гишүүн асуугаад байхад л тойруулаад л давхиад байх юм. 5 номер сэтгэлд сэр хийтэл нь гоё хариул даа. Намчинсүрэн байх.

Г.Намчинсүрэн: Баярлалаа. Гишүүний асуултад нэмж хариулъя. Үндсэндээ энэ гэрээг ил тод, нээлттэй болгох асуудлыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар оруулж өгсөн байдаг. Энийг нутгийн захиргааны байгууллагатай түрүүний хэлсэн дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар гэрээ байгуулна гээд энийг нь өөрөө гэрээг нь нээлттэй байлгана. Энэ асуудлаар 42.1-д заасан энэ 3 асуудлаараа олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулна гэдэг уг нь яамны зүгээс баримталж байгаа бодлого бол эхлээд эрэмбэлээд, ард нийтээрээ хэлэлцүүлээд, түүнийхээ дагуу гэрээг нь байгуулаад яв. Гэрээ нь өөрөө нээлттэй бай гэдэг зарчмыг л баримталж ажиллаж байгаа.

Түрүүн таны асуултад нэмээд хариулахад Архангай аймаг дээр 9 хайгуул, 15 ашиглалт, Баянхонгор дээр 40 хайгуул, 99 ашиглалт, Өвөрхангай аймаг дээр 33 хайгуул, 24 ашиглалтын .../минут дуусав/

С.Ганбаатар: Тэгээд тэд нар нь харин саяын 42-ын гэрээг хийсэн юм уу, үгүй юу гэж бас тодруулж асууж байгаа шүү дээ. Тэрийгээ нэг хариул даа. Тийм лиценз байна гэдэг мэдээлэл бол хаа сайгүй байгаа шүү дээ. Зүгээр 42-ын гэрээ хийсэн юм уу, үгүй юу. Тэрийгээ тодруулж хэлээрэй. Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: 2024 оны сонгуулиар сумдуудаар олон ард иргэдтэй уулзаад явахад нэг ийм зүйл яриад байгаа юм. Дуудлага худалдаагаар газар нутгийг чинь зарчихсан байна. Жишээлбэл, танай өвөлжөө, хаваржаа, зуслан гээд. Тэгэхээр энэ өмнөх сайдын үед яг энэ журам гаргаад лиценз, хайгуулын лиценз олгож байсан юм билээ. Хайгуулын лиценз олгож байсан. Тэгээд тэр хайгуулын лиценз олгохдоо сонгон шалгаруулалт ч биш юм шиг байгаа юм. Дуудлага худалдаа гэж яриад байгаа юм. Тэгэхээр хамгийн их үнийн санал өгсөн буюу жишээ нь 17 тэрбум, 10 тэрбум, 5 тэрбум гэсэн ийм тоонууд яригдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр өнөөдөр энэ журам яг цуцлагдсан уу. Жишээ нь л бол Хангайн бүсийн тойргоос сонгогдсон гишүүд Алтангэрэл сайд бас танай яам руу энэ журмыг цуцлах ийм саналыг явуулсан. Энэ журмын талаар.

Миний авч байгаа мэдээлэл бол ойрын хугацаанд яг энэ журмаар дахиад дуудлага худалдаа зарлаад, хайгуулын лицензүүдийг олгож байна гэдэг мэдээллийг авсан. Энэ ямар хуулийн хүрээнд явж байна. Энэ Ашигт малтмалын тухай хууль дээр яг энэ байна уу. Яг ийм байдлаар явах юм бол нөгөө бид нарын хэлж байсан, ярьж байсан танай өвөлжөө, хаваржааг одоо ингээд газар нутгийг чинь одоо дуудлага худалдаагаар мөнгөөр зарж байна гэдэг юмыг зогсооно. Тийм юм хэзээ ч байхгүй. Үндсэн хуулийн тэр 3.1 дээр ард иргэдээсээ буюу ард иргэдийн төлөөллийн байгууллага орон нутгийн тэр тусмаа багийн ИНХ-аас санал авдаг байна гэсэн энэ амлалт, яриа нь зөрчигдөж байна. Энэ дээр ямар талаар хариулт өгөх вэ гэдэг ийм асуултууд байна.

С.Ганбаатар: Туваан сайд хариулъя. 3 номер.

Ц.Туваан: Эрдэс баялгийн салбар уул уурхайн ч гэж ярьдаг. Энэ салбарын суурь фундамент бол хайгуул геологийн асуудал байдаг. Манай Монгол Улсад бол

энэ асуудал парадокс буюу гаж үзэгдэл болчихсон байгаа. Тэр нь юу гэхээр яг үнэндээ өнөөдрийн байдлаар бол хайгуулын 600-аад лиценз л байна. Ашиглалтын 1700 лиценз байна. Зүй нь олон улсын жишгээрээ бол 1 ашиглалтын лицензэд 5-6 хайгуулын лиценз ноогдоод, тэгээд тэр хайгуул хийгдэж байж тэр ордуудыг олж илрүүлдэг. Энэ хайгуулын салбар өөрөө маш өндөр эрсдэлтэй рисктэй ийм салбар. Маш олон жуниор компаниуд орж энэ хайгуулыг хийгээд, хөрөнгөө гаргаад, хөрөнгө босгоод хийгээд, дараа нь тодорхой хэмжээний ашигт малтмалыг олж илрүүлээд, энийг нь дараагийн хөрөнгө оруулалтын компаниуд нь аваад явдаг ийм бичигдээгүй хууль гэх юм уу, ийм жишиг байдаг.

Энэ таны ярьж байгаа журам бол 2024 оны 4 сард буюу сонгуулийн өмнө бол зогссон. Засгийн газар дээр шийдвэр гаргаад, тухайн үеийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар зогссон байсан. Тэгээд энэ танд байгаа мэдээлэл бол үнэн. Энэ асуудал бол сэргэсэн. 2025 оны 3 сарын 1-ээс эхлээд энэ хайгуулын лицензийг олгох журам батлагдаад, энэ журмыг хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлээд, энэ журам сэргэсэн. Дуудлага худалдаа биш сонгон шалгаруулалтын буюу тендерийн байдлаар явж байгаа. Өмнөх үйлчилж байгаа зогссон журмыг тодорхой хэмжээнд сайжруулаад, хууль дээр байгаа заалтын дагуу энэ үйл ажиллагаа явагдаж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд сая бас бид нар Архангай аймагт хангайн бүсийн анхдугаар чуулга уулзалт хийсэн. Бүх босож үг хэлж байгаа Засаг дарга нар, аймаг, сумын Засаг дарга, удирдлагууд бүгдээрээ л энэ дэд бүтэц, нийгмийн асуудлаа шийдье, зам тавиулъя, хөрөнгө оруулалт гэж байгаа. Тэгээд 1 амаараа яг ингээд иймэрхүү байдлаар бид нарт хөрөнгө хэрэгтэй байна. Асуудал шийдэх хэрэгтэй байна гэххээд, нөгөө талаараа ингээд 93 хувийн экспортын орлоготой энэ салбараа хөгжүүлэхгүй, дэмжихгүй гэдэг энэ зүйл бол ийм хоорондоо логикийн хувьд ч тэр маш зөрчилдөөнтэй ийм зүйл байгаа. Тэгэхээр энийг бол бид нар ард иргэдэд буруу өгөхөөсөө илүү энэ хуульдаа АМНАТ-ийн хуулийн менежмент дээрээ энэ зохицуулалтыг хийж өгөхгүйгээс болсон гэж ингэж үзэж байгаа.

Үеийн үед алтыг нь аваад, авдрыг нь хоосон хаясаар байгаад нөгөө хүмүүст юу ч наалдахгүй болохоор уул уурхайн салбарыг дэмжихгүй гэдэг ийм нийтлэг хандлага бий болсон. Тэгэхээр энийг бид хэд хууль дээр засаж өгч байж энэ хандлага өөрчлөгдөж явна байх гэсэн ийм бодлоготой ... /минут дуусав/

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн тодруулж асууя.

Д.Жаргалсайхан: Тэгвэл ингээд баахан хайгуулын лиценз олголт явах юм байна. Энэ дээр бол томоохон мөнгөн дүнгүүд гарах байх, яригдах байх. Тэгэхээр мөнгөн дүнгээр зарж байна л гэж ойлгогдоно. Энэ мөнгөн дүнгээс яг тухайн тэр айлын өвөлжөө, хаваржаа, бэлчээр бол ойлгомжтой худалдаж авч байна гэсэн ойлголтыг малчид ойлгоод байна. Энэ мөнгөнөөс тэр малчид ард иргэдэд очих хувь буюу яг тэр журам дээр тусгагдсан зүйл байна уу. Мөнгө олгогдох уу. Нөхөн төлбөр олгогдох уу. Яг саяын өөрийн чинь ярьж байгаагаар тэр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн хувилбарууд яригдаж байна. Энэ дээр бол тэр АМНАТ-аас айл өрхүүдэд олгогдоно. Тэр бэлчээр нутаг нь орж байгаа айл өрх бас хажууд нь юу гэдэг юм нөлөөллийн бүсэд байгаа айл өрхүүд ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ хууль чинь бол гараагүй байгаа хууль шүү дээ. Тэр хуулийг гартал энэ хайгуулын лицензтэй холбоотой, энэ журамтай холбоотой ард иргэдийн тэр нөлөөлөлд орж байгаа бүсэд ... /минут дуусав/

С.Ганбаатар: Санал хэлсэн үү. Асуулт байсан уу. 3 номер Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Энэ яг өнөөдрийн байдлаар хуулиар таны ярьж байгаа асуудал бол зохицуулагдаагүй байгаа. Үнэн. Мэдээж энийг бас зохицуулах ёстой юу гэвэл ёстой. Орон нутгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд бол энэ асуудлыг маш хүчтэй хөндөж тавьж байгаа. Ялангуяа энэ уул уурхайн олборлолт явуулж байгаа түгээмэл дийлэнх явуулж байгаа аймаг сумуудад энэ асуудлыг маш хүчтэй тавьж байгаа. Тэгэхээр ирээдүйд гарах ашигт малтмалын батлагдах хуулийн шинэчилсэн найруулга дээр бол энэ асуудал бүр тодорхой заалт болж орно. Орон нутагт нь ямар хувь юм. Аймагт нь яах юм. Сумд нь яах юм гэдэг энэ асуудлууд бол заагдаж орно гэдгийг хэлье.

Мөн үүнтэй холбогдуулаад Засгийн газар дээр яригдаж байгаа асуудал бол Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2019 оны үндсэн хуулийн дагуу 2024 онд батлагдсан. Энэ хууль дээр 3 сан байхаар Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гээд энэ .../минут дуусав/

С.Ганбаатар: Туваан сайд тодруулж хариулъя. 3 номер.

Ц.Туваан: Энэ сангууд дээр энэ уул уурхайн баялгийг олборлосны АМНАТ гэж ярьж байгаа энэ төлбөр нь Тогтворжуулалтын санд ороод, тэндээсээ гарч ирсэн АМНАТ-ын хувийн 65 хувь нь Ирээдүйн өв санд ороод, 35 хувь нь бол хуримтлалын санд орох байдлаар хуульчлагдсан байгаа. Тэгэхээр ард иргэд юу ярьж байна гэхлээр уул уурхай ашиглаад байдаг. Энэ одоо ашигласны мөнгө, ашиг, үр дүн чинь бид нар дээр амьдралд ирж нөлөөлөхгүй байна. Ялангуяа орон нутагт бүр цаашлах юм бол энэ баялгийн сангийн хуваарилалт байдлаар иргэдэд дорвитой ийм наалдахгүй байна гэдэг маш их зүйл ярьж байгаа учраас Засгийн газар дээр Үндэсний баялгийн сангийн, Ирээдүйн өв сангийн, АМНАТ-ийн 65 хувийн тодорхой хувийг эхний төслөөрөө бол 20 хувийг орон нутгийн санд өгөхөөр нөгөө хууль батлагдахаас өмнө шийдвэр гарах байдлаар ярилцагдаж байгаа гэдгийг танд хэлье.

С.Ганбаатар: Үндсэндээ гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Надад асуулт байна. Ерөнхийдөө энэ хуулийн хэрэгжилтийг Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйл дээр заасан байгаа. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг нь 10.1.3 дахь заалтад Ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах гэж заасан. Танай яам 100 хувь хариуцаж байгаа. Үр дүн нь юу гээч. Та нарын оруулж ирж байгаа асуудал нь. Монгол оронд 2740 лиценз байгаа. 2740 лиценз байна. Энэ чинь ганцхан ашиглалтынх биш шүү дээ. Хайгуулынх ч гэсэн ярина. Энэ дотроос 2740-147 гэрээ дүгнэгдэж, 173 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 147 гэрээ дүгнэгдсэн 95,7 хувийн хэрэгжилттэй байна гэж хүн хуурч байгаа юм уу та нар. Туваан сайд бол үнэхээр ажлын төлөө явж байгаа. Үгүй ээ, та нар хариуцлагаа тооц л доо. 2740 шүү дээ. 1 дүгээрт хариулаарай дараа нь.

2 дугаарт аймгийн Засаг дарга нарт яг энийг орон нутаг дээрээ хэрэгжүүлэх хуультай. Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан байгаа шүү. Би өөрөө сайдтай 2 удаа уулзсан. Энэ асуудлаар нэг дорвитой үр дүн гаргая. Та нар бол зүгээр л Монголын ард түмнийг үл ойшоож байгаа. Яам, аймгийн Засаг дарга 2 бол ерөөсөө бичиг ирүүлдэггүй. Сумдаас ирэхээрээ зэрэг

сумдаас ирж байна. Үгүй ээ, энэ баялаг чинь бидэнд ерөөсөө ямар ч ашиг алга. Зогсоогоод өгөөч л гэсэн баахан юм ирэх юм. Ард иргэд нь бас нээрээ манай нутаг ямар баян юм бэ. Юм битгий олдоосой гэж залбирдаг болсон. Яагаад гэвэл ард түмэнд ямар ч ашиггүй. Та нар яг энэ иргэний дайн шиг юм болгож байгаа нь та нар өөрсдөө шүү дээ. Яамны холбогдох хүмүүс нь энэ дээр хариуцлага үүрэх үү. Энэ чинь та нар өөрсдөө энийг хийгээд байна шүү дээ. Ард иргэдтэйгээ гэрээ байгуулаарай гэж байгаа юм.

Би энэ хуулийн заалтыг уншъя. Би та нарт маш энгийн юм уншъя.

42.1-д тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

42.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ гэрээгээ байгуулахдаа олон нийтийн хэлэлцүүлэг явуулна. Юу ч хэлэлцүүлээгүй та нар.

42.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчдийг иргэд дундаасаа сонгон шалгаруулж ажиллуулна. Өнөөдөр хүртэл юу ч байхгүй.

4-д нь энэхүү гэрээ олон нийтэд ил тод байна гэж байгаа юм. 7 уулын цаана аваачаад нуучихсан байгаа юм шүү дээ та нар. Үгүй ээ, энэ чинь аймгийн захиргааны өмнө хулдаасан самбар дээр гаргаад тавьчихад хэдэн төгрөг болох юм бол юу ч хийгээгүй энэ дээр. Би тэгээд л хэд хэдэн Архангай, Өвөрхангай, Баянхонгор гээд 10-аад аймаг руу явуулсан. Засаг дарга нар нь таг. Тэгээд юм олдог эх үүсвэр нь л биш байлтай юм. Таг. Яагаад ийм нөхцөлтэй байгаа юм бэ. Яагаад энэ гэрээг яг ард түмэнд ил тод болгох тал дээр орон нутгийн тэр ард иргэдийн төлөөллийг оролцуулах тал дээр анх энэ чинь гэрээг бол Норвэ фанд гэж төсөл хэрэгжиж байж энэ загвар нь байгуулсан шүү дээ. Загвар сайн шүү дээ. Загвар нь гайгүй шүү дээ. Та нар хэрэгжүүлэхгүй хумсаа тас нууж байгаа байхгүй юу. Яагаад ийм байдалтай байгаа юм. Энэ дээр хариуцлага тооцох уу та нар. Хэзээ үр дүн гарах вэ. Миний ийм 3 асуултад би хариулт авъя. Туваан сайд 3 номер.

Ц.Туваан: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Энэ нөгөө юу л даа. Хайгуулын 900 гаруй лиценз, ашиглалтын 1700 хэдэн лиценз нийлээд 2740 гэдэг тоо гарч байгаа. Энэ дундаас бид нар тайлан юмаа нэхээд, тоо бүрдүүлэх юм өгөхөөр 100 хэдэн компани өгч байгаа. Бусад нь икс тайлантай. Бид нар ашиглаагүй, бид нар ажиллаагүй. Үйл ажиллагаа явуулаагүй гээд өгчхөж байгаа учраас энэ дүгнэлт ингэж бага хувьтай гарч байгаа шүү. Өгсөн хүрээнд нь бол тэр 90 хэдэн хувийн гүйцэтгэл гарч байгаа гэдгийг хэлье.

Таны хэлсэн тэр хуулийн 42.1 болон түүний дагалдах заалтуудыг бол хэрэгжүүлэх үүрэг бид нарт байгаа. Засгийн газарт байгаа. Мөн орон нутагт байгаа. Бид бүхэн орон нутгийн удирдлагуудтай, Засаг дарга нартай, аймгуудын Засаг дарга нартай гэрээ байгуулж ажилладаг. Тэр дээр дурдаад, үүрэгжүүлдэг. Аймаг очоод сумдын Засаг дарга нартаа үүрэгжүүлдэг. Яг өнөөдөр бол бодитойгоор орон нутаг дээр бас бид нар дээр энэ хэрэгжилт дээр бол маш хангалтгүй ажиллаж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг яригдсан ажлын хэсэг дээр бас үүний хариуцлагажуулах, ямар хариуцлага тооцох вэ энэ тэр гэдэг асуудлыг бас

нэлээн нарийсгаж өгөхгүй бол бид нарт ч гэсэн өгөхгүй. Яамны хувьд бол орон нутагт яг нэг салбарын хяналтын байцаагчаас өөр гар хөл байхгүй, өөрсдөө шууд яваад бүгдийг нь энэ тайлан юмаа авах боломж байхгүйтэй холбоотой бас нэлээн асуудал байгаа гэдэг зовлон тоочиход ийм байна.

Мөн яах вэ, орон нутгийн тэр энэ гэрээ бүгдээрээ бас муу бас хэрэгжихгүй бай байгаа биш. Бидэнд байгаа тоогоор өнөөдөр 12240 иргэнийг орон нутгаас нь ажлын байраар хангасан гэсэн ийм статистик тоо байгаа.

С.Ганбаатар: Үгүй ээ, мөн том харж үзэж байна аа. Хамгийн гол нь энэ сайхан буянаа яагаад нуугаад байгаа юм бэ л гэж асуугаад байгаа шүү дээ. Тэгээд таны хариултад бол 147 гэрээ байгаа. Бусад нь бүгд икс тайлантай гэж байгаа юм байна шүү дээ. Монгол орон 147 уурхай л ажиллаж байгаа юм уу. Икс тайлантай бол энэ 42-ын гэрээг байгуулахгүй гэсэн хууль байхгүй шүү.

2 дугаарт миний тодруулж асуух ёстой асуулт би хариултаа авч чадсангүй. Юу гэвэл энэ яагаад ил тод байхгүй байгаа юм. 147 яг хаана байгаа юм. Тэрийг би бүр 1 сарын 3-нд та нар луу захидал явуулсан. 1 сарын 3-нд гэрэл зургаар олон нийтэд ил тод байна гэсэн тэр юмаа яаж хангасан юм бэ. Гэрэл зургаар явуулаач гэж байгаа. Надад 1 ч хариу ирээгүй. Энийг чинь ард иргэдийг зүгээр та нар бол дээрэлхэж байна гэсэн үг шүү дээ. Тэр баялгийн эзэд шүү дээ. Үндсэн хуулиа биелүүлэе л дээ. Тэгэхээр энэ дээр 42.1, 2, 3, 4, 5-д нь юу гэж заасан гээч бүр гоё юм заасан шүү дээ. Энийг хэрэгжүүлээгүй бол хариуцлага тооцоорой гэж заалт байгаа шүү дээ. Үүний хэрэгжилтийг хэзээ би авч болох вэ. Та нарт юу ч байхгүй л дээ одоо бол. Тэгээд Ажлын хэсэг байгуулахад энийгээ найдвартай өгч чадах уу. 4 номер.

С.Жавхланбаатар: Ганбаатар даргын асуултад хариулъя. 1 дүгээрт гэрээнүүд ил тод байгаа юу гэж байна. Гэрээнүүд iltodgeree.mn гэдэг веб хуудсан дээр байгаа.

С.Ганбаатар: Тэр нь олон нийтийн өмнө гэж үзэж байгаа юм уу.

С.Жавхланбаатар: Ямар ч байсан бид нар ил тод. Энэ бүх гэрээнүүдийг та бүхэн татаад авч болно. Зөвхөн 42.1-д заасан гэрээнүүд ч биш, 1214 гэрээ байна. Одоогоор энэ жагсаалтад.

С.Ганбаатар: Би 42-ыг л асууж байгаа.

С.Жавхланбаатар: 42-ыг нь түрүүн бид нар хариулсан.

С.Ганбаатар: Ард иргэдтэй байгуулах ёстой гэрээгээ л асууж байгаа.

С.Жавхланбаатар: Ил тод байгаа гэдгийг нь хариуллаа.

С.Ганбаатар: Тэгээд тэр интернэт дотор нуучхаад, тэгээд л ил тод, үзэхгүй яасан юм хохь нь гэдэг юмаа больё доо хэдүүлээ. Миний асуулт асуух юм дуусчихсан байх.

Гишүүд асуулт асууж, хариултаа авлаа. Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. 2 гишүүн үг хэлэхээр өгсөн байна. 3 гишүүн. Ингээд Бадамсүрэн гишүүн, Жаргалсайхан гишүүн, Замира гишүүн үг авсан байна. Замира гишүүн үг хэлнэ.

С.Замира: Баярлалаа. Яамны хийж байгаа ажлын талаар сонслоо. Яам бол нэлээд ажил хийж байгаа юм байна. Тэгэхдээ бас өчнөөн жил удсан энэ ажлыг нэгмөсөн шийднэ гэж амархан биш байх. Тэгээд манай Их Хурал, Байнгын хороо бас ажлын хэсэг байгуулаад хамтран ажиллая гэсэн хүсэлт ирүүлчихсэн байгаа. Тийм учраас бид нар ажлын хэсэг байгуулна. Тэр ажлын хэсэг нэлээд гишүүд орж ажиллах гэж байна. Тийм учраас яамных нь ажлын хэсгийн гишүүдтэй хамтран ажиллаж, тухай бүр судалгаа гаргаж өгч тусална байх. Хамтдаа ажиллах байх гэж би найдаж байна. 1 дүгээрт.

2 дугаарт болохоор энэ лицензүүд нэг хэсэг нь хөдлөөд, нөгөө хэсэг нь дандаа икс тайлан гээд яриад байна шүү дээ. Миний эхнээс нь яриад байсан юм чинь яагаад тэр компаниудын үйл ажиллагаа нь зогсонги байдалд байна гэдгийг манай ажлын хэсэг бас давхар судалгаа хийсэн нь дээр байх. Тийм учраас тэр лицензийг аваад байж байх биш, яг одоо эдийн засгийн хямралтай үед эргэлтэд оруулах тал дээр бас бид нар хамтран ажиллах байх гэж найдаж байна. Тийм учраас бидний тухайн үед хийсэн бүх судалгаа, асуусан судалгаа бүх юман дээр та нар яаралтай тухай бүр хариу өгч байхыг хүсье. Хамтран ажиллахад бэлэн байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Замира гишүүн ажлын хэсэг байгуулах саналыг бас гаргаж байна. Жаргалсайхан гишүүн үг хэлнэ.

Д.Жаргалсайхан: Энэ хайгуулын лиценз олголт бол дараа нь тэгээд хэдэн 10 жилийн дараа яригддаг асуудал л даа.Одоо тэгээд Туваан өгсөн юм байгаа юм. Энэ АН-ынхан өгсөн юм байгаа юм. Энэ тойрогт юу гэдэг юм, сумын Засаг дарга байх үедээ өгсөн байгаа юм. Энэ аймгийн Засаг дарга байхад өгчихсөн. Манай өвөлжөө, хаваржааг ингээд өгчихсөн. Одоо манайх үр удмаараа олон жил амьдарч ирсэн, одоо дууссан гээд сум дээр яг үнэн чанартаа аймгийн Засаг дарга нь, сумын Засаг дарга нь, Улсын Их Хурлын гишүүд нь эсэргүүцээд байгаа юм ерөөсөө биш. Тухайн сумын малчин үр удмаараа тэнд амьдраад, өвөлжөөд, хаваржаад ирсэн учраас л тэр хүмүүс тэр газар нутгаа сүйдлүүлчихлээ, бид нар энэ газар нутагтаа эзэн байж чадсангүй гэдэг л насан туршийн гомдол байдаг байхгүй юу.

Тийм учраас тэр журамд тэр мөнгө төлөөд тэр газрыг авч байгаа бол тэр айл өрхөд, тэр нөлөөллийн бүсэд байгаа айл өрхүүдэд нь тодорхой хувийг нь олгочихвол тэр хүмүүсийн тэмцэл, эсэргүүцэл, тэр эсэргүүцэл нь тэр сумынх болж, багийнх болж тэр сумаа, тэр удирдлагуудаа шахаж, аймгаа шахаж байгаа байхгүй юу. Тэгээд ийм байдлаар гишүүд нь хүртэл яг иргэдийнхээ талд орохоос өөрцгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр ийм байдлаар тэр журмаа эргэж харвал яасан юм бэ. Тэр төлбөр мөнгө орж ирдэг бол тэр төлбөр мөнгөнөөс тодорхой хувийг нь тэр малчин өрхөд, тэр нөлөөллийн бүсэд байгаа айл өрхүүдэд өгвөл яасан юм бэ. Ер нь цаашдаа хайгуулын лицензийг олгохдоо АМНАТ гээд ярьж байна. АМНАТ чинь яг үнэн чанартаа аймаг, суманд л орж байгаа шүү дээ. Яг тэр тухайн малчинд очихгүй байгаа шүү дээ. Тэгээд энэ юмыг хэдүүлээ аль аль талаас нь ухаалгаар харахгүй бол ийм л асуудал болчихоод байдаг юм. Би орон нутагт ажиллаж байсан, орон нутгаас сонгогдсон гишүүний хувьд хэлэхэд би дургүйцээд байгаа юм

ерөөсөө биш, сонгогч дургүйцээд байна шүү дээ. Тэр айл дургүйцээд байна шүү дээ.

Тэгэхээр энэ асуудлыг шийдэх юмыг та хэд маань бодож үзээч ээ.

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн үг хэллээ. Саяын чухал ажил хэрэгч саналуудыг бас та нар ажилдаа тусгаж ажиллаарай. Мөнхтулга гишүүн түрүүн бас үг хэлнэ гэж саналаа өгсөн шүү. Бадамсүрэн гишүүн үг хэлье.

М.Бадамсүрэн: Энэ орон нутгийн гэрээний үйлчлэлд зөвхөн ашиглалтын тусгай зөвшөөрөл дээр л гэрээ байгуулах нь зөв. Яг амьдрал дээр. Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн 1 дүгээрт уулын ажлын төлөвлөгөө гэж батлуулахгүй, 2 дугаарт тийм орон нутагт дэд бүтэц, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар тийм нэмэр болж чадахгүй шүү дээ. Тэгэхээр энэ бол ерөөсөө оновчтой зохицуулалт биш байгаа юм. Тэгэхээр нөгөө шинэчилсэн найруулга дээр хуулийн зөвхөн ашиглалтын тусгай зөвшөөрөл гэж оруулж өгөх тал дээр бас манай яамны ажлын хэсэг бас анхаарч өгөөч гэдгийг хэлье.

2 дугаарт нь гэрээг нэг талаас аймаг, сумын Засаг дарга, нөгөө талаас тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, төлөөллийн удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх удирдлага гэж ялгаа заагтай, бүр тодорхой тавьж өгөх нь бол хамгийн зөв гэж бодож байгаа юм.

3 дугаарт нь нутгийн захиргааны байгууллагыг төлөөлж гэрээ байгуулах, хэлцэл хийх ажлын хэсгийг яаж байгуулах вэ гэдэг зохицуулалт энэ хууль дээр байхгүй байгаа. Тэгэхээр энийг бол тухайн шатын Иргэдийн хурлаас нь Засаг даргынх нь өргөн мэдүүлснээр ажлын хэсгийг нь байгуулж өгөх хэрэгтэй. Яагаад гэвэл нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын оролцоог хангаж, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хяналтыг сайжруулах чиглэлээр оруулах ийм зохицуулалттай гэж үзэж байгаа.

Хандив тусламжийг бол Төсвийн тухай хуулиар зөвхөн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж байгаа. Орон нутгийн хөгжлийн сан өөрөө тусгай хууль журмаар зохицуулагддаг учраас 1 дүгээрт нийтийн эрх ашигт нийцсэн, 2 дугаарт ард иргэдийн санал авсан ийм ажлыг санхүүжүүлнэ гэж заасан байгаа.

Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр энэ хандив тусламжийн орлогыг юунд зарцуулах вэ гэдгийг бас зааж өгөх хэрэгтэй. АМНАТ-ийн орлогыг ч гэсэн. Тэгэхгүй бол ингээд баахан орлого олдог, нөгөөдхөөрөө баахан албан тушаалтнуудын жийп машин авчихвал яах вэ. Тэгэхээр энийг нөгөө зохицуулалт нь ингээд дараагийн гарч болзошгүй ийм сөрөг гэж хэлж болох зүйлүүдийг хаах байдлаар энийг энэ нутгийн захиргааны байгууллагатай харьцах гэдэг хэсэг дээр нэлээн сайн ажиллаж, энийг гарч болзошгүй сөрөг зүйлүүдийг хааж явъя. Илүү сайжруулах тал руу нь явъя гэдэг саналаа л би хэлээд байгаа юм.

Тэгээд энийг бас та бүхэн өнөөдөр нэгэнт цаг зав гаргаад, Байнгын хорооны гишүүд, тэгээд Байнгын хорооны хурал, сайд, төрийн нарийн, холбогдох газар хэлтсийн дарга нар гээд байгаа үедээ энэ яг яригдаж байгаа зүйлүүдийг маш сайн анхаарч, энийг бас ажил болгож явахгүй бол цаг бидэнд бас үнэтэй байна.

Тэгээд ер нь энэ ташрамд хэлэхэд яамдаас байн байн ингээд мэдээлэл аваад байх нь ямар байдаг юм бол доо. Нэгтгэж байгаад 1 сайн авмаар байна. Тэгэхгүй бол ер нь их ойрхон ойрхон авч байна. Буруу ч юм байхгүй л дээ. Гэхдээ сайн мэдээлэл өгөөд, түргэн түүхий биш, сайн шийдвэр гаргаад яваад байвал илүү оновчтой юм уу л гэж бодож байна. Тийм учраас түрүүний ажлын хэсэг байгуулах дээр нухацтай хандаж, юмыг ингээд хийвэл хийсэн шиг хийе л гэж байгаа юм. Баярлалаа.

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн үг хэллээ. Мөнхтулга гишүүн үг хэлье.

П.Мөнхтулга: Түрүүн Туваан сайд ярьж байсан. 90 хувийн экспортын бүтээгдэхүүн маань уул уурхай гээд. Тэгээд ганц хоол олж идэж байгаа салбараа иргэд хооронд нь талцуулаад, энэ бүх асуудал чинь ерөөсөө энэ 42 байхгүй юу. Бид нар иргэдээ оролцуулаад энэ гэрээнд нь иргэдийнхээ төлөөлөл, сумаас нь, багаас нь энэ чинь А лиценз дээр л яригдаж байгаа юм шүү дээ. Ашиглалтын лиценз гэдэг чинь нөөц нь тодорхой болчихсон. Олох орлого нь тодорхой болчихсон. Тэгээд энийгээ нээлттэй тавиад, үүнээсээ бид нар тэдэн хувийг нь зардал болгох юм. Гарсан ашгийнхаа тэдэн хувийг нь суманд, дэд бүтэц шийднэ, нийгмийн асуудал шийднэ, ажлын байр бий болгоно гэдгээр процесс нь уддаг байж магадгүй. Яадаг юм. 1 удаа хийгээд л энэ гэрээг хүлээн зөвшөөрөгдсөн бүх талууд хүлээн зөвшөөрөгдсөн гэрээ л болчих юм бол цаашаа уул уурхайн салбарт ч муу нэр орж ирэхгүй. Цаашаа манай уул уурхайн салбар улам хөгжөөд явна. Түрүүн Төрийн нарийн хэлж байна лээ. Асуудлыг бид нар шилэн тунгалаг байх дээр их анхаарч байгаа гээд. Шилэн тунгалаг байна гэдэг чинь анхнаасаа энэ гэрээг иргэд нь мэдэж хийхийг л шилэн тунгалаг байгаа болохоос биш, Засаг дарга, компани 2-ын хийчихсэн гэрээг интернэтэд тавих биш байхгүй юу. Тэгээд яах юм, хэрүүл л болно шүү дээ. Эцэс төгсгөлгүй нөгөө уул уурхай дээр ирээд байгаа иргэдийн бухимдал чинь цаашаа л үргэлжилнэ шүү дээ. Тэгэхээр анхнаас нь шилэн тунгалаг байгаад, мэдэх эрхийг нь өгөөд өнөөдөр хууль D-parliament дээр яваад л болоод л байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр гэрээнийхээ төслийг анхнаас нь нийтээр хэлэлцүүлдэг 14 хоногийг нь тавьж өгөөд, сумын хурлаар хэлэлцүүлдэг хугацааг нь тавьж өгөөд, ингээд анхнаас нь шилэн тунгалаг болоод явах юм бол уул уурхайн нэр хүнд унахгүй, иргэд бухимдахгүй, Засаг дарга авлигын хэрэгт орохгүй, тэр компани ч гэсэн олох ашиг нь тодорхой гэнэтийн улс төрийн халдлагад өртөхгүй. Шилэн тунгалаг гэдэг юм чинь анхнаасаа л шилэн тунгалаг байж байж бүтнэ. Тэгэхээр дунд нь булингар орж ирэхлээр цаашаа бүх юм булингар болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ шилэн тунгалаг байдлыг л энэ хууль дээрээ хийж өгөхийг зөвлөж байна.

Тэгээд хамгийн гол асуудал бол энэ 42-ын заалтыг маш тодорхой, бүх процессыг нь хугацаатай, биелүүлэхгүй бол яах юм гэдэг санкцтай нь төсөл дээрээ оруулж ирье гэж хэлье. Баярлалаа.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн үг хэлье.

Л.Мөнхбаясгалан: Говийн бүсийн зовлон ихээ. Бас ашигт малтмал ихтэй, Монголын стратегийн ордууд байдаг. Манай Дорноговь аймаг гэхэд л Хатан булаг, Даланжаргалан, Айраг, Иххэт, Дундговь гэх юм бол Өндөршил, Баянжаргалан, Өмнөговь гэх юм бол Мандал-Овоо, Гурвантэс, Цогтцэций, Ханбогд гээд маш олон нөлөөллийн бүсэд амьдардаг ийм сумуудтай. Улсын төсөвт 1,7 их наяд төгрөгийн

орлого төвлөрүүлдэг. Тэгсэн хэр нь хүн ардад нь, яг нутгийн иргэдэд нялзсан юм байдаггүй. Сумын засаг дарга ч юм уу, гоё гоё юм яриад, манай суманд ийм ийм юм хийгдээд байгаа гэдэг боловч, яг тухайн амьдарч байгаа иргэд ямар ч тийм сэтгэл ханамжийн баталгаагүй, цаашдаа яг тэр сумдаа, тэр багтаа сайн сайхан амьдарна гэсэн бололцоогүй. Яагаад гэвэл нүүлгэн шилжүүлэлтэд өртдөг байхгүй юу. Тэгээд тэр одоо өгч байгаа өвөлжөө, хаваржааны жаахан мөнгө төгрөг өгөөд л байгаа юм. Энийг илүү бүр нөгөө хүмүүсийн эрүүл мэнд, ирээдүй баталгаа гэдэг талаас нь ерөөсөө харахгүй байгаа. Нөлөөллийн бүс гэдгийг тогтоохгүй, нөлөөллийн бүсийн хууль л хэрэгтэй болчихоод байгаа юм л даа. Тэгэх юм бол энэ дээрээ дахиад хуульчилмаар санагдаад байгаа. Жишээ нь, Цогтцэций сум дээр Цагаан-Овоо баг нүүсэн. Монголын төрөөс 5 жил гуйсан. Бид нарыг эрүүл мэндийн үзлэгт оруулаад өгөөч гээд. Одоо Цогтцэций сум газар нутаггүй шүү дээ. Одоо сумаараа мөдхөн нүүлгэн шилжүүлэлтэд өртөх байх л даа. Тэгэхээр наад АМНАТ гэдгээс юм уу эсвэл Жаргалсайхан гишүүний тэр хайгуулын дуудлага худалдаанаас гэдэг юм уу бодитоор хүмүүст хүрэх юм хийхгүй бол нутаг оронгүй болоод, манай говийн бүс бол үүцээ нээснийхээ төлөөсөнд бүгдээрээ амьдрах газаргүй болоод говиороо нүүх боломж бүрдээд байна шүү дээ.

Дээрээс нь усгүй болсон. Байгаль орчин, амьдрах нөхцөл байдал нь доройтчихсон ийм байгаа юм. Тэгэхээр Жаргалсайхан гишүүний саналыг дэмжиж байгаа. Энэ тал дээр бас та бүхэн харж, сайн бодож, бодлогоо боловсруулж ажиллаарай гэж хүсье.

Тэгээд Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэгт байгаа болохоор бас энэ тал дээр анхаарч ажиллана. Хамтарч ажиллаарай гэж хүсье.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн чухал үг хэллээ. Би үг хэлээд, тэгээд ажлын хэсэг байгуулах юм байна. Ажлын хэсэг дээр нэлээн чамбай бас дүгнэлтүүд гарах байх. Ажлын хэсэг дээр бас хамт олон нэлээн хичээж ажиллах байх. Ер нь ажлын хэсэг байгуулахгүй л бол түрүүн тэгээд хойшлуулж байгаа хүмүүс нь гэрээнийхээ тэр Онтре-ийн мэдээллүүдийг хариуцаж авчирна шүү. Эзэн биегүй хаяна гэдэг бол эс үйлдлээрээ бас л тэгээд үйлчлээд л байгаа хэлбэр шүү дээ. Тэгээд ажлын хэсэг байгуулахыг хичээж байна.

Миний хэлэх 2 үг байна. Хамт олон алтыг нь аваад, авдрыг нь хаях гэгчээр ивийлээд эдийг нь авах, өрөвдөөд өрхийг нь бүтээх гэгчээр л ядарсан хэдэн малчид, ард иргэдийг бол ёстой дээрэлхэж байна даа. Тэдэнд юу өгөх юм, яах юм гэдэг гэрээгээ хийгээрэй. Хэлэлцээрээ хийгээрэй гэж л энэ 42-ыг заасан. Та нарын хамгийн дургүй сэдэв. Хамгийн ярих дургүй сэдэв. Энэ дээр ажлын хэсэг байгуулж, Улсын Их Хурлын гишүүд нь бас жоохон анхаарах байх.

Тэгээд компани, яам 2 нь иргэдийг яая даа байз. Ёстой нэг зовоож байна л гэж халаглаад байдаг. Үндсэн хууль дээр уг нь бол 6.1 дээр газрын хэвлийн баялаг “гагцхүү” гэж үг байгаа юм шүү. Гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна гэж байгаа юм шүү дээ. Тэрнээс биш яам, компани 2-т өгсөн юм биш шүү дээ. Тэгээд явж явж энэ хууль хэрэгжихгүй болохоор компанийн хэдэн нөхдийг л одоо хэдэн дарга нарын аманд аваачиж өгөх гэж байгаа юм шүү дээ. Тэгээд л иргэд нь уурлаад байдаг. Энийгээ хэдүүлээ хэрэгжүүлэх талаар сайхан ажиллая. Та нар маань бас их хүнлэг байна гэж бодож байна.

Туваан сайд бол энэ дээр хийх гээд л үгүй ээ мөн хичээж байгаа байх. Манай яам бол цус ойртчихжээ. Та нар жоохон ухаантай царайтай байвал уг нь буян болно доо. Жавхланбаатар яагаад инээгээд байна. Инээд нь хүрээд байна уу, үгүй юу. Инээд нь хүрээд л, ард түмэн цаана чинь уйлж байна. Аймар хэцүү байгаа. Манай нутагт битгий баялаг олдоосой гээд л залбираад байна.

Тэгэхээр өнөөдөр энэхүү ашигт малтмал яаж ард түмэнд ашигтай байлгах вэ гэдэг гэрээ хэлэлцээр хийх ёстой Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн биелэлтийг хангуулах, биелэлт ер нь хэр явж байна вэ гэдэг мэдээллийг бид сонслоо. Маш аятайхан мэдээлэл өглөө гялайлаа.

17.18 цаг.

Ингээд дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. **4 дэх хэлэлцэх асуудал бол саяын энэ ярьсан асуудал дээр Ажлын хэсэг байгуулах тухай.**

Бас хойшилчихвол тэгээд л энэ уйлаан майлаан бас цаашаа яваад байна л гэсэн үг байх. Ингээд та бүхэнд тараагдсан. Би танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1.Ашигт малтмалын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн биелэлтийг хангуулах болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нутгийн захиргааны байгууллагатай хэрхэн харьцаж байгаа асуудлын талаар холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийг ахалж, нэлээн хэд хоногийн өмнө саналаа надад өгсөн шүү. Замира гишүүн бичгээр өгсөн байгаа. Лүндэг гишүүн бас энэ ажлын хэсэгт бас оръё гэж байна. Өөр саналтай гишүүн байна уу. Уянга гишүүн байна, Бадамсүрэн гишүүн байна, Жаргалсайхан гишүүн байна, Мөнхбаясгалан гишүүн энэ 42 шүү дээ. Мөнхтулга гишүүн орж байгаа юм байна. Жангабыл гишүүн орж байгаа юм байна. Зөвхөн 42 шүү. Энэ бол зөвхөн 42 дээр ард түмнийг зовоож байна. Ингээд саяын гишүүд болон нэмж орох гишүүд нь саналаа хэлээд Батнайрамдал гишүүн орно.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа авах чиглэлээр холбогдох салбарын мэргэжилтэн шинжээчдийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэг /С.Замира/-д зөвшөөрсүгэй.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн байна.

Ингээд тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор дэмжиж байгаа гишүүд нь Замира гишүүн ахалж байгаа. Ингээд тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Ингээд Ганзориг гишүүн горимын санал гаргая гэдэг санал гаргалаа.

П.Ганзориг: Ажиллахгүй байна. Би уг нь дэмжиж санал өгсөн. Тэгээд төхөөрөмж ажиллахгүй саналаа өгч чадсангүй. Тиймээс саяын саналыг хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулах горимын санал гаргаж байна.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн бас тэгж хэлсэн байгаа. Ингээд Ганзориг гишүүний саналын томьёоллоор санал хураалт. Эсвэл гараа өргөх юм уу. Жаргалсайхан гишүүн. Тэгээд л хэдүүлээ мафи болчихно шүү дээ. Хэдүүлээ мафид элссэн царайтай л болно доо. Яана аа.

Тэгэхдээ Онтре-г хойшлуулна гэдэг бол шударга л зүйл байх даа. Ингээд гараа өргөө гэдэг томьёоллоор түрүүнээс хойш бас 2 ч тохиолдол гарч байгаа шүү. Энэ техникийн саатал гарсан.

10.4-д гэмтэл саатал гарсан тохиолдолд санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл гарсан тохиолдолд ил санал хураалтыг явуулах учиртай гэсэн ийм заалтын дагуу дэгийн тухай хуулийн 10.4-өөр ил гар өргөж санал явуулъя гэдэг зарчмын санал гаргаж байна. Гишүүд маань ил гараар санал хураалтаа явуулъя. Харин тэрийгээ ил санал хураалтаар явах юм уу, үгүй юу. Нөгөө техникүүд гацаад байна гэдгийг бол 10.4 дээр заачихсан байгаа юм байна шүү. Ингээд саяын саналын томьёоллыг цуцалъя гэсэн саналын томьёоллоор илээр санал хураалт явуулъя. Ингээд нийт 14 гишүүн, Лүндэг гишүүн гараа өргөсөн байх тийм ээ. 14 гишүүнээр санал дэмжигдлээ. Одоо энэ саяынх чинь горимын санал байсан.

Одоо Замира гишүүнээр ахлуулсан “Ажлын хэсэг байгуулах” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт илээр явуулъя. 13 гишүүний саналаар, 14 гишүүний саналаар санал 100 хувь дэмжигдлээ.

17.24 цаг.

Ингээд дараагийн хэлэлцэх асуудал байгаа шүү гишүүд ээ.

“Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төслийн талаар Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсоно.

Батлут гишүүн санаачилж энийг бас тавьсан. Нэлээн удчихсан байгаа шүү. Батлут гишүүн зөвөөр ойлгоорой. Сайд нь яг хурал давхардаж байна гээд сая биечилж ирээд Батлут гишүүнтэй уулзаад, мэдээллүүдээ гишүүдэд өгөөд явсныг харгалзаад ингээд ажлын хэсгийг би танилцуулъя.

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Зам, тээврийн яамны Автотээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Мөнхнасан, Зам, тээврийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Мяндасмаа, Төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэгч “Ди Ди Эй Жи” компанийн захирал Ганзаяа ирсэн байна. “Ди Ди Эй Жи” компанийн төслийн менежер Балжинням ирсэн байна. Ингээд ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Мэдээллээ Төрийн нарийн бичгийн дарга Батболд 2 номерын микрофоныг өгсөн байна.

С.Батболд: Их Хурлын Байнгын хорооны эрхэм дарга, эрхэм гишүүд та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

““Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газраас металлурги, машин байгууламж, газрын тос, нүүрс боловсруулах болон химийн үйлдвэрийг хөгжүүлэн нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, улмаар хүнд үйлдвэрийн салбараас эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байгаа.

Энэ хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан үйлдвэр технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, металл хийц машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг кластерыг хөгжүүлэх зорилгоор Зам, тээврийн яам “Эрдэнэт” үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газар хамтран ажиллаж байгаа.

Энэ ажлын хүрээнд “Эрдэнэт машин” цогцолбор байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулсан. Энэ ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллагаар боловсруулаад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэр технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн ТЭЗҮ-д дүгнэлт өгөх зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлөөр хэлэлцүүлсэн байж байгаа. Энэ төслийн хүрээнд юу хийгдэх юм бэ гэхээр төслийн хүрээнд 1-10 тонн хүртэл даацтай ачааны автомашин, бүх төрлийн автобус, ачааны вагон үйлдвэрлэх боломжийг бид нар судлуулсан. Ингээд энэ “Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулагдсанаар ачааны автомашины зах зээлийн 5 хувь, ачааны хагас вагон болон автобусны зах зээлийн эрэлтийн 50 хувийг дотооддоо үйлдвэрлэх боломжтой гэсэн ийм дүгнэлт гарсан байж байгаа.

“Эрдэнэт машин” цогцолбор үйлдвэр байгуулах төсөл хэрэгжсэнээр нийт 1113 байнгын ажлын байр бий болж, Монгол Улсын ачаа тээврийн багтаамж, эрэлтийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээний ачааны вагон зорчигч тээвэрт үүсээд байгаа хүндрэлийг арилгахад томоохон түлхэц болно гэж үзэж байгаа.

Ингээд энэ ТЭЗҮ хийсэн талаар ТЭЗҮ-ийнхээ танилцуулгыг хийх юм. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Ганбаатар: Төрийн нарийн бичгийн дарга мэдээллийг өглөө. Ингээд үүнтэй холбогдуулж асуулт асуух гишүүд саналаа өгнө үү. Жангабыл гишүүн, Батлут гишүүн, Жаргалсайхан гишүүнээр тасаллаа. Ингээд Жангабыл гишүүн асуулт асууна.

Х.Жангабыл: Баярлалаа. Нэмүү өртөг шингэсэн “Эрдэнэт машин” үйлдвэр байгуулах гэж байгаа юм байна. Энд 3 бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм байна. Ачааны вагон, автобус, тэгээд ачааны машин. Тэгэхээр энд 708,9 тэрбум төгрөг зарцуулах юм байна. Ойр зуур 20 сая доллар л доо. Үүний 50 хувь нь бараг л ачааны вагон үйлдвэрлэхээр байна. 50 хувь нь автобусны үйлдвэр болон ачааны машин үйлдвэрлэх юм байна. Тэгэхээр энэ ачааны вагон үйлдвэрлэж байгаа нь саяын хил холболтын асуудлууд байж байгаа. Бид нар соёрхон баталсан. Хил дамнасан төмөр замын. Бидэнд ачааны вагон хэрэгтэй л дээ. Тэгээд одоо манай Монгол Улсад явж байгаа ачааны вагоны насжилт, хуучирчихсан. Ихэнх нь түрээсээр

явдаг. Тэгэхээр дотооддоо ачааны вагон үйлдвэрлэх нь маш чухал гэж үзэж байгаа. Тэгэхээр та нарын энэ төлөвлөсөн ачааны вагон чинь 100 хувь Монголын зах зээлийг хангаж чадах уу. Саяын насжилттай вагонуудыг үйлдвэрлэснээр сольж чадах уу гэсэн асуултууд байна. Дээрээс нь 708,9 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг “Эрдэнэт” үйлдвэр хийх юм уу, гадаадын санхүүжилт юм уу, дотоодын санхүүжилтээс гаргаж байгаа юм уу гэдэг асуулт байна. Тэгэхээр энэ төслийг хэрэгжүүлснээр хэр зэрэг Монгол Улсад ашигтай юм бол. Урьд өмнө нь бас троллейбус, цахилгаан автобус үйлдвэрлэж байсан. Тэр нь дампуураад сураггүй алга болсон. Тийм асуудал гарах юм биш үү. Энэ дээр тооцоо суулгаа хэр зэрэг хийсэн байна гэдэг асуултууд байна даа.

С.Ганбаатар: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Энэ бол бас Монголын хувьд бол стратегийн том асуудал шүү. Жижиг асуудал биш. Энэ шийдэгдвэл олон олон зүйл бас дагаж шийдэгдэхээр байгаа. Ингээд 2 номерт хариулт өгье.

С.Батболд: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Юуны түрүүн энд бид нар саяын хэлж байгаа 700 гаруй тэрбумыг улсын төсвөөс гаргах тухай бол ерөөсөө яриагүй байж байгаа. “Эрдэнэт машин” цогцолбор байгуулах ийм дэд бүтцийг Эрдэнэтэд бол байгуулаад, авто зам, төмөр зам, цахилгаан гээд бүх ийм дэд бүтцийг нь байгуулаад, ерөнхийдөө дуусах шатдаа орж байгаа юм. Бид нарын боловсруулсан автобус, энэ үйлдвэрүүд бол төр, хувийн хэвшлийн түншлэлээр гаднын хөрөнгө оруулалт, дотоодын хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөсөн.

ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавартаа гаднын 6-10 аж ахуйн нэгжид санал тавиад, судлаад ир гэсэн. Ингээд Хятад, Япон, Герман, Узбек гэсэн ийм орнуудын машин үйлдвэрлэгч нартай уулзаад, Монголд ийм машин угсрах талаар хамтарч ажиллах уу гэдэг санал тавьсан. Бүгдээрээ дэмжиж, хамтарч ажиллая гэдэг асуудал тавьж байгаа юм. Эхнээсээ бид нар яаж хөрөнгөө оруулах вэ, хэзээ эхэлж болох вэ гэдэг хүртэл асуудал тавьж байгаа.

Ингээд энэ 3 үйлдвэр бол тус тусдаа үе шаттайгаар бас хийх боломжтой байгаа юм. Сүүлийн тэр асуусан ачааны вагоны үйлдвэр бол жилдээ бид нар 500 орчим вагон үйлдвэрлэх, ачааны хагас вагон үйлдвэрлэх ийм хүчин чадалтайгаар тооцож байгаа. Өнөөдөр манайд нийт бүртгэлтэй 11 мянга орчим ийм хөдлөх бүрэлдэхүүн байгаа. Тэрний 6600 орчим нь бид нарын сонирхож байгаа тавцанд ийм вагон байгаа. Ингээд яг өнөөдөр гэхэд одоо Улаанбаатар төмөр зам нийтдээ 1200 вагон шинэчлэх ийм шаардлагатай. Энэ вагонуудыг бол ОХУ-аас худалдаж авдаг үнэ нь өнөөдрийн байдлаар 1 вагон бол 260 орчим сая төгрөгийн үнэтэй байгаа. Дотоодод үйлдвэрлэснээрээ бид нар эдийн засгийн үр ашгийн талаар боломжтой бол манай энэ зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ТЭЗҮ хийсэн багаас товчхон эдийн засгийн үр ашгийг слайд дээр бид нар үзүүлэх боломжтой байгаа юм.

С.Ганбаатар: Дэгийн тухай хуулиа бариад, маш товчхон танилцуулаарай. Ингээд 5 номерын микрофон.

Д.Ганзаяа: Эрхэм гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Ди Ди Эй Жи” компанийн захирал Ганзаяа байна. Автобус, ачааны машин, ачааны вагон үйлдвэрлэх төслийн ТЭЗҮ-ийн үндсэн үзүүлэлтүүдийг та бүхэндээ маш товчхон танилцуулъя.

Ачааны хагас вагоны үйлдвэр байгуулахад нийтдээ 357 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай. Автобусны үйлдвэр байгуулахад 158, ачааны автомашины үйлдвэр байгуулахад 193 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, нийтдээ 708,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай.

Цаг бага байгаа учраас төслийн нийт үр дүнгүүдийг танилцуулъя. Төслийн эдийн засгийн тооцоог 10 жилийн хугацаагаар боловсруулсан. Нийтдээ 10 жилийн хугацаанд 2,5 тэрбум ам.долларын орлого олж, нийтдээ 328,5 сая ам.долларын цэвэр ашигтай ажиллах ийм үйлдвэр байгаа. Ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэн 51,3 сая ам.доллар, өгөөжийн дотоод норм нь 14,3 хувьтай. Хөрөнгө оруулалтын зардлыг 5 жилийн хугацаанд нөхсөн. Орлогоор тооцсон ашигт ажиллагааны түвшин 18,9 хувьтай, зардлаар тооцсон ашигт ажиллагааны түвшин 22,7 хувьтай гарсан ийм төсөл байгаа.

Нэмээд хэлэхэд автобус жилд 500 ширхэг, ачааны хагас вагоныг жилд 500 ширхэг, 1-10 тонны даацтай ачааны автомашиныг 10 мянган ширхэг үйлдвэрлэхээр тусгасан байгаа. Түрүүн Төрийн нарийн бичгийн дарга хэлсэн. Гаднын үйлдвэрүүдийн туршлагыг явж үзэж судалж, санал тавиад ирсэн. Гаднын үйлдвэрийн туршлага бол юу байдаг вэ гэхээр олон тоогоор үйлдвэрлэх нь өөрөө автомашин машин үйлдвэрлэлийн хамгийн өгөөж өндөртэй байдаг хувилбар гэж ойлгож болно.

Ачааны машин, автобус бол манай улсын нийгэм, эдийн засагт нэн тэргүүнд шаардлагатай түгжрэлийг бууруулах, ногоон эдийн засгийг дэмжих, ачаа эргэлт, бараа тээврийнхээ асуудлыг шийдэхэд нэн чухал ач холбогдолтой дотоодын чухал хэрэгсэл гэж үзээд, энэ ТЭЗҮ-тэй энэ 2 бүтээгдэхүүнийг бол сонгож оруулж ирсэн. Тэгэхдээ бол ашиггүй төсөл биш. 3 үйлдвэр маань гурвуулаа ашигтай ажиллах төсөл байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Энийг бол дэмжиж байгаа шүү дээ. Тэгээд ингээд үлгэр яриад, фантаз яриад, маш ашигтай л гэж яриад байх юм. Бүгд ойлгож байгаа. Энэ чинь бас харин материал нь овоо эрт ирсэн шүү. Юун дээр болохгүй байна, яагаад энэ олон жил гацаад байгаа юм бэ гэдгийг ярих гэж Байнгын хороо хуралдаж байгаа юм шүү дээ уг нь. Тулга гишүүний нэрийг бас оруулчхаарай.

Ингээд Батлут гишүүн бол энийг анхнаас нь хөөцөлдөж чармайж явсан. Тэгээд 1 л бүтэхгүй байгаа учраас асуулт асуугаад байгаа шүү дээ. Батлут гишүүн.

Д.Батлут: Оройн мэнд хүргэе. Манай Эрдэнэт хоттой, Эрдэнэт үйлдвэртэй холбоотой асуудал. Монгол Улсад бас томоохон өгөөж өгөх төсөл гэж уг нь би хардаг юм. Олон жил ярьж байгаа. Тэгээд боломж нь бас манай Эрдэнэт үйлдвэрийн Засвар механикийн заводыг түшиглэсэн техник технологийн шинэчлэлийг хийх, үйлдвэр технологийн паркийн хүрээнд энэ асуудлыг шийдвэрлэх боломж байна гээд их олон жил ярьж байгаа. Германы хамтын ажиллагаа ч гэдэг юм уу, Герман, Монгол Улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээрт ч гэсэн 1 удаа орж байсан санагдаж байна.

Хамгийн гол нь бас ТЭЗҮ боловсруулагдаад дуусчихсан байгаа нь их авууштай л юм. Эхний ээлжид ямар ч байсан 1 алхчихжээ гэж харж байгаа. Тэгээд энэ хэзээ дууссан ТЭЗҮ вэ. Хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдэх гэсээр байтал

энд байгаа үзүүлэлтүүд нь бас тоо хэмжүүрүүд нь бас өөрчлөлт орох болов уу гэдэг дээр ямар бодол байдаг юм бол.

3 чиглэлийн үйл ажиллагаа гэж байна. 1 дүгээрт нь хагас вагон, автобус, тээврийн машин. Манайд бас хөдөө аж ахуйн салбарын автомашин, тоног төхөөрөмжүүд ихээр шаардлагатай байдаг. Ер нь энэ тал дээр ТЭЗҮ боловсруулсан зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа компани ямар санаа бодолтой байсан юм бэ. Энэ мэдээж Монгол Улсын “Алсын хараа 2050” хөтөлбөр, хүнд үйлдвэрлэлийн хөгжүүлэх хөтөлбөртэй холбоотой уялдаж гарч байгаа асуудал. Ойлгомжтой. Тэгээд энэ дотор ямар асуудлыг агуулж, тэр дотроо хөдөө аж ахуйн салбарын автомашин, тоног төхөөрөмжтэй холбоотой асуудлыг ер нь оруулна гэж бодож байгаа юу эсвэл хасчихсан юм уу.

Хууль, эрх зүйн орчин нь өөрөө энэ төсөл хэрэгжээд 1 ёсондоо машин үйлдвэрлэл ингээд явлаа гэхэд бид нарт хууль, эрх зүйн орчин нь яг хангалттай байгаа юу. Энийг бид цаашдаа хэрхэн анхаарч үзэх ёстой юм бэ гэдэг дээр надад нэг хариулт өгөөч.

Хөрөнгө оруулалтын асуудлууд мэдээж Эрдэнэт үйлдвэрийн бас хувийн хэвшлийн гадна, дотнын хөрөнгө оруулалтууд л гэж байна л даа. Үндсэндээ 200 орчим сая доллар байх шиг байгаа юм. Тэгээд та бүхний тайлан мэдээлэл дээр болохоор тухайлах юм бол Автобусны үйлдвэрлэлийг 3 улсын 3 аж ахуйн нэгжтэй ярьсан юм байна. Тэд нар нь бас орж ирж ажиллахад бэлэн гэдгээ илэрхийлсэн байна. 2025 оны 1 дүгээр сард зохион байгуулсан “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит компани олон улсад үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа сэдэвт уулзалт хийсэн юм байна. Тэгээд эндээс яг үр дүн гарсан уу. Одоо яг үнэндээ гаднын хөрөнгө оруулалт нь автобус дээр, вагон дээр, тэр машин дээр ийм ийм аж ахуйн нэгжүүд шууд хөрөнгө оруулалт хийнэ гээд гэрээ контрактын шатдаа ч юм уу явж байгаа, ахиц гарсан зүйл байгаа юм уу гэдэг дээр надад бас хариулт өгөөч. Баярлалаа.

С.Ганбаатар: Төрийн нарийн бичгийн дарга 2 номерт хариулт өгье.

С.Батболд: Батлут гишүүний асуултад хариулъя. ТЭЗҮ бол хийгээд хэлэлцэгдээд дууссан. Ер нь энэ үйлдвэрийн ажил бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны чиг үүрэгт хамаарах ажил байгаа. Энэ бол хүнд үйлдвэрийн салбарт хамаарах ажил. Яг манай яаманд шууд хамаарах ажил бол биш. Бид яах вэ, нөгөө хэрэглэгч гэдэг талаасаа санаачилга гаргаад явж байгаа юм. Ер нь манай энэ ТЭЗҮ боловсруулсан компанийн тооцоогоор бол энэ үйлдвэрүүдийг байгуулахад 36 шаардлагатай гэдэг ийм тооцоо гарсан байж байгаа. Бид энийг одоогоор ямар нэгэн байдлаар гэрээ контракт хийсэн юм бол байхгүй байгаа. Энэ дээр бид нар шийдвэр гаргуулах гээд хүлээж байгаа юм. Анх бол ер нь бид нарын санаа Эрдэнэт үйлдвэртэй хамтраад ийм үйлдвэр байгуулах гэдэг ийм чиглэл явсан юм. Тэгээд сүүлдээ “Эрдэнэт” үйлдвэр бол бид нар одоогоор хөрөнгө оруулж чадахгүй гэсэн учраас хувийн хэвшил гэдэг рүү явсан. Ингээд энэ 4 сарын 28-нд Булганд болох Хангайн бүсийн чуулганд бид нар энийг мега төсөл болгож, Засгийн газраар танилцуулаад, шийдвэр гаргуулах гээд материалаа өгчихсөн байгаа юм. Энэ дээр яг хувийн хэвшил оруулчхаж болж байна уу. Яг оруул гэдэг ийм шийдвэрийг нь гаргуулах гээд ингээд байж байгаа юм.

Өнөөдөр Монгол Улсад 260-аад төмөрлөг машин механизмын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд байгаа юм. Өнөөдөр Монголын ийм залуучууд 23 жил зүгээр л чимээгүй, өөрсдийгөө нэг их рекламдаж сурталчлаад байхгүй, Японоос өндөр чанарын ган оруулж ирээд, Японы машины эд анги үйлдвэрлээд 24 цагаар ажиллаад, буцаагаад Япон руу гаргаад байж байгаа ийм туршлага байгаа. Өнөөдөр ч гэсэн ажиллаад явж байгаа.

Тэгээд түрүүн бас Жангабыл гишүүн асуусан. Өмнө та нар үйлдвэрлэж байсан угсарч байсан гэдэг асуулт асуусан. Тэгэхээр өмнө бид нар ийм инженерүүдийн санаачилгыг дэмжээд, дотооддоо гаргах гэж үзсэн. Үнэхээрийн бас бараагүй. Одоо бид нар эхнээсээ ингээд шүүхдэлцээд явж байгаа. Монгол машин цахилгаан тээвэр гээд бүгдээрээ үйлдвэрлэсэн. Ингээд ашиглалтын шаардлага хангахгүй, 1-2 жил ашиглаад болохгүй байсан учраас одоо бол энэ ТЭЗҮ дээр бид нар дотооддоо өөрсдөө нэг их юм үйлдвэрлээд хэрэг байхгүй. Гаднын тэр брэндийг Монголд угсрах чиглэлээр л ажиллаж байгаа.

Эрх зүйн орчны хувьд бол ерөнхийдөө бид бас 10-аад жилийн өмнөөс бүрдүүлээд явж байгаа. Жишээ нь энэ дээр Монголд үйлдвэрлэсэн машины дэлхийн үйлдвэрлэгчийн таних тэмдэг гэдэг ийм таних тэмдгийг олон улсын инженерийн холбооноос өгдөг. Энийг бид нар жишээ нь 2012 онд олон улсын инженерийн холбооноос авсан. Энэ бол олон улсын стандартад орчихсон MU9 гэдэг кодыг олон улсын инженерийн холбооноос өгсөн. Ингээд манай бүртгэлийн системд Монголд үйлдвэрлэсэн машины аюулгүй байдлыг ингэж туршина, ийм бичиг баримтаар бүртгэнэ энэ тэр гээд эрх зүйн баримтууд ерөнхийдөө бол боломжтой гэж үзэж байгаа.

С.Ганбаатар: Ер нь бол үйлс пад харлачихсан л гэсэн юм ярьж байна шүү дээ. Батлут гишүүн тодруулах нь зөв байх.

Д.Батлут: Та бүхний тайлан дээр гарсан байна л даа. 3 улсын 3 аж ахуйн нэгж хөрөнгө оруулалт хийгээд, хамтраад ажиллахад бэлэн гэсэн. Тэгээд энэ дээр ямар нэгэн санаачилга гаргаад, тэр өрсөлдөөн зохион байгуулж хамтран ажиллах тендер зохион байгуулаад сонголт хийж байгаа зүйл байгаа юм уу. Байхгүй бол энэ хөрөнгө оруулалтын хүрээнд уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс 2025 оны 1 сард бас хөрөнгө оруулалтын чиглэлийн үйл ажиллагаа уулзалт зохион байгуулна гэсэн. Хэрвээ зохион байгуулсан бол ямар үр дүн гарсан юм бол гэдэг л асуултыг би асуугаад байна л даа. Тэгээд энэ ажил маань зөвхөн ТЭЗҮ боловсруулаад л зогсчихоод байгаа юм уу. Уг нь боломжтой гэсэн илэрхийллүүд байгаад байна. Тийм ээ. Гаднын хөрөнгө оруулалтынхан. Тэгээд дээрээс нь ийм уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах гэж төлөвлөж байгаа гэхихсэн л байна л даа. Аль уже өнгөрчихсөн байхгүй юу. Үүнээс үр дүн гарсан юм уу гэдэг асуулт дээр хариулт авах гээд байгаа юм.

С.Ганбаатар: Төрийн нарийн бичгийн дарга 2 номерт хариулна. Ер нь бол уул уурхайн яам хариуцна шүү л гэж байна. Зам, тээврийн яам харин ч идэвхтэй явж байгаа юм байна. Ингээд асуултад хариулт өгье.

С.Батболд: Батлут гишүүний асуултад хариулъя. Бид нар яг түрүүн миний хэлээд байгаа уул уурхайн яаманд бас хамааралтай ажил байгаа гээд уул уурхайн яамтай бас хамтраад ажиллаж байгаа. Одоо нөгөө Засгийн газрын хуралдаанд

оруулаад яг хувийн хэвшил оруулж болно гэдэг шийдвэрийг л гаргуулах гээд байгаа юм. Түүнээс өнөөдөр ямар нэгэн байдлаар бид нар гэрээ хэлэлцээр хийх тийм бас эрх байхгүй учраас Засгийн газрын шийдвэр гаргуулах гээд энэ 4 сарын 28-нд засгаар оруулах гэж байгаа юм.

Эрдэнэтэд болсон арга хэмжээ дээр бол сонирхсон аж ахуйн нэгжүүд дотооддоо ийм чиглэлээр үйлдвэр явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг танилцуулах, энийг хэлэлцүүлэх, санал авах ийм арга хэмжээ явсан. Бүгд бол хэрвээ байгуулдаг юм бол манайх ийм даавуу, ийм хуванцар, ийм төмөр нийлүүлэх, хийх боломжтой гэдэг саналуудаа илэрхийлчхээд байж байгаа. Тэрнээс цаашаа бол бид нар яг хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээр бол эхлээгүй байгаа.

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн асуулт асууж.

Д.Жаргалсайхан: Энийг дэмжиж байна. Бидний хувьд бол өөрсдөө дотооддоо импортыг орлох бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх шаардлагатай машин механизм. Гэхдээ энэ дээр гайхаад байна л даа. “Эрдэнэт” үйлдвэр хэрэгжүүлж байгаа төсөл юм уу. Тэгээд эхнийхээ албан бичиг дээр “Эрдэнэт” үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газартай хамтран хэрэгжүүлж байна гээд ингээд албан бичиг ирчихсэн байгаа юм. Тэгснээ сая бол Эрдэнэт үйлдвэр бол хөрөнгө оруулалт хийхгүй гэсэн юм гээд. Тэгээд энэ яг хаанаас урган гарсан төсөл юм бэ. Хэн хэрэгжүүлж байгаа төсөл юм бэ. Тэгээд энэ яг төрийн ямар дэмжлэг хүсэж байгаа юм бэ. Асуулт бол тодорхой байгаа биз. Хаанаас урган гарсан төсөл юм. Яг “Эрдэнэт” үйлдвэрээс гарсан төсөл юм уу, эсвэл хувийн хэвшлээс гарч ирсэн төсөл юм уу. Тэгээд яагаад ямар шатанд “Эрдэнэт” үйлдвэр хэрэгжүүлж эхлээд байна гэхихсэн юм бэ. Энэ “Эрдэнэт” үйлдвэр өөрөө ийм шийдвэр гаргасан юм уу. Одоо тэгээд юу нь болохоо байчихаад ингээд орж ирж байгаа юм бэ. Одоогийн ярьж байгаагаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулмаар байна. 14 мега төсөлд оруулмаар байна. Ингээд байгаа нь ямар учиртай юм. Төсвөөс мөнгө хүсээд байгаа юм уу. Ямар дэмжлэг хүсээд байгаа юм бэ гэсэн ийм асуултууд байна. Нэмж асууна.

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн асуулт асууж байна. Энэ бол нэлээн урт хугацаанд яригдсан зүйл шүү. Бас тэгээд ГОК бол дэмжиж байх ёстой доо. Тэрийг Төрийн нарийн бичгийн дарга 2 номерт хариулт өгнө үү.

С.Батболд: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Санаачилга бол ковидын үеэр манай яамнаас гаргасан. “Эрдэнэт” үйлдвэрийн тухайн үеийн захирал байсан Бадамсүрэн захиралд бид нар тавиад, ер нь танайд ийм механик засварын завод бас нэлээн өндөр хэмжээнд байна. Энийг бас ашиглая. Манай УБТЗ, МИАТ компани хувийн хэвшил гээд маш олон газруудад ийм боломжууд байна. Бүгдээрээ нэгдэж ажиллая гэдэг санаачилгыг манай яамнаас гаргасан. Ингээд “Эрдэнэт” үйлдвэр бол энэ машин механизмынхаа заводыг өргөжүүлэх гэдэг ТЭЗҮ хийлгэж эхэлсэн юм. Энэ дээр нь бид нар машин угсрах гэдгийг нэмье гэдэг саналыг тавиад, тэгээд “Эрдэнэт” үйлдвэр энэ ТЭЗҮ хийх санхүүжилтийг гаргасан юм. Ингээд явж байгаад тухайн үед бол бид нар танайх ингээд хөрөнгө оруулаад хамтарчхаач, сая жишээ нь ковидын үеэр 1 их наяд төгрөгийг цахилгааны мөнгөнд зарчихсан. Энэ бол бид нарын хүсээд байгаа үйлдвэр барих хэмжээний мөнгө байна. Цаашдаа энэ Эрдэнэтийн материаллаг баазыг ашиглаж, бид нар энэ үйлдвэрлэлийг хөгжүүлье гэдэг саналыг тавиад ингээд явж байсан.

Эрдэнэт ТЭЗҮ хийгээд үзэхээр бид нар энэ хөрөнгө оруулалтын асуудлыг ярьж гээд, ямар ч байсан ТЭЗҮ-ээ хийлгэсэн. Ингээд Эрдэнэт үйлдвэрийн бас 2025 он, 2026 он, 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнүүдийг үзээд маш олон “Эрдэнэт” үйлдвэр өөрөө бас ийм бүтээн байгуулалтын ажлууд хийх шаардлагатай байгаад байгаа учраас одоогоор бид нар бол хөрөнгө оруулалт хийж чадахааргүй юм байна гэдэг ийм шийдвэрийг энэ 2024 оны төгсгөл рүү өгсөн юм. Тийм учраас бид нар хувийн хэвшилд, тэгээд Засгийн газарт ямар шийдвэр хүсээд байгаа юм бэ гэхээр энийг та нар хөрөнгө оруулагчтай энэ дээр яриад энийг шийдье гэдэг л ийм шийдвэр гарчихвал энэ сонирхож байгаа аж ахуйн нэгжүүдтэй яриад, шалгаруулалт явуулаад хийчих ийм боломжтой л гэж үзэж байгаа. Тийм учраас бид нар Засгийн газраас энийг хувийн хэвшилтэй яриа хэлэлцээ хийж болно гэдэг шийдвэр л хүсэж байгаа юм. Ийм байдлаар оруулж байгаа юм.

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн тодруулж асууя.

Д.Жаргалсайхан: Ингээд энэ газар дээр нэлээн асуудлууд гарч ирж байна шүү дээ. “Эрдэнэт” үйлдвэр өөрийн эзэмшлийн 800 га байсан уу. Тэгээд бусад Баян-Өндөр сумын, Жаргалант сумын ч гэхихсэн байх шиг байна. Тэгээд энэ олон га газрууд хувийн хэвшил рүү шууд шилжих үү. Хувийн хэвшилд хөрөнгө оруулалт хийгээд явахад төрийн оролцоо нь яаж байх юм. Тэгээд дээрээс нь “Эрдэнэт” үйлдвэрийн саяын тэр засварын төвтэй түшиглэж байна гэж байна шүү дээ. Тэгээд энэ оролцоонуудаа яаж харж байгаа юм та хэд.

С.Ганбаатар: Асуултад Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

С.Батболд: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Энэ газар бол аж ахуйн нэгжүүдтэй хамтарч ажиллалаа гээд энэ аж ахуйн нэгжүүд рүү шилжих боломж байхгүй. Энэ бол төрийн газар. Төрөөс бол дэмжлэг үзүүлж байгаа нь “Эрдэнэт” үйлдвэр бол саяын хэлсэн дэд бүтцүүдийг нь л шийдэж өгч байгаа. Зам, төмөр зам, цахилгаан гэдэг асуудлыг шийдэж өгч байгаа. Тэгээд энэ дээр энэ төмөрлөг машин механизмын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэд бүтцийг нь шийдээд өгчихсөн учраас одоо яг шууд үйлдвэр байгуулах ийм хөрөнгө оруулалт хийгээд явах боломж бол бүрдчихээд байгаа юм л гэсэн үг. Түүнээс газар нь хувийн хэвшилд өгөх ийм боломж бол байхгүй.

С.Ганбаатар: Төрийн нарийн бичгийн дарга Батболд бас тодорхой хариулт өглөө. Буяагийн Тулга гишүүн асуулт асууна.

Б.Тулга: Та бүгдийнхээ оройн амгаланг эрье. Миний асуулт ерөнхийдөө Жаргалсайхан гишүүний асуулттай нэлээн давхацлаа. Өөрөөр хэлбэл бас анхнаасаа үйлдвэр гэж явж байгаад сүүлдээ гээд төрийн нарийн бас нэлээн дэлгэрэнгүй сайн хариуллаа. Ер нь зүгээр дахиад тодруулаад асуухад нэгэнт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт хайж байгаа бол Их Хурал, Байнгын хороо, Засгийн газар дээрээс ямар зөвшөөрөл авах гээд байна. Би бол зарчмын хувьд энэ үйлдвэрлэл байгаасай гэдэг дээр бол 100 хувь санал нэг байна. Бас та хэдийн энэ товч танилцуулга дээр бас тодорхой судалгаанууд хийчихсэн, ТЭЗҮ хийчихсэн, бас нэг ийм итгэл үнэмшил байгаа бол явах нь 1 дүгээрт зөв. Зүгээр гадагшаа экспортолно гэдэг дээр юу л бол. Тэр жоохон юу харагдаж байна. Узбекистантай хамтарна гэсэн байна лээ. Тэгэхлээр Узбекистан чинь зүгээр сая юунаас хайгаад үзэхэд бол машин үйлдвэрлэдэг улсуудаасаа 27, 28 дээр явдаг л улс байна шүү дээ. Тэгээд энийгээ бас та бүхэн анхаараарай. Тэд нартай нийлж

ачааны машин үйлдвэрлэнэ гэдэг бол олон улсын зах зээл дээр, манай дотоодын зах зээл дээр ч гэсэн явах нь юу л бол. Энийг бас нэг хармаар л харагдаж байна. Мэдээж хамгийн том машины үйлдвэрлэгч бол яах аргагүй Хятад. Дэлхийн зах зээл дээр цоо шинээр гарч ирж байгаа өөрөө. Та бүхэн мэдээлэл харсан бол энэ тарифын дайнаас болоод Хятадын аль хэдийн бусад улсууд дээр угсрах үйлдвэр байгуулсан үйлдвэрүүдээ хааж байгаа гэдэг мэдээлэл бас байгаад байгаа. Тэгэхээр 4, 5 жилийн өмнө хийсэн ТЭЗҮ маань өнөөгийн нөхцөл байдалтай, тэгээд өнөөдрөөс хойш ирээдүйд бас бий болох нөхцөл байдалтай уялдаж байгаа эсэхийг нь 1 дүгээрт шалгаарай гэж зүгээр сануулах гэсэн юм. Асуулт бол түрүүнд би асуулаа. Яг засгаас гэдэг юм уу, эндээс ямар шийдвэр гаргаж байж өөрөөр хэлбэл хүлээлт байгаа юм бэ гэдгийг л тодруулж асуух гэсэн юм. Тэгээд Батболд дарга бол бас хэллээ. Өөрсдөө бас дэмжээд, манай Байнгын хороо руу оруулж ирж байна. Тэрнээс Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны асуудал л даа. Тэгэхээр бид бол үйлдвэрлэл барихыг дэмжих нь мэдээж зөв байлгүй яах вэ. Тэгэхдээ энэ дээр бас яг шийдвэрээ ийм шийдвэр гаргуулчихвал бас бидэнд хөрөнгө босгоход гэдэг юм уу, хөрөнгө оруулагч татахад хэрэгтэй байгаа юм гэдэг тал дээр тодорхой хариулт өгөөч гэж хүсэж байна.

С.Ганбаатар: Батболд Төрийн нарийн бичгийн дарга товчхон хариулна уу. Яг ямар төсөөлөл байгаа юм бэ.

С.Батболд: Тулга гишүүний асуултад хариулъя. Саяын Жаргалсайхан гишүүний асууж байгаа тэр том газар дээр бол бүгдэд нь бид нар юм хийх гээгүй. Тэр бол үйлдвэр технологийн парк гээд тусдаа явж байгаа. Үүний нэг хэсэгт нь л ийм машин үйлдвэрлэл гэдэг юмаар бид нар тооцсон юм.

Засгийн газраас түрүүний хэлдэг бид нар энэ үйлдвэрлэл дээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгээд та нар явж болно л гэдэг зөвхөн энэ шийдвэрийг л хүсэж байгаа. Энэ байдлаар оруулах гэж байгаа.

Узбекстантай бол бид нар хамтарч машин үйлдвэрлэх тухай одоогоор бол яриагүй. Зүгээр Узбекистан бол гаднын 6 орны машиныг үйлдвэрлээд, гадагшаа экспортод гаргаад байгаа юм. Эхнийх нь жишээ нь Америкийн Шевролетийг Узбекистан угсраад, Монгол руу аль хэзээний оруулаад эхэлчихсэн. Эд нар бол 2027 оноос Монголд Шевролетийг угсаръя гээд өөрсдөө санал тавиад явж байгаа гэх мэтчилэн ийм сонирхсон аж ахуйн нэгжүүд бол байгаа. Түүнээс одоогоор бид нар аль ч үйлдвэртэй хамтрах тухай ярьж эхлээгүй. ТЭЗҮ хийхдээ л асууж судалж сонирхож байна уу гэсэн. Хятадын үйлдвэрүүд бол бүр манайд зориулаад өөрсдөө тооцоо судалгаа хийчихсэн юмнууд яваад байгаа юм. Бид нар тэрийг нь одоогоор авахгүй байгаад байна. Хятадаас том ачааны машин жилдээ 5-8 мянгыг Орос руу гаргаад байгаа юм. Эд нар бол энийг бид нар танайд угсрах боломжтой гээд тэр Пао-ийн үйлдвэр энэ тэр бол өөрсдөө ийм юм яриад яваад байгаа юм. Бид нар бас шууд өөрсдөө мэдээж яриа хэлэлцээр хийж чадахгүй ингээд Засгийнхаа шийдвэрийг авч байгаад явъя гэсэн байдалтай байж байгаа юм.

С.Ганбаатар: Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Байнгын хороо дээр олон асуудлуудыг ярьж орж ирдэг боловч яг энэ асуудал бол бас бүтчихээр, дархан хүн бурхан ухаантай гэгчээр бид нар хийж болохоор юмнуудыг оруулж ирлээ. Тэгээд гацаа тээгээс гарахын төлөө гишүүд маань бас дэмжиж Батлут гишүүн ээ, бас эрчимжүүлж ажиллана гэдэгт итгэлтэй байна. Мэдээлэл сонслоо.

17.55 цаг.

Одоо 1 асуудал үлдсэн. Ажлын хэсгийн удирдамж батлах асуудал.

Өнгөрсөн хуралдаанаар Ганзориг гишүүнээр ахлуулж усны хэрэглээ, аж үйлдвэр үйлдвэрлэлийн хэрэглээний асуудал дээр бас бид хяналт тавья. Энэ дээр бас юу болж байна гэдэг ийм ажлын хэсэг гарсан байгаа. Ажлын хэсгийнхээ удирдамжийг энэ удаад батална.

Ингээд ажлын хэсгийн удирдамжийг би та бүхэнд танилцуулъя. Тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь.

1.Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 6 дугаар тогтоолоор байгуулагдсан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдаж байгаа усны нөөцийн зөв зохистой ашиглалт, усны ашиглах боломжит нөөц, ус хэрэглээний хэтийн төлөв, ус ашигласны болон ус бохирдуулсны үнэ, төлбөр, үр дүнгийн талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж хэлэлцүүлэх, мөн тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Улсын Их Хурлын гишүүн Ажлын хэсгийн ахлагч П.Ганзоригт үүрэг болгосугай.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм тогтоолын төслийг та бүхэнд танилцууллаа. Бичгээр тараасан байгаа.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Ингээд тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн удирдамж батлагдлаа.

Өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ амжилт хүсье. Та бүхэндээ баярлалаа. Ингээд өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

17.57 цаг.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ